Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2012. 03 сар. №004 (014) www.mongolianeconomy.mn

Тиймээ, бид Монголын Economist болох зорилготой

Төсвийн зарцуулалтад Дулмаа анхаарна

Засаглал нь нээлттэй, ил тод, олонхийн оролцоотой оронд хөгжил ирдэг

БСБ МЕБЕЛЬ

Оффисын Цогц Шийдэл!

Таны ажлын өрөөнд Сингапур, Малайз улсад үйлдвэрлэсэн сайн чанарын тавилгыг
-Өргөн сонголт,
-Боломжийн үнэ,
-Үнэгүй хүргэлт, угсралтын хамт санал болгож байна.

YU 8092

UNIQ SERIES

БСБ АМАН ХУУР МЕГАСТОР
Баянзүрх дүүрэг, 13 хороолол
Аман Хуур Хотхоны 1 давхарт
Утас: 77020019, 99085902
И-мэйл: amankhuur_fur@bsb.mn

БСБ МИШЭЭЛ
Хан-Уул дүүрэг Мишээл
төв С-2, С-5 павильон
Утас: 70110441
И-мэйл: elba_misheel@bsb.mn

BSB

Та 30+ суудалтай онгоцны төрлүүдээс Сааб 340 онгоц хамгийн олон тоогоор борлуулагдсан гэдгийг мэдэх үү?

eznis airways

Изинис Эйрвэйз компани нь зорчигчдын болон онгоцны тоогоороо тэргүүлэх бүс нутгийн авиа компани юм. Бид хамгийн олон чиглэлд хамгийн өндөр давтамжтайгаар нислэг үйлддэг. Дэлхийн шилдэг онгоцны засвар үйлчилгээ үзүүлдэг компаниудын нэг болох **Луфтханза Техник** компанитай хамтран ажиллаж нислэгийн аюулгүй байдлыг хангадгаараа бид бахархадаг. Мөн дэлхийн хамгийн том авиа компаниудын нэг Япон улсын **АНА** компанитай хамтран олон улсын шилдэг иргэний агаарын тээврийн туршлагыг монголд нэвтрүүлэхээр ажиллаж байгаагаараа бид бахархадаг.

Тууллах тэнгэр цэлмэг
Тухлах зорчигч амгалан

8 Зовхис Билдинг, 1-р давхар, Сөүлийн гудамж 21, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот 14251, Монгол Улс
Утас: +(976-11) 333311, Факс: +(976-11) 331514, И-мэйл: info@eznis.com
www.eznisairways.com

333311
ТИЙЗ ЗАХИАЛАХ УТАС

Хүсэл, боломж нэгдэхийн цагт...

Das Auto.

New Tiguan 2012

Хэрэгцээ боломжоо ухаалгаар мэдэрч, амьдралаа үргэлж аз жаргалаар бялхуулж байдаг тэр л эрхэмсэг Таны хүсэл боломж нэгдэх тэр л ертөнцөд Фольксваген Тигуан шинэчлэгдэн мэндэллээ.

Эрхэм Таны төгс мэдрэмж, ухаалаг хэрэгцээг тодорхойлно

Бусдаас ухаалаг имидж төрхөөрөө ялгарахыг хүссэн хэн бүхний сонгох сонголт яах аргагүй Tiguan юм.

Түүний шинэчлэгдсэн хувилбар гадаад дизайн, нэмэлт чамин тоноглолууд мөн бартааг туулах зориулалтаараа дэлхийн олон олон хэрэглэгчдийг байлдан дагуулсаар байна.

Гэрэл цацруулагч лед бүхий урд, хойд гэрлүүд, шинэчлэгдсэн дизайн бүхий урд гупер, хажуу хормой зэргийг цогцоор нь харахад жинхэнэ Герман дизайнерын чансаатай бүтээл гэмээр.

Хамгийн хэмнэлттэй хөдөлгүүр бүхий 100 километрт 10-12 литр шатахуун зарцуулалт, 7 шаталбарт DSG буюу автомат, механик хосолсон хурдны хайрцаг, зогсоолд өөрийгөө байршуулах автомат систем, 4 талын зайн мэдрэгчийн систем, гэрэл шилжүүлэгч автомат систем зэрэг тоноглолууд нь энэхүү загварыг ангилалдаа тэргүүлэгч болгож чадсан юм.

Жишээ нь **гэрэл шилжүүлэгч автомат систем** нь өөдөөс болон урдаа явж буй машиныг гэрлээрээ гялбуулахгүй байх үүднээс өөрөө мэдэрч гэрлээ автоматаар шилжүүлдэг систем юм.

Таны гэр бүлийн аюулгүй байдал хамгаас чухал

Бидний амьдралын утга учир, аз жаргал, баяр баясал яах аргагүй гэр бүл маань байдаг. Гэр бүлийн тань аюулгүй байдал, тав тух, эдийн засгийн хэмнэлт эдгээр бүгд шинэчлэгдсэн Тигуанд цогцолжээ.

EuroNCAP /**N**ew **C**ar **A**ssessment **P**rogram/ нь Олон Улсад шинээр худалдаалагдаж буй авто машины гэнэтийн ослын үе дэхь аюулгүй байдал , хамгаалах хэрэгслийн ажиллагааг үнэлдэг байгууллага юм. Энэхүү байгууллагыг үнэлгээгээр шинэчлэгдсэн Тигуан нь зорчигч, хүүхдийн суудлын аюулгүй байдал, явган зорчигчид нөлөөлөх байдал зэрэг категориудад нийлбэр дүнгээр хамгийн дээд оноо буюу 5 оноо авч ангилалдаа **хамгийн найдвартай авто машин гэсэн** алдрын титмийг зүүжээ. Түүний ABS (шарвалтын эсрэг функц), ESP (автомат тэнцвэржүүлэгч программ), Auto Hold (өгсүүр зам, гэрлэн дохион дээр зогсох үеийн автомат цоожлогч), салхин хөргөлттэй дискэн тормоз, хөл, толгой, цээж, хажуугийн цохилтоос хамгаалсан нийт **10 хийн дэр** зэрэг нь таныг болон зорчигдыг тохиолдож болзошгүй гэнэтийн аюул ослоос бүхий л талаараа найдвартай хамгаална.



Зогсоолд байршуулах автомат системийн тусламжтайгаар параллель байрлалд жолоочийн оролцоогүйгээр өөрөө байрлах боломжтой

Шинэчлэгдсэн Тигуаныг дээрхи тоноглолуудаас өөрийн хүссэн тоноглолтойгоор албан ёсны дистрибьютер Таван Богд Моторс компанид захиалан авах боломжтой.

Таван Богд Моторс ХХК
Утас: 9909-2361, 9910-1963
www.motors.mn

TOP SAFETY PICK 2011

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Үүсгэн байгуулагч,
Эрхлэгч: Д.Бэхбаяр 9999 4248

Үүсгэн байгуулагч,
Орлогч Эрхлэгч:
И.Оттонжаргал 8800 6228

Англи хэлний редактор:
Terrence Edwards

Орчуулагч: Б.Үүрийнтуяа

Сэтгүүлч:
Х.Хулан
Э.Зоригт
Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Б.Уганбаяр
Б.Энхмарт

Дизайнер, Вэб мастер:
Ш.Оюундарь

Маркетингийн менежер:
Д.Барианжав 8880 0825
С.Жавхлан 99620780
Б.Энхцэцэг 9901 5476

Борлуулалтын менежер:
С.Цэнд-Аюуш

Хаяг:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23
Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар,
Төв шуудан, ш/ х-2762

Утас/Факс: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:
"Интер ном"
"Цэцэг төв"
"Зиг заг" автосервис
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mal"

Эрхлэгчийн зурвас

Монголын эдийн засгийн 2011 оны форумын үеэр манай сэтгүүлийн анхны дугаар гарч билээ. Бид Эдийн засгийн чуулганаар анхныхаа дугааараа гаргана гэж төлөвлөөгүй, тэгж л таарсан юм. Гэтэл олон хүн танай сэтгүүл энэ том форумаар гарч байгаа нь сайхан хувь зохиол юм биш үү гэсэн мэссэж ирүүлсэн. Зарим хүмүүс Монголын эдийн засгийн чуулганаас гаргаж буй сэтгүүл үү ч гэж асууж байлаа. Ингэж асуухаас аргагүй байсан хэрэг л дээ. Учир нь, өнгөрсөн оны форумын бүх оролцогч “Mongolian Economy” сэтгүүлийн анхны уншигчид болж, Монголын эдийн засгийн сэтгүүл зүйд ийм нэгэн сэтгүүл мэндэлсэн юм байна гэсэн мэссэжийг авсан билээ.

Тэгвэл өнөөдөр манай сэтгүүл нэг нас хүрлээ. Сэтгүүлийнхээ нэг жилийн ойн баярын мэндчилгээний хамт “Монголын эдийн засгийн чуулган-2012”-т зориулсан шинэхэн дугааараа уншигч, захиалагч, мөн тус чуулганы төлөөлөгч танд хүргэж байгаадаа маш их баяртай байна.

Монголын эдийн засгийн чуулган нь улс орны хөгжилд тулгарч буй асуудал, мөн гарцыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн төлөөлөлтэйгээр харилцан ярилцаж, санал бодлоо солилцож, тэдний санаа оноо, зөвлөмжийг төрийн бодлогод тусган хэрэгжүүлэхэд зорилгоо чиглүүлдэг арга хэмжээ билээ. Харин “Mongolian Economy” сэтгүүл Монголын эдийн засгийн салбар бүрийн асуудлыг хөндөж бичихийн зэрэгцээ мэргэжилтнүүд болон иргэдийн санаа оноог хууль боловсруулж, бодлого тодорхойлогчдод хүргэж ажилладаг тул манай хоёр байгууллага зорилго, чиглэл болоод бас нэр ч нэгтэй учраас хамтран ажиллаж ирлээ. Тиймээс шинэхэн дугаарын нийтлэлүүдийг энэ оны форумд зориулж, чуулганаар хэлэлцэх асуудлуудыг урьдчилсан хэлэлцүүлгүүд дээр очиж сурвалжилсны үндсэн дээр хөндөж бичив. Салбар бүрийн асуудлаар төлөөлөгчдөд бодит байдлаас гадна санаа оноо өгөхийг хичээлээ.

Мөн Ерөнхий сайд С.Батболд манай сэтгүүлд анх удаа ярилцлага өглөө. Засгийн газрын тэргүүн улс орны эдийн засаг, хөгжлийн талаар ярьж байна. Тэрбээр Эдийн засгийн форумын даргын хувьд чуулганы төлөөлөгчдийн үнэтэй санал бодол, зөвлөмжийг сонсоход нэлээд ач холбогдол өгдөг гэж хэлж болно.

Сэтгүүлийн маань нэг жил бол бидний хувьд том баяр, бахархал. Бүх уншигч, захиалагч нартаа нэг жилийн ойн баярын мэндийг хүргэхийн зэрэгцээ өнгөрсөн хугацаанд хамтдаа байж, сэтгүүлийг маань захиалан уншиж, санаа бодлоо хэлж байсанд маш их баярлалаа. Та бүхний сэтгүүлийг дэмжсэн сэтгэл, урам, шүүмжлэлийн хүчинд бид багагүй амжилттай явна

Эрхлэгч Д.Бэхбаяр

Агуулга

Ядууралд ялгавартай бодлого хэрэгтэй

Өнөөдөр Монгол Улсын эдийн засаг 17 гаруй хувиар өссөн. Үүнийг дагаад ядуурал ч мөн адил өсч 40 орчим хувьд хүрчээ...22

Уул уурхайн тэсрэлт дундах бохир баячууд ба үндсэрхэг үзэл

Хятад улсын хэрэгцээт баялаг дээр сандайлсан Монгол Улс огцом өсөлтийг таалан сууна...30

Ус-тогтвортой хөгжил

Дэлхийн нийт усны 2,5 хувийг л цэвэр ус эзэлдэг. Үүний өчүүхэн хэсэг нь Монголд ногддог...37

Эдийн засаг

10 Эдийн засгийн форум-хөгжлийн гарц хайдаг индэр

12 С.Батболд: Нээлттэй, ил тод, олонхийн оролцоотой засаглалтай оронд хөгжил ирдэг

17 Түвэгтэй бизнесийн түгшүүр

19 Төсвийн зарцуулалтад Дулмаа анхаарна

21 “Халамжийн” бодлого

22 Ядууралд ялгавартай бодлого хэрэгтэй

23 Мэдлэг зарна

26 Тэтгэврийн нөөц сантай болох уу

27 Эрүүл мэндийн салбарт эрс шинэчлэл хэрэгтэй байна

29 Швейцариас ирсэн захидал

30 Уул уурхайн тэсрэлт дундах бохир баячууд ба үндсэрхэг үзэл

33 Тархигүй эдийн засаг

35 Нөөц баялгийн хяслан

Ногоон эдийн засаг

37 Ус-тогтвортой хөгжил

40 Нүүрс үү, салхи уу?

Бизнес

44 Монгол брэндийг хөлд оруулъя

45 Компанийн нийгмийн хариуцлага үнэт чанарын тусгал юм

48 Тиймээ, бид Монголын Economist болох зорилготой

49 Сэтгэл нэг л их догдлонгуй

52 Тэд хөрөнгө оруулалтыг хэрхэн “чулуу” болгож чадсан бэ

Нүүрс үү, салхи уу?

...Өнөөдрийн байдлаар Монгол Улсын эрчим хүчний ганц нөөц нь нүүрс. Эрчим хүчний зориулалтаар ашиглах 12 тэрбум гаруй тонн нөөцтэй 200 гаруй нүүрсний уурхай манайд бий. ... 40

Монгол брэндийг хөлд оруулъя

Чацарганы тариалалтын талбайг 2016 он гэхэд одоо байгаагаас нь 20 мянган га-гаар тэлэх, ургацыг 35 мянган тоннд хүргэхээр “Чацаргана” хөтөлбөрийнхөн төлөвлөж байнаж...44

Компанийн нийгмийн хариуцлага үнэт чанарын тусгал юм

Хариуцлагатай бизнес гэдэг нь бүх нийтийн сайн сайханд үйлчилнэ... 45

http://www.mongolianeconomy.mn

Эдийн засаг

Бага, дунд орлоготой иргэдэд жилийн зургаан хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай орон сууцны хөнгөлөлттэй зээл олгох тухай асуудлыг зохицуулсан журмыг холбогдох яамд, Улаанбаатар хотын захирагч нар баталлаа. Энэхүү ажлын хүрээнд иргэдийг жилийн зургаан хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулахад шаардагдах хөрөнгийг бүрдүүлэхийн тулд Хөгжлийн банкны 200 хүртэл тэрбум төгрөгийн үнэт цаас гаргахаар Засгийн газар шийдвэрлэсэн. Мөн үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрт Засгийн газар баталгаа гаргахыг Сангийн сайдад зөвшөөрөөд байгаа аж. Хөгжлийн банкнаас гаргах үнэт цаасны эх үүсвэр орж ирэх хүртэлх хугацаанд арилжааны банкууд өөрийн хөрөнгөөр иргэдэд орон сууцны хөнгөлөлттэй зээл олгох юм.

Нийслэл 2012 оныг “Иргэдийн оролцоо-өрхийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлалаа. Өнгөрсөн онд нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор 396 төсөлд 30 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, үүний үр дүнд нийт 1330 ажлын байр шинээр бий болжээ. Энэ ажлын хүрээнд эмзэг бүлгийн өрхийг дэмжихийн зэрэгцээ жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэн өрхийн орлогоо нэмэгдүүлэхээр зорьж буй иргэдээ түлхүү дэмжих ажээ.

Улсын нөөцөд 10 мянган тонн мах нэмж бүрдүүлэн, худалдах тухай тогтоолыг Засгийн газар гаргалаа. Нийслэлийн Засаг даргын захирамжийн орон нутгаас мах бэлтгэх ажлын хэсэг ч байгуулж, хөдөө томилолт аван ажиллаж байгаа аж. Түүнчлэн “Аймаг, нийслэлийн Засаг дарга нар, аж ахуйн нэгжтэй мах нэмж нийлүүлэх гэрээ байгуулах, борлуулалтын оновчтой хэлбэрийг бий болгох, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон” гэдгийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнсний хангамж хариуцсан мэргэжилтэн О.Уянга хэллээ.

Санхүүгийн зах зээл

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн ТУЗ-ийн 2012 оны хоёрдугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор “Электрон арилжааны системын арилжааны журам” шинэчлэгдсэн байна. Журмын зорилго нь Монголын хөрөнгийн бирж /цаашид Бирж гэх/-ийн үнэт цаасны арилжааны төрөл, хэлцэл хийгдэх нөхцөл, арилжааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах явцад үүсэх харилцааг зохицуулахад орших аж.

Нийгэм

Улсын бүртгэлийн ерөн¬хий га¬зар цахим иргэний үнэм¬лэх хэв¬лэх программаа суул¬гаж дуу¬саад, иргэдийн гарт хүргэхэд бэлэн болоод байгаа ажээ. Засгийн газарт танилцуулсны дараа олон нийтэд тараах өдрийг мэдэгдэх гэнэ. Цахим үнэмлэхийг 484 нэгжээр дам¬жуулан энэ оны дөрөв¬дүгээр сар гэхэд арванзургаагаас дээш насны иргэн бүрт хүргэсэн байхаар төлөвлөөд байгаа юм. Нийслэл болон хөдөө, орон нутгийн иргэд шинэ цахим үнэмлэх авахдаа

харъяа хороондоо иргэний үнэмлэхээ авч очоод цахим иргэний үнэмлэхээ авах бүрэн боломжтой гэнэ. Хуучин үнэмлэхээ Улсын бүртгэлд хураалгах хэрэгтэй. Ингэснээр хуучин үнэмлэхийг устгалд оруулах ажээ.

Уул уурхай

Өмнөговийн Ухаа худагийн коксжих нүүрсний уурхайд олборлолт хийж буй “Энержи Ресурс” компанийн нүүрсийг нойтон аргаар баяжуулах үйлдвэрийн хоёрдугаар хэсгийг Улсын комисс хүлээн авлаа. Хоёрдугаар модуль нь жилд доод тал нь 6000 цаг ажиллах бөгөөд цаг тутамд 850 тонн, жилдээ 5 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай ажээ. Ингэснээр Ухаа худагийн нүүрс баяжуулах үйлдвэрийн

хүчин чадал 10 сая тонн болж өргөжиж буй юм. Харин гуравдугаар модулийг энэ оны сүүлчээр ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа аж.

Төв аймгийн Баян сумын нутагт байрлах Бөөрөлжүүтийн тал буюу Цайдам нуурын нүүрсний ордын хайгуулын ажил дуусаж, олборлолтоо эхлэхээр болжээ. Энэхүү орд нь Төв аймгийн Баян, Баянжаргалан сумыг холбосон 35 кВт-ын өндөр хүчдэлийн шугам болон цэвэр усны эх үүсвэрээс гурван км зайтай оршдог нь дэд бүтцийн тааламжтай нөхцөлтэй төдийгүй Монголын хувьд нүүрс шингэрүүлэх, хагас кокс, шахмал түлшний үйлдвэр байгуулах хамгийн том орд газарт тооцогдож байгаа юм. Тиймээс тус орд газрыг түшиглэн 600 мВт-ын цахилгаан станц барихаар болж, техник, эдийн засгийн үндэслэлээ гаргаад байгаа аж.

Дэд бүтэц

Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Увс, Завхан, Хөвсгөл аймгийн төвийг нийслэл хоттой холбох замын ажлыг ирэх дөрөвдүгээр сард эхлүүлэхээр боллоо. Энэ дагуу авто замын барилгын ажил, барилгын технологид хяналт хийж гүйцэтгэх зөвлөхийн ажлын жагсаалтыг Засгийн газраас батлав. Замын ажилд 293 орчим тэрбум төгрөг шаардлагатайгаас эхний ээлжинд 88 орчим тэрбум төгрөгийг Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэхээр болсноо салбарын сайд нь мэдэгдсэн юм.

V ДЦС тендерийн төслийг хоёр үе шаттай хэрэгжүүлэх аж. 2015

http://www.mongolianeconomy.mn

он хүртэлх үе шатанд 450 МВт чадалтай эхний барилга байгууламжийг ашиглалтад оруулах юм байна. Хоёрдугаар шатанд 370 МВт чадалтай байгууламжийг барих ажээ. Хоёрдугаар шатны шалгаруулалтад 11 компани саналаа ирүүлснээс дөрөв нь шалгарчээ. Компаниудыг нэрийг, шалгаруулсан үзүүлэлтийн талаар уг төслийн удирдагч Б.Эрдэнэбилэгээс тодруулахад “Надад одоохондоо тодорхой мэдээлэл алга. Шалгаруулалтаас тунасан дөрвөн компанийн нэрийг холбогдох яам, Засгийн газраар баталгаажуулсны дараа зарлах байх” гэв.

Эрүүл мэнд

Эрүүл мэндийн яам энэ жилийг “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын жил” болгон зарлаж, нээлтээ хийлээ. Нээлтийн үеэр Эрүүл мэндийн сайд Н.Хүрэлбаатар эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, үйл ажиллагаагаа улам эрчимжүүлэх зорилгоор луу жилийг “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын жил болгон зарлаж буйгаа дуулгав. Энэ ажлын хүрээнд есөн зорилт бүхий, тус бүр есөн багц, нийт 81 ажил хийх бүтээлч санаачилга өрнүүлэн төлөвлөгөө боловсруулжээ. Үүний дотор 18 хүртэлх насны бүх хүүхдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүлжүүлэх зорилгоор “Эрүүл хүүхэд-Монголын ирээдүй” аяныг орон даяар зохион байгуулахаар болсон байна.

Орос

Москва хотноо болсон “Оросын хөрөнгө оруулалт-2012” чуулганы үеэр тус улсын Ерөнхий сайд В.Путин өөрийн Засгийн газрын бодлогоо танилцуусан тухай Оросын “Правда” сонины цахим хуудсанд мэдээлжээ. Тэрбээр илтгэлдээ Оросын эдийн засаг барууны бусад орны эдийн засгийн байдалтай харьцуулахад сүүлийн 12 жилийн турш амжилттай хөгжиж ирсэн тухай хэлээд Америк болон Европын холбооны эдийн засгийн бодлогыг шүүмжлээд амжижээ. Путин илтгэлдээ “Евро бүсийн нийт өрийн хэмжээ ДНБ-ий 90 орчим хувьтай тэнцэж байна. Улс, улсаасаа хамаараад энэ үзүүлэлт 80-85 хувьтай байна. Итали, Грек зэрэг оронд өрийн хэмжээ 124 хүртэл хувьд хүрсэн” хэмээн онцолжээ. Мөн тэрбээр Америкийн өрийн хэмжээ 15,3 их наяд ам.долларт хүрсэн төдийгүй энэ нь тус улсын ДНБ-ээс их байгаа тухай тэмдэглэсэн байна. Энэ байдал удаан үргэлжилвээс бидний таамаглаж буйгаас илүү сөрөг үр дүнг дагуулахыг анхааруулсан бол Орос улсын хувьд эдийн засгийн эргэлт хийх үе ирсэн гэж онцлов.

Хятад

Хятад, Солонгос, Япон улс нь Хөрөнгө оруулалтын гурван талт хэлэлцээр хийх болсон тухай Солонгосын Ёнхап агентлаг мэдээллээ. Тус хэлэлцээрийг 2007 оноос хойш хэрэгжүүлэхээр зэхэж байсан бөгөөд уулзалтын сүүлийн товыг энэ долоо хоногт буюу энэ сарын 28-наас ирэх сарын 1-нд төлөвлөжээ. Энэхүү уулзалт амжилттай болж өндөрлөвөл бусад эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг өргөжүүлэх саналтай байгааг холбогдох албаныхан мэдэгдсэн юм.

Япон

Японы Засгийн газар өрийн хэмжээгээ бууруулахын тулд худалдааны татварын хэмжээгээ өсгөхөөр болсныг BBC мэдээлэв. Тус улсын татварын хэмжээ одоогоор таван хувь байгааг 2014 онд найм болгож, 2015 онд 10 хувьд хүргэхээр тооцоолсон гэнэ. Ингэж бүсээ чангалахын учир нь тус улс 10.5 их наяд ам.долларын өртэйгээс гадна ирэх жил нийгмийн халамжид зарцуулах хөрөнгийн хэмжээ нэг их наяд иен (12.6 тэрбум ам.доллар)-ээр нэмэгдэхийг урьдчилан тооцоолсон байна. Түүнчлэн 2060 он гэхэд нийт хүн амынх нь ойролцоогоор 40 хувийг тэтгэврийн насныхан эзлэхээр байгаа аж.

http://www.mongolianeconomy.mn

Онцлох сэдэв

Эдийн засгийн форум-хөгжлийн гарц хайдаг индэр

17 Түвэгтэй бизнесийн түгшүүр

19 Төсвийн зарцуулалтад Дулмаа анхаарна

22 Ядууралд ялгавартай бодлого хэрэгтэй

Д.Баяр

Монголын эдийн засгийн форумыг зохион байгуулаад гурав дахь жилтэй золгож байна. Хөгжлийн гарцад шинэлэг санаа, шинэ өнгөөр түрэн орж ирсэн Эдийн засгийн форум нь ихээхэн ач холбогдолтой, нийгэмд хэрэгтэй арга хэмжээ болсон билээ. Төрийг хувийн хэвшлийн, олон нийтийн санаа бодлыг сонсдоггүй, асуудлыг нээлттэй бусаар хэлэлцээд баталж, хэрэгжүүлдэг, ингэснээр амьдралд буухгүй шийдвэр, дүрэм гаргадаг гэж их шүүмжилдэг. Тэгвэл энэхүү чуулганыг жил бүр хийдэг уламжлал тогтсоноос хойш дээрх шүүмжлэл тодорхой хэмжээгээр багассан гэж хэлж болно.

Өөрөөр хэлбэл, Монголын эдийн засгийн чуулганы гол зорилго нь улс орны хөгжлийн секторуудаар хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэмтэн судлаачдын санаа оноог сонсож, тэрхүү үнэтэй санал санаачлагыг төрийн бодлого тодорхойлогчдод хүргэхэд чиглэдэг. Чуулганаас гарсан олон зөвлөмж, шинэлэг санаагаар төрийн эрхмүүд хөгжлийн зөв бодлогыг баяжуулж, амьдралд ойрхон бодитой дүрэм журам, хуулийг баталж хэрэгжүүлдэг механизмыг л бүрдүүлэхэд чуулганы үр дүн орших юм.

Өнгөрсөн хоёр удаагийн форум нь маш зөв арга хэмжээг сэдэж явуулж байгааг харуулна. Давхардсан тоогоор 1500 гаруй хүний санаа бодлыг төр сонсчээ. Энэ нь хөгжлийн нэг алхам бус гэж үү. Өмнө нь нэг яам, тамгын газар дээр, эсвэл тодорхой хүрээнд асуудлыг яриад л өнгөрдөг, нэгэн өглөөний нарнаар хууль мэндэлдэг, араас нь дагасан шинэхэн дүрэм журмууд цувардаг л тогтолцоо байсан шүү дээ. Тэгвэл өдгөө бас ч тухайн салбарын хөгжлийн ирээдүйн гарц шийдлийг олохын төлөө төр иргэдээ, хувийн хэвшлийнхнээ сонсож, санал бодлоо хуваалцахыг эрмэлздэг болоод байгаа нь дэвшил юм.

Гэхдээ гуравхан настай арга хэмжээний хувьд алдаа оноотой зүйл байгаа нь мэдээж. Зохион байгуулалт, хэлэлцэх асуудал, төрийн түшээд болон иргэдийн оролцоо гээд л цааш нь улам сайжруулж, бэхжүүлж, анхаарал хандуулах асуудлууд бий. Үнэ өндөртэй хурлаар хүмүүс баахан л юм ярьдаг, тэр нь үр дүнгээ өгдөг ч юм уу, үгүй ч юм уу, эсвэл нөгөө төрийн түшээд нь орж ирээд л өөрсдийн хийснээ л яриад байдаг гэж олон хүний ярихыг сонссон. Ингэж ярьдаг хүмүүсийг энэхүү чуулганд ороод асуудлын гүнд нь орж үзээсэй гэж хэлмээр санагдана. Улс орныхоо хөгжлийн талаар та хий дэмий бухимдаж, энэ төрийнхөн гэж тэднийг шүүмжилж суухын оронд энэхүү чуулганд ороод саналаа хэлж, эсвэл урьдчилсан хэлэлцүүлгүүдэд идэвхтэй оролцох эрхтэй шүү дээ. Хэлж ярьж, санал бодлоо уралдуулж байж л хөгжил ирнэ. Төр иргэдээ хэдий чинээ тэвчээртэй сонсоно, улс хөгждөг гэдэг шүү дээ.

Энэхүү арга хэмжээг Монголын эдийн засгийн форум ТББ зохион байгуулдаг. Зохион байгуулалтын арга хэлбэрийн тухайд уламжлалт арга барилаас татгалзаж, өөрөөр хэлбэл, Давосын уулзалтын жишгээр төрийн түшээдийг их яриулахгүй, илтгэл тавьж төлөөлөгчдийн нойрыг хүргэхгүй байдлаар хийхийг чухалчилдаг. Мөн дэлхийд нэртэй эдийн засагчдыг урьж, тэдний илтгэл дээр хэлэлцүүлэг өрнүүлдэг байдлыг уламжлал болгохоор ажиллаж буйг тус ТББ-ын ерөнхий захирал Л.Төр-Од ярьж байна. »

http://www.mongolianeconomy.mn

Үр дүн гарсан уу?

Өнгөрсөн хоёр жилийн форум улсын бүртгэлийн шинэчлэл, төсвийн шинэтгэл буюу тогтвортой, ил тод, нээлттэй байдал, хөрөнгийн зах зээлийн шинэчлэл уул уурхай, хүний хөгжил, засаглал, дэд бүтцийн асуудлыг хөнджээ. Үр дүн тодорхой хэмжээгээр гарсан тухай Ерөнхий сайд С.Батболд ярьсан. Тухайлбал, улсын бүртгэлийн шинэчлэл хийгдээд явж байгаа, төсвийг олон нийтэд ил болгох, төсвийн зарцуулалтыг иргэдийн зүгээс хянах, төсвийн тогтвортой байдлыг бий болгох, орон нутгийн төсөв захирагчдад эрх мэдэл олгох шаардлагатай байгаа билээ. Тиймээс УИХ төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх, түүний эрх зүйн тогтвортой орчныг бүрдүүлэх хүрээнд Монгол Улсын төсвийн тухай хуулийг шинэчлэн баталсан.

Уг хуулиар төсвийн төвлөрлийг сааруулах, орон нутгийн төсөв захиран зарцуулах эрх мэдэл, ялангуяа нутгийн захиргааны төсвийн үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, улсын ба орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн горимыг шинэчлэх, бүс нутгийн хөгжлийг татварын бодлогоор дэмжих, орон нутгийн татварын орлого бүрдүүлэх чадамжийг бэхжүүлэх, иргэдийн эрүүл мэнд, боловсрол, эрхэлж буй бизнес, орон нутагт бүтээн байгуулалт, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг түлхүү хуваарилах, түүнчлэн төсвийн хуваарилалт, зарцуулалт, хяналтын ажлын явцад иргэдийн идэвхтэй оролцоог өргөжүүлэх өргөн боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой аж.

Энэ бол Монгол Улсын хөгжилд хурд нэмэхүйц хууль болсон гэж мэргэжилтнүүд үзэж байгаа. Хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийг Лондонгийн хөрөнгийн биржтэй хамтарч хийхээр ажиллаж байна. Гэхмэтчилэн форумын зөвлөмж, санаа оноог тусгасан ажлууд салбар бүрт хэрэгжээд явж буй тухай Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун хэвлэлийн хурлын үеэр сэтгүүлчдэд мэдээлэл өгсөн.

Ямар асуудлыг хэлэлцэх вэ?

Энэ оны чуулганаар гурван асуудлыг хөндөж ярилцах юм. Нэгдүгээрт, эдийн засгийн хөгжил, хүртээмжтэй өсөлт. Хоёрдугаарт, нийгмийн бодлого, тэнцвэртэй өсөлт, гуравдугаарт, өрсөлдөх чадвар, инновац, ногоон шийдэл.

Өнгөрсөн онд үзүүлсэн эдийн засгийн огцом өсөлт хүндээ наалдаж чадаагүй талаар их ярьсан. Тэгвэл энэ чуулганаар өсөлтийг иргэн бүрт хэрхэн яаж наалдуулж амьжиргааг нь дээшлүүлэх вэ, яагаад өсөлт хүн бүрт хүртээмжгүй байна, эдийн засаг өсөөд байхад ядуурал яагаад буурахгүй байна, халамжийн хавтгайрсан бодлого иргэдийг залхуу занд сургасан уу, энэ бодлогоо үргэлжлүүлэх үү, санхүүгийн салбарт ямар бодлого үгүйлэгдэж байгаа, агаарын бохирдлоос ард иргэд ямар нэг хэмжээгээр өвчтэй болж, ирээдүй харшилж өвчилж байгааг яах вэ, Монгол Улс инновацийг ямар салбарт түлхүү хөгжүүлбэл үр дүн гарах бол, хүрэнээс ногоон эдийн засагт шилжүүлэх бодлогыг хэзээ хэрэгжүүлэх вэ, нүүрсээ ухахын зэрэгцээ байгальд ээлтэй салхины эрчим хүчийг хөгжүүлэх боломж байна уу, яаж хөгжүүлэх ёстой вэ, усны тулгамдсан асуудлыг шийдэх зөв гарц юу байх вэ, усны үнэ цэнийг бий болгоход ямар бодлого явуулах ёстой бол, усны үнийг нэмснээр асуудал шийдэгдэх үү, гадагшаа хил даван урсаж буй гол мөрөнийг хэрхэн ашиглах вэ, усны эрчим хүчээр хараат бус болж чадах уу зэрэг асуудлыг хөндөн ярилцахаар төлөвлөжээ. Эдгээр асуудлаар энэ жил урьдчилан хэлэлцүүлэг зохион байгуулсан нь шинэлэг санаа байлаа.

Эдийн засгийн форумын энэхүү нээлттэй индрийг хөгжлийн гарц хайдаг тавцан болгоход иргэн таны хувь нэмэр их. ■

Монголын эдийн засгийн форумын талаар хүмүүс ингэж хэлж байна

Камерон МакРей
/“Оюутолгой” ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал/:

“Монгол хүний ур чадвар, авьяас мэдлэг эдийн засгийн ирээдүйн хөгжлийг хүчирхэгжүүлэх болно. Тиймээс ч бид боловсролыг тэргүүн эгнээнд дэмжиж энэ салбарт хамгийн том хувийн хөрөнгө оруулалт хийгээд байгаа юм.”

Ч. Отгочулуу
/Монголын өрсөлдөх чадварын судалгааны төвийн захирал/:

“Өрсөлдөх чадвар өөрсдийгөө танин мэдэхээс эхэлнэ. Хөгжил нэгдсэн ойлголцлоос эхэлнэ.”

Жим Двайер
/МБЗ-ийн Гүйцэтгэх захирал/:

Монгол Улс эрчимтэй хөгжлийн шатандаа ирлээ. Эдийн засгийн форумаар “Тогтвортой Хөгжлийн” арга барил, хэмжигдэхүүнүүдийн талаарх мэдлэг оюунаа хуваалцан баталгаажуулах нь гол амжилт болно.

Ж. Оюунгэрэл /Петровис Хувьцаат Компанийн ТУЗ-ийн дарга/:

Монголын Эдийн Засгийн форум бол нийгмийн бүх оролцогчдын дуу хоолойг олон нийтэд хүргэх шинэлэг ардчилсан арга хэмжээ мөн. Гагцхүү МЭФ-ийн удирдлагыг төр, бизнес, иргэний нийгмийн оролцоог жигд хангасан байнгын ажиллагаатай хүчирхэг байгууллага болгох асуудал нэн тэргүүний зорилт болж байна.

Б.Найдалаа
/МЭФ ТТБ- ын Гүйцэтгэх Захирал/:

Мэдлэг солилцоо, харилцан ярилцлага, ойлголцол бол бодлогын шийдэл оновчтой гаргах үндсэн суурь нөхцөл юм. Энэ таатай орчинг бүрдүүлэх нь Эдийн засгийн форумын үндсэн зорилго бөгөөд жилээс жилд дэмжигч, оролцогчийн тоо нэмэгдэж, идэвхжиж байгаа нь Монгол Улс баялгийн хараалд өртөлгүй, сэргэн мандаж чадна гэсэн итгэлийг улам лавшруулж байна. Чуулгандаа бүтээлчээр оролцож, хөгжилд хувь нэмрээ оруулахыг урья.

http://www.mongolianeconomy.mn

Ерөнхий сайд ярьж байна

С.Батболд: Нээлттэй, ил тод, олонхийн оролцоотой засаглалтай оронд хөгжил ирдэг

Б.Баяртогтох

Ерөнхий сайд С.Батболдыг Монгол Улсын хөгжлийн гарааны түүхэн үед Засгийн газрыг тэргүүлж буй нэг талаас азтай, нөгөө талаас их хариуцлага үүрсэн хүн хэмээн уздэг. Үнэхээрийн ч Оюутолгой, Тавантолгой гэсэн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахаас авахуулаад төсөв, инноваци, Хөгжлийн банк, бүртгэл болоод санхүү, хөрөнгийн зах зээлийн шинэчлэл зэрэг улс орны хөгжлийн олон салбарын асуудал түүний удирдлагаар урагшилсаар байгаа юм. Тэрбээр мөн уламжлал болгон зохиож буй Монголын эдийн засгийн форумын даргаар ажилладаг билээ. Ингээд гурав дахь жилдээ болох гэж буй Монголын эдийн засгийн чуулганыг угтан Ерөнхий сайд С.Батболдтой эдийн засгийн асуудлуудаар ярилцлаа. Манай "Mongolian Economy" сэтгүүлийн хувьд ч үүсэн байгуулагдсаны нэг жилийн ойгоороо Засгийн газрын тэргүүнтэй ярилцаж байгаа нь бас түүхэн завшаан болж байгаа юм.

-Монголын эдийн засгийн форум гурав дахь жилдээ зохион байгуулагдаж байна. Энэ жилийн форумын онцлог юу байх вэ, ямар үр дүн хүлээж байна вэ?

-Энэ удаагийн Монголын эдийн засгийн форумын гол онцлог нь өмнөх жилүүдэд баталсан, хийсэн ажлуудаа тулгуурлаад дараагийн дөрвөн жилийн эдийн засгийн хөгжлийг тодорхойлох, мөн ирэх 20 жилийн эдийн засгийн хөгжлийн урт хугацааны гол гол чиглэлүүдийг ярих гэж байгаад оршино. Сэргээгдэх эрчим хүч, инноваци, шинэ технологи, төрөлжилт гэсэн томоохон сэдвүүдийг форумаар хэлэлцэнэ.

-Өнгөрсөн жилийн Эдийн засгийн форум хүний хөгжлийг хангаж, чинээлэг дундаж давхаргыг хэрхэн бий болгох вэ гэсэн эцсийн зорилго агуулж байсан. Чуулганаас гарсан шийдлүүдийг Засгийн газар шийдвэр гаргахдаа тусган ажиллана гэдгийг Та онцолж байсан. Үр дүн гарсан уу?

-Хүний хөгжлийг хангах, чинээлэг дундаж давхаргын талаар хэд хэдэн бодлогын алхмыг хийглээ. Нэгдүгээрт, бизнесийн орчныг сайжруулж, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд онцгой анхаарлаа. Хоёрдугаарт, жижиг, дунд үйлдвэр хөгжихөд чиглэсэн санхүүгийн дэмжлэг өмнөхөөсөө тав, зургаа дахин өссөн. Шинэ санхүүгийн хэрэгслүүд бий боллоо. Тухайлбал, зээлийн баталгааны хууль батлагдсан нь маш чухал. Мөн сум хөгжүүлэх сан байгуулагдсан. Энэ бүхэн нь эргээд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх чинээлэг, дундаж давхаргууд бий болгоход чиглэсэн бодлогууд байгаа юм.

Цаашид хувираа болон жижиг, дунд үйлдвэр эрхэлж байгаа иргэдийн татварын орчинг илүү хөнгөлж, нөгөө талаасаа үл хөдлөх хөрөнгөтэй, орон сууцтай дундаж давхаргын айл өрхийг дэмжсэн татварын бодлоготой болохоор ажиллаж байна. Энэхүү бодлогыг энэ онд үргэлжлүүлж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг шинээр бий болгоход нэлээд ажил төлөвлөгдөөд хийж байна. Энэ бүхэн эргээд эдийн засагтаа гэрэл гэгээ нь болж, иргэдийг ядуурлаас гаргах, чинээлэг дундаж давхаргыг бүрдүүлэхэд онцгой ач холбогдолтой. Ажилгүйдэл 11 хувь байснаа найман хувь болтлоо буурлаа. 72 мянган ажлын байр бий боллоо. Бизнесийн орчин сайжирснаар жижиг, дунд үйлдвэрлэлийн тоо нэмэгдсэн. Энэ жил өрхийн үйлдвэрлэлийг дэмжих жилийн хүрээнд хэд хэдэн арга хэмжээ авахаар төлөвлөж байна. Төлөвсөн ажил бүхэн чинээлэг дундаж давхаргад хүрэхэд ахиц гарна гэж үзэж байна.

-Хүний хөгжлийн асуудал үндэсний хөгжлийн стратегид хэрхэн тусгагдах учиртай вэ?

-Хүний хөгжлийг олон хэлбэрээр авч үзэх хэрэгтэй. Нэгд, боловсрол, хоёр дахь нь эрүүл мэнд, гуравдугаарт, эдийн засгийн орлого гэж авч үзнэ. Уул уурхай ашигт малтмалын нөөц дээрээ тулгуурлаад Хүний хөгжил сан болон төсвөөр дамжуулаад дээрх гурван үзүүлэлтэд том ахиц гарлаа гэж бодож байна. Нэгдүгээрт, нэг хүнд »

ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр манай улс дундаж орлогын тоонд анх удаа багтлаа. Хоёрдугаарт, орлогыг дахин оновчтой хуваарилах талаар бодлогын нэгдсэн ойлголтод хүрсэн. Энэ хүрээнд дээр ярьсан бодлогуудыг хэрэгжүүллээ.

Боловсролын салбарт Кембрижийн тогтолцоонд шинээр шилжих, оюутны хотхон барих, Ерөнхий боловсролын олон сургуулийг барьж, засахад томоохон ахиц гарсан. Мөн эрүүл мэндийн салбарыг сайжруулахын тулд тогтолцоог нь иж бүрнээр эргэж харах, санхүүжилтийг шийдвэрлэх, эрүүл мэндийн даатгалын системийг боловсронгуй болгох талаар энэ форумаар ярьж, хэлэлцэнэ.

Монгол хүний дундаж наслалт нэмэгдсэн байгаа. Хуучин 64 байсан бол 68 хүрлээ. Энэ бол хүний хөгжилд тодорхой ахиц гарч байгаа гэсэн үзүүлэлт юм. Тэгэхээр цаашдаа эрүүл мэндийн тогтолцоог сайжруулж, Монгол Улс эрүүл мэндийн салбараараа бүс нутагтаа тэргүүлдэг болох. Монголчууд гадаад явж эмчлүүлэх бус гадныхан манайд ирж үзүүлдэг байх ийм хэмжээний эрүүл мэндийн системийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Мөн хөдөө орон нутагт төрөлжсөн олон шинэ эмнэлэг барих, хуучин эмнэлгийг засах ажлын өртгийг улсын төсөвт урьд өмнө байгаагүйгээр суулгасан байгаа.

Үргэлжлүүлэн боловсролын салбарт арван жилийн 30 сургуульд Кембрижийн боловсролын тогтолцоонд шилжихтуршилтхийжбайна.Амжилттай болох юм бол улс орноороо олон улсын стандартад шилжих юм. Их дээд сургуулиудын хүрээнд "Цахим хөндий" төсөл шинээр хэрэгжих гэж байна. Оюутны хотхон шинээр барих ажлын бэлтгэл хангагдаж, хөрөнгө мөнгө нь шийдэгдлээ. Багануурт оюутны шинэ хотхон барих ажил үндсэндээ эхэлчихлээ.Тэгэхээр ийнхүү богино хугацаанд боловсрол, шинжлэх ухааны салбарт ахиц гаргахаар ажиллаж байна.

-Уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж эхэлсэн ч Монголд ажилгүйдэл их хэвээр байна. Иргэдээ ажлын байртай болгоход Засгийн газар яаж анхаарч байгаа вэ?

-Хөдөлмөрийн бирж болон бүртгэл дээр үндэслэсэн хөдөлмөрийн зах зээлийг холбож өгөх асуудлыг төр хийх ёстой. Тиймээс ч мэргэжлийн сургалтын төвүүдийг өнгөрсөн хугацаанд олноор байгууллаа. Өнгөрсөн онд 70 мянган хүн ажлын байртай болсон. Гэхдээ ажилгүйдэл ядуурал буурсангүй гэх шүүмжлэл бий. Үүнд хариулах хоёр асуудал байна. Ажилгүйдлийн бүртгэлийг хийгээд ирэнгүүт нөгөө ажилгүй байсан иргэд бүртгүүлээд эхэлсэн. Өмнө нь олонх нь бүртгэлд байхгүй байсан гэсэн үг. Ажилгүй хүмүүс бүртгэлд хамрагдаж байна гэдэг сайн зүйл. Сүүдэрт байсан ажилгүйдэл ил гарч байгаа нь ахиц юм. Тэднийг мэргэжилтэй болгох чиглэлд өнгөрсөн жил анхаарлаа хандууллаа.

МСҮТ-үүдийн сургалт үйл ажиллагаанд эрс шинэчлэл хийж хөрөнгө оруулалт зориггой хийсний үр дүнд зах зээлд эрэлт ихтэй нарийн мэргэжлээр суралцах хүмүүсийн тоо нэмэгдлээ. Тэр хэмжээгээр уул уурхайн томоохон төслүүдэд хамрагдаж ажлын байраар хангагдаж байна. Хоёрдугаарт, ажилгүйдлийн түвшинг тооцох статистик аргачлалд зөрүү байна. Дэлхийн банкны олон улсын аргачлалаар манай ажилгүйчүүдийн төвшин нэлээд буурч, бараг 10 хувьд хүрсэн байдаг. Гэтэл ҮСХ-ны гаргасан тооцоогоор энэ тоо 39 хувь дээр явж байна. Юуны өмнө энэ аргачлалаа маш тодорхой болгох хэрэгтэй юм.

Хөдөлмөрийн бирж болон шинэ бүртгэлийг үндэслэн ажилгүйчүүдийн дунд мэргэжлийн сургалт зохион байгуулах ажлыг төр хийнэ. Харин иргэдээсээ болон залуучуудаасаа хүсэх зүйл гэвэл ажил хийвэл ам тосдоно гэдэгчлэн хөдөлмөрлөх хэрэгтэй гэдгийг хэлмээр байна. Жишээ нь, өнгөрсөн оны эхээр би хөнгөн үйлдвэрийнхэнтэй уулзах үеэр "Говь" компани 400 гаруй хүний ажлын байр байгаа ч долоохон хүнийг ажилд авсан тухайгаа ярьж байсан. Яасан гэхээр нэхмэлчин, сүлжигч гэх мэргэжлийн ажилтан олдохгүй байгааг учирласан. Иргэдэд ажил хийх, бас нарийн мэргэжлээр суралцах санаачилга эрмэлзлэл тийм ч сайн биш байна. Тиймээс Засгийн газраас тэднийг хүссэн мэргэжилдээ эзэн болгох хэмжээнд мэргэшүүлэх, ингэсний хүчинд хөдөлмөрийн үнэлэмжээ зөв үнэлүүлж боломжит амьдралыг бий болгох тал дээр дэмжих ёстой гэсэн бодлогыг барьж байна. Мөн эдийн засгийн боломжийг ч тийш нь чиглүүлэх ёстой гэж үздэг. Үүнийг бид цаашид системчилж, өнгөрсөн жил тавьсан сууриа эрчимжүүлэх болно.

-Дэлхийн эдийн засаг нэн осолтой цэг дээр байна. 2008 оны хямралтай төстэй уналтад орох бодит эрсдэл үүсээд байна. Европын улсуудын өрийн хямрал дордвол дэлхийн аль ч улс орон дархлаатай байж чадахгүй гэж судлаачид үзэж байна. Мөн олон улсын байгууллагуудаас Монголын бодлого тодорхойлогчид 2008, 2009 онд гаргасан алдаанаасаа сургамж авах биш, харин ч алдаагаа давтаж байгаа нь Монголын эдийн засагт хямрал нүүрлэх эрсдэлийг даллаж байна гэдгийг хэлж сануулсаар байна. Та үүнийг юу гэж үзэж байна вэ?

-2008 оны хямралаас сургамж аваад бий болгосон шинэ тогтолцоо нь яах аргагүй Тогтворжуулалтын санг байгуулсан явдал. Тус санд хуримтлал үүсгэж байгаа. Цаашдаа хүний хөгжилд хөрөнгө оруулалт хийх хуримтлалыг төвлөрүүлдэг санг бий болгохоор ажиллаж байна. Энэ чиглэлээр олон улсын туршлага бий. Тухайлбал, Сингапур улсад хувь хүн тус бүр дээр хуримтлалын сан үүсгэж, уг сан дахь мөнгийг боловсрол, эрүүл мэнд, орон сууцны зардлыг нь төлдөг тогтолцоотой.

Цаашилбал, Төсвийн тогтвортой байдлын хуулийн дагуу төсвийн алдагдлаа жил бүр багасгах, хуримтлалаа байнга өсгөх улсын хэмжээний бодлого хэрэгжинэ. Иймээс 2012 оны зургадугаар сараас хойш бэлэн мөнгөний түгээлт "дуусаж", бүтээн байгуулалт, аж үйлдвэржилтийг бий болгоход зарцуулна. Үүний тулд Хөгжлийн банкийг бий болгосон. Энэ хөрөнгийг тус банкинд байршуулж, тодорхой хэмжээний санхүүгийн эх үүсвэртэй болгох талаар мэргэжлийн байгууллагууд анхаарч байгаа.

Ер нь ирэх жилүүдэд дэлхий хэмжээнд эдийн засгийн хямрал болж магадгүй гэсэн таамаглал явж байна. Тиймээс Монгол Улсын хувьд багагүй хэмжээний мөнгөн хуримтлал үүсгэчихсэн, хувь хүн бүр өөрийн гэсэн хуримтлалтай болж, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлээ хуримтлалаасаа төлдөг болгохыг зорьж байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн ирээдүйн баталгааг бий болгочихсон байх болно. Нөгөө талаас төр төсвийн алдагдалтай олон салбараа тэтгэж, өргөтгөсөн байх нь ойрын дөрвөн жилийн дунд хугацааны гол зорилгуудын нэг байх юм. Ингэснээр манай улсын эдийн засгийн аюулгүй байдлыг сайжруулах тал дээр онцгой ахиц гарна. Мөн дэд бүтцээ сайжруулж, олон талд далайд гарцтай болоход хэлэлцээр хийж, бүтээн байгуулалт эрчимжиж байна.

-Монгол Улс дотооддоо нефтийн үйлдвэртэй болох асуудал ямар шатандаа явна вэ, бид хэзээ энэ »

http://www.mongolianeconomy.mn

http://www.mongolianeconomy.mn

хараат байдлаасаа гарах вэ?

-Аль болох нефтийн бүтээгдэхүүний хараат байдлаас хурдан гарах зорилт дэвшүүлсэн. Өмнө нь зорилт дэвшүүлж байсан ч яаж шийдэх вэ гэсэн шийдэл тодорхой гарч байгаагүй. Манай Засгийн газар хэд хэдэн шийдлийг боловсруулаад энэ чиглэлээр ажиллаж байна. Товчхондоо нүүрс шингэрүүлэх болон дотооддоо нефтийн үйлдвэр байгуулах зарчмын шийдлүүд гарчихсан. Үүний дагуу хөрөнгөө босгож, дотооддоо нефтиэ боловсруулах, нефтийн хангамжийг дотоодоосоо хийх бодлогыг барьж байна.

-Таван толгойн хэлэлцээ ямар шатандаа явна вэ?

-"Таван толгой"-н орд газар эдийн засгийн эргэлтэд орсон. Оны сүүлчээр эхний сая орчим тонн нүүрс "Тавантолгой"-н Зүүн Цанхийн ордоос гарлаа гэж надад хэлсэн. Энэ ажлын эрч хүчийг улам нэмэгдүүлэх, хэвийн төвшинд аваачих техникийн бөгөөд зохион байгуулалтын нөхцөл хангагдсан гэж манай холбогдох байгууллага, компанийнхан бидэнд илтгэж байгаа.

"Таван толгой" дээр Баруун Цанхийн орд газрыг ашиглах асуудал бол хоёр дахь ойлголтын зөрүү яваад байна аа. Гадаадын улс орны компаниудад орд газраас хувь эзэмшүүлнэ гэсэн ойлголт. Ийм зүйл байхгүй. Засгийн газар ингэж огт яриагүй. Засгийн газар угаасаа "Тавантолгой"-н орд газар бол хувьцаа, өмчлөл, лицензийн хувьд ч 100 хувь Монголын ард түмэн, Засгийн газрын мэдэлд байгаа. Баруун Цанхи дээр энгийнээр яривал түрээсийн гэрээгээр, тодорхой хугацаагаар татвараа төлөөд нүүрс олборлож, магадгүй. 20-30 жилээр ч юмуу нүүрс олборлоё, жилд олборлох нүүрсний хэмжээг бид тогтоож өгье. Тухайлбал, Баруун Цанхи дээр нэг жилд 15 сая тн нүүрс олборлоно. Тэгээд 20 жилээр тооцох юм бол 600 сая тн. Тавантолгой орд 6-7 тэрбум тоннын нөөцтэй шүү дээ. Тэгэхээр энд түрээсийн олборлолтыг хийлгэх асуудлын тухай ярьж байгаа юм. Тэрнээс биш хувьцаа юмуу, өмчлөлийг өгчих тухай огт яриагүй. "Оюутолгой"-гоос эрс ялгаатай нь энэ. Цаашид ч ийм байна.

Түрээсийн олборлолт дээр манай сонирхогч бөгөөд ажиллая гэж байгаа гол гол түнш орнуудын компаниуд өөрсдийнхөө байр суурийг нэгтгэж харилцан тохирч чадаагүй л байна. Нэг талаасаа заавал тохиролцоод маргааш гэж шахах шаардлага байхгүй гэж үзэж байгаа. Нөгөө талаасаа энэ ажил удахад "Тавантолгой"-н ашиглалт хойш тавигдаж болохгүй ээ, энэ ажил явагдаж байх ёстой. Энэ утгаараа Засгийн газар болоод энэ ажлыг эрхэлж байгаа "Эрдэнэс-Тавантолгой" компанийн зүгээс үйл ажиллагааныхаа Зүүн Цанхи, магадгүй бусад хэсэг дээр, Баруун Цанхийн хэсэг дээр ч гэсэн хөрс хуулах ажлыг эхлүүлэх саналыг дэвшүүлээд ярьж байгаа зүйлүүд бий. Ажлын хувьд цаг хугацаа алдахгүй, мөн эрч хүчийг нь алдуулахгүй явуулах нөхцөл боломжийг хангаж ирсэн. Энэ хавар уул уурхайн ажил эхлэхэд үүнтэй холбогдсон ажлуудын бэлтгэл бүрэн дүүрэн бүрдэнэ гэж үзэж байгаа. Тийм учраас "Тавантолгой"-н орд газрын хувьд, энэ ордын ашиглалт, үүнээс олох орлогыг ард иргэддээ хүртээх эдийн засгийн шударга ёсны хуваарилалтыг Засгийн газар хариуцаж хийнэ.

-"Оюутолгой" төслийн хүдэр олборлох хугацааг наашлуул гэж Монголын Засгийн газар шаардаж байгаа тухай яриа байна. Ийм зүйл байгаа юу?

-Ийм зүйл байхгүй ээ. Ийм яриаг ч би сонсоогүй юм байна."Оюутолгой" төслийн хувьд бид онцгой анхаарч байгаа. Нэг сарын, нэг хоногийн өмнө ч ашиглалтад орвол Монгол Улсын эдийн засагт л үр өгөөжтэй. "Оюутолгой" төслийн зүгээс эрчим хүчний найдвартай эх үүсвэр хангагдаж чадаагүй ийм нөхцөлд ямар шийдэл байх ёстой вэ, үүнийг цаг алдалгүй шийдэж өгөөч гэсэн шахалтыг бидэнд үзүүлж байгаа. Та нар энэ асуудлыг шийдэхэд дэмжлэг үзүүлэхгүй бол төслөө цааш үргэлжлүүлэн явуулах боломжгүй болно шүү гэдгийг "Оюутолгой" төслийнхөн Монголын Засгийн газарт шахалт үзүүлж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Ажлаа хурдан хий гэж шаардах нь бидний үүрэг, нөгөө талаас боломж нөхцөлийг бүрдүүлж өг хэмээн шаардах нь бас тэдний үүрэг. Харилцан хоёр талаас ярьж байж л ажлыг шуурхайлах ёстой. Томоохон төслүүдийн үр дүнг болж өгвөл энэ онд гаргах ёстой гэж Засгийн газрын тэргүүний хувьд үзэж байгаа. Бас тийм чин эрмэлзлэл ч байна шүү дээ.

-Монгол орныг тэжээн тэтгэж ирсэн хөдөө аж ахуйн салбарыг шинэ тутам хөгжиж буй уул уурхайн хөгжилтэй хэрхэн зохицуулж, зөв авч явах ёстой вэ?

-Монгол Улсын эдийн засаг олон тулгууртай байх ёстой. Жишээ нь зөвхөн зэсийн үнэ унахад л манай төсвийн бүрдэлт үндсэндээ хүндэрдэг. Тэгэхээр бид уул уурхайд түшиглэсэн эдийн засгийг голлох биш, боломжийг зөв ашиглах ёстой. Уул уурхайг хөгжлийн түлхүүрийн түлхэц болгох учиртай. Нөгөө талаас монголчуудыг үеийн үед тэжээж ирсэн, тэтгэж байгаа, маргааш бүр ч илүү тэтгэх хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалангийн салбарыг онцгойлж авч үзэх ёстой гэж би үздэг. Энэ бол Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын асуудал юм. Эдийн засгийн хөгжлийн асуудал болсон хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангахын зэрэгцээ экспортын боломж ч бидэнд бүрэн дүүрэн бий. Тэгэхээр эхлээд дотоодын хэрэгцээгээ чанартай бүтээгдэхүүнээр хангах асуудлаа төр бодлогоор

http://www.mongolianeconomy.mn

дэмжих ёстой. Бодлогын дэмжлэгийг энэ удаагийн Засгийн газар, УИХ-аас маш тодорхой гаргасан. “Монгол мал” гэсэн үндэсний том хөтөлбөр гаргалаа. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогоо тодорхойлсон. Одоо эдгээрийг хэрэгжүүлэх хүрээнд хөтөлбөрүүдийг гаргаж байгаа.Үүний нэг нь “Таван эрдэнэ” хөтөлбөр юм. Малаа эрүүлжүүлэх асуудал хөтөлбөрийн нэг том ажил. Сүүлийн 20 гаруй жил хийгдээгүй зүйл. Малаа эрүүлжүүлэх энэ бодлого маань хөдөө аж ахуйг эрчимжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, малчдын амьдрал сайжрах нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байгаа.

-Тогтвортой хөгжлийн нэг үндэс нийгмийн хариуцлагаа ухамсарлах. Зөвхөн компаниуд бус нийтээрээ хариуцлагаа ухамсарлаж ажиллаж амьдрах шаардлагатай байна. Засгийн газраас компанийн нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх, урамшуулах чиглэлээр ямар бодлого, арга хэмжээ явуулсан бэ?

-2010 оноос Монгол Улс компанийн нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх томоохон бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Тухайлбал, Компанийн засаглалын үндэсний хөтөлбөрийг баталж, хэд хэдэн чуулган хуралдаан зохион байгуулж, компаниудад нэвтрүүлэх, жишиг компанийн дотоод засаглалын дүрэм журмыг боловсруулсан байгаа. Компанийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж, боловсронгуй болгох талаар эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Компанийн засаглалыг бэхжүүлэх, нийгмийн хариуцлагыг сайжруулахаар анхны чуулганыг хуралдуулж, хөтөлбөр боловсруулж байна. Үүнд олон улсын байгууллагын туршлагыг судлаад Монголын нөхцөлд нийгмийн хариуцлагыг хэрхэн тодорхойлох тал дээр ажиллаж байна.

Компанийн нийгмийн хариуцлага нь компанийн хувьд нийгэмтэй харилцдаг идэвхтэй гишүүн гэдгээ ухамсарлаж, тууштай зүтгэхийг хэлж байгаа юм. Нийгмийн бүрэн эрхт нэг гишүүн гэдгээ компани харуулах ёстой. Хүмүүсийн сайн сайхан амьдралын төлөө, тогтвортой орлогыг нь хариуцаж байгаа газар. Тиймээс цалин мөнгийг нь зөв тогтоох, урамшуулал, нийгмийн даатгал, ажилтны өсөлт хөгжлийн асуудалд анхаарал хандуулах шаардлагатай. Компанид хүн ажиллаж байхдаа тодорхой хэмжээний нийгмийн баталгааг бий болгох ёстой. Мөн компанийн ТУЗ-ийг сайн болгох, шийдвэр гаргах үйл явц тодорхой байх ёстой. Гадаад худалдан авалтыг ч тодорхой хэмжээгээр нээлттэй болгох хэрэгтэй. Хүн ажилд авах, тушаал ахиулах, өөрчлөх үйл явцаа журамжлах шаардлагатай. Нэг хүний засаглалаас компанийн жинхэнэ засаглал руу шилжих цаг үе болсон. Нийгэмд тогтвортой хөгжлийг бий болгоход компанийн үүрэг оролцоо маш чухал гэдэг нь эндээс харагдана.

-Дэд бүтэц, боловсрол, шинжлэх ухааны салбарт дорвитой хөрөнгө оруулалт байхгүй байгаа тухай салбарын мэргэжилтнүүд гомдоллодог.Гэрлийн хурдаар өссөн Монгол Улсын хөрөнгө оруулалтын чанарт Та ямар үнэлгээ өгөх вэ?

-Монгол Улсын хувьд дэд бүтцийн салбарт асар их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа. Сүүлийн жилүүдэд зөвхөн 2011 онд хийсэн хөрөнгө оруулалт 600 тэрбум төгрөг байсан бол 2012 онд үүнээс хоёр дахин их хөрөнгө оруулалт хийж байгаа. Үүний дийлэнх нь засмал зам, цахилгаан станц зэрэг дэд бүтцийн хөгжилд зарцуулагдана.

Түүнчлэн боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хийх хөрөнгө оруулалтын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа. Шинжлэх ухааны салбар хөрөнгө оруулалтыг хэр үр өгөөжтэй ашиглаж байгааг авч үзэх ёстой. Өнөөгийн байдлаар ШУА-д 20 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхэд энэ нь ерөнхийдөө цалин болоод хувирч байна. Монгол Улсын хөгжилд хамгийн тулгамдсан дэд бүтэц, утаатай тэмцэх, эрчим хүчний асуудлаар практикт хэрэгжиж байгаа зүйл тун бага байна. Зөвхөн суурь судалгаа, онолын судалгаа хийгээд байгаа нь хүмүүсийн бодит амьдралтай нийцэж, уялдаж өгөхгүй байгаа юм. Тиймээс цаашид ШУА-ийн тогтолцоог цогцоор нь шинэчилж, практик амьдралтай холбох хэрэгтэй байна. Шинжлэх ухааны салбарыг шинэчилснээр Монгол Улсын хөгжилд ихээхэн үр өгөөжтэй өөрчлөлт болно гэж бодож байгаа. Тус салбарт олон мянган залуу эрдэмтэн судлаач, академич ажиллаж байна. Тэдний мэдлэг чадварыг ашиглах, улс орны хөгжил рүү дорвитой чиглүүлэх хэрэгтэй байна.

-Лондоны хөрөнгийн биржтэй манай бирж хамтран ажиллаж байгаа нь хөрөнгийн зах зээлийг бодитоор хөгжүүлэх шинэ алхам болсон. Цаашид хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хууль эрх зүйн орчинд ямар өөрчлөлт хийх вэ?

-Үнэт цаасны тухай хуулийг шинэчилж олон улсын системд ойртуулах шаардлага байгаа. Манай хөрөнгийн зах зээл анхлан хувьчлалын зориулалтаар байгуулагдсан учраас орчин үеийн бодитой, хэрэгцээтэй шаардлагаас хоцроод байгаа юм. Техник, менежмент, зохион байгуулалтын хувьд хоцорсон гэсэн үг. Сүүлийн хоёр жилд хөрөнгийн биржийг дорвитой өөрчлөх чиглэлээр ажилласан. Үүний дүнд олон улсын менежментийн багийг авчраад техникийн шинэчлэлтийг бүрэн хийлээ. Одоо хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох болно.Бусад хөгжиж байгаа орны санхүүгийн эрүүл тогтолцоо нь банк 50, хөрөнгийн зах зээл нь мөн хэмжээний хувийн харьцаатай байдаг. Гэтэл манайд банк 95 хувь, хөрөнгийн зах зээл таван хувийг эзэлж байна. Ийм буруу

http://www.mongolianeconomy.mn

тогтоолцоог засаж сайжруулахад бас л хугацаа орно. Гэлээ ч манай Засгийн газар сүүлийн хоёр жилд энэ чиглэлд багагүй ажил эхлүүлээд байна.

-Ногоон хөгжлийг Та юу гэж ойлгодог вэ? Дэлхийн бусад улс ногоон хөгжлийг, ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж, эн тэргүүний зорилт болгоод явж байгааг бид харж байна. Гэтэл манай төрөөс хүрэн эдийн засгийг түлхүү ярьж, бодлогоо чиглүүж байгаа. Ногоон эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газар ямар бодлого, зорилттой явдаг вэ?

-Ногоон хөгжил гэдэг өргөн ойлголт юм. Байгаль орчинд ээлтэй салбарууд болох хүнс, хөдөө аж ахуй, тээвэр, аялал жуулчлал гээд бүх салбар ногоон эдийн засагт задардаг. Тиймээс ногоон хөгжлийг өргөн утгаар нь авч үзэх ёстой. Зөвхөн сэргээгдэх эрчим хүчийг ашиглана гэсэн үг биш. Хог хаягдал гэхэд л дахин боловсруулдаг байх, нүүрс шатааж эрчим хүч үйлдвэрлэхдээ хэмнэдэг болох, нар, салхины нөөцөө илүү сайн ашиглах. Нэг ширхэг бүтээгдэхүүнд зарцуулж байгаа энергийн хэмжээг хэмнэхээс ногоон хөгжил эхэлнэ. Жишээ нь бид крантаар гоожуулж байгаа усаа үр ашиггүйгээр алдахаа болих хэрэгтэй. Орон сууцны өрх айлууд цонхоо нээж дулаанаа алдахгүй байх нь ногоон хөгжил юм. Эхнээсээ л орон сууцныхаа дулааны тохиргоог тааруулах хэрэгтэй. Ийм зарчмаар ажиллавал бага зардлаар их зүйлийг бүтээнэ. Энэ нь байгаль орчиндоо ээлтэй гэсэн үг. Хэмнэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, байгалийн нөөцөө хэмнэх, гарсан хогоо боловсруулдаг болох хэрэгтэй. Үүнийг л ногоон хөгжил гэж ойлгож болно.

-Та саяхан намын бага хурал дээрээ олигархийн компаниас ард түмний засаглал руу шилжинэ гэсэн итгэл тавьсан билээ. Одоогийн засаглалын талаар та юу хэлэх вэ, яаж ард түмний засаглал руу шилжүүлэх вэ?

-Ерөөсөө улс орнуудын хөгжлийн түүх нь засаглалаасаа хамааралтай байдаг юм байна. Баян, ядуу, хөгжингүй орнууд гэж гурван төрлийн орон байна. Байгалийн асар их баялагтай мөртлөө ядуурсан орон тухайлбал, Африкийн орнууд. Байгалийн баялаг үнэт зүйл нь цөөнхдөө төвлөрчихсөн ийм засаглалтай улс орон ядуу байдаг юм байна. Баян орон гэж бий. Арабын орнуудыг жишээ болгон ярьдаг. Гаднынхныг нэлээд их авчирч ажиллуулдаг, өөрсдөө бараг ажил хийдэггүй. Боломжийн орлоготой, бас боловсролтой. Өндөр халамжин дор сайхан амьдардаг хэдий ч хөгжилтэй гэж хэлэхгүй. Баялаг байхгүй мөртлөө хөгжчихсөн орон байна. Боловсрол, эрүүл мэнд болон санхүүгийн үйлчилгээ, далайн тээвэр, мэдээлэл технологиороо хөгжөөд ард түмний амьдрал нь дэлхийд тэргүүлэх зэрэгт очсон Сингапур, Япон, Солонгос зэрэг орныг нэрлэж болно. Улс орон нь хөгжингүй, ард түмэн нь бүтээгч.

Миний илтгэл дээр ярьсан гол зүйл нь Монгол Улс тодорхой хугацааны дараа ийм хөгжингүй, бүтээгч орон болох ёстой гэсэн санаа юм. Тэгэхийн тулд бид хоёр гурван зүйл дээр анхаарах ёстой юм байна. Эдгээр улсын хамгийн гол ялгаа нь засаглалаас хамаардаг. Нээлттэй, ил тод, олонхийн оролцоотой ийм засаглалтай оронд хөгжил дэвшил ирдэг. Зөв засаглал гэдэг бидний сонгосон ардчилсан тогтолцооноос гадна Сингапурын тогтолцоо бол маш зөв хэлбэр. Засаглал хоёр түвшинд байна. Төрийн засаглал нь нээлттэй тунгалаг байх ёстой. Дараагийн шатанд байгаа хэлбэр нь өмчийг хуваарилах компанийн засаглал.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монголын зах зээлийн нийгмээс өвлөж авсан хувийн хэвшлийн, үндэсний аж аухйн нэгжүүдийн гээд дэвшилттэй зүйлүүд бий. Гэхдээ эдгээр нь засаглалын нэг л хэлбэр буюу цөөнхийн засаглал руу явчихсан. Цөөнхийн гарт илүү их эрх мэдэл, хуваарилалт төвлөрсөн байна. Үүнийг шийдэж чадаагүй улс орон хөгжиж чаддаггүй юм байна. Компанийн засаглалыг яаж ил тод, тунгалаг болгох вэ, цөөнхийн засаглалыг яаж олон нийт, ард түмнийх болгох ёстой вэ гэдэг асуудлыг шийдчихсэн жишиг байна. Тухайлбал, хамгийн ойрын жишээ авахад БНХАУ-ыг нэрлэж болно. Дэлхийн эдийн засгийн төв, 10 жилийн дараа АНУ-ын өмнө гишгэнэ гээд л ярьдаг. Тэд хөрөнгийн зах зээлээ маш сайн хөгжүүлж, ард иргэд нь энэ зах зээл рүүгээ идэвхтэй орж чадсан. Улс орноо маш хурдацтайгаар ядуурлаас гаргаж байгаа орон. Засаглалаа маш ойлгомжтой цөөнхөөс олонхи руу шилжүүлж чадсан байгаа юм.

-Намын бодлогыг үүнд чиглүүлэх асуудал хэцүү биш үү?

МАН бол ардчилсан үзэл баримтлалтай, зүүн төвийн нам. Энэ намын үндсэн үзэл бол нийгмийн амьдрал, хүний эрүүл мэнд, боловсрол,ажил тэтгэвэр тэтгэмж гээд энэ бүх асуудал дээр анхаарлаа төвлөрүүлдэг. Хүний амьдрал чадалтай, чадваргүй гээд янз бүрийн хувь тохиолтой. Үүнд төр л зохицуулалт хийх учиртай. Төр нь эдийн засгийн шударга хуваарилалтыг хангаж, зохицуулалтыг хийж өгөх ёстой. Үүнийг ярих биш ажил болгох механизмыг гаргаж ирсэн нь хөрөнгийн зах зээл. Төрийн өмчийн компаниуд хувьчлагдаад нэг эзэн, нэг компанийн гарт очдог бол үүнийг больё гэдэг санаа юм. “Оюутолгой”, “Тавантолгой”, “Эрдэнэт” гэх мэтийн хувьчлалыг хөрөнгийн зах зээлээр явуулна. Хэн нэгэн 2-3 олигарх нийлээд хувьчлаад авч болохгүй юм. Монголын нийт 2.7 сая хүн амд энэ боломжийг ижил гаргаж өгнө. Ингэж олонхийн нээлттэй, ард түмний засаглал руу явуулна.

Сүүлийн үед би томоохон компаниудыг хөрөнгийн зах зээл руу гар гэдэг шаардлага тавьж байгаа. Тэгэх юм бол тэдний хөрөнгийн зах зээлийн тоглоомын дүрэм, зохицуулалт нь олон улсын жишиг, стандартад хүрнэ. Сүүлийн хоёр жил энэ чиглэлээр хатуу шаардлага тавьж ажиллаж байна. Хөрөнгийн зах зээл, зөв засаглалыг гаргана гэдэг жинхэнэ нөгөө олигархжсан засаглалаа ард түмний компани болох засаглал руу шилжүүлж буй үндсэн хэлбэр. Үүн рүү том компаниуд бүгд орох ёстой. Түүнээс биш, ганц хоёр хүнийг ажлаас нь халж хаяснаар энэ засаглал сайжрахгүй байна. Сайжирдаг байсан бол сайжрахаар л цаг хугацаа боллоо шүү дээ.

Өвчний оношийг зөв тавиад, тэгээд эмчлэх хэрэгтэй. Эрх мэдэл, өмчийн хуваарилалтыг ил тод болгоод өгвөл улс төр рүү нөлөөлдөг нөлөөлөл нь ил тод болоод л эхэлнэ. Төрийн үйлчилгээ дарамт шахалт биш, ил тод төрийн үйлчилгээ байх ёстой. Зөвшөөрлийн тогтолцооноос бүртгэлийн тогтолцоо руу оруулъя гэсэн үг. Бүртгэдэг түшмэл өнөөдөр олигарх болчихоод байна шүү дээ. Энэ этгээдийг бүртгэдэг ажилтан болгоё. Ингэхийн тулд стандарт тавьж өгнө. 17 шаардлага хангасан хүн автоматаар зөвшөөрлөө авдаг ийм стандарт тогтоож өгье. Ингэвэл олигархжсан компани, олигарх түшмэдүүдийн ажил аяндаа нээлттэй, тунгалаг болоод ирнэ. Энэ агуулгаар би илтгэл тавьсан.

Систем оношилгоогоо зөв тавьж, ямар технологиор ямар засаглалыг гаргах вэ гэдэг асуудал бол шинэ хандлага. Үүнийг зөв гаргаж ирэх асуудлыг агуулгаар нь ярьж, нийгэмд зөв ойлгуулж, зөв бодлого болгож явуулах хэрэгтэй байгаа юм. Сэтгэлгээний өөрчлөлт ч бас бидэнд хэрэгтэй байна. ■

http://www.mongolianeconomy.mn

Асуудал

Түвэгтэй бизнесийн түгшүүр

И.Отгонжаргал

Бухимдуулах нэг өдөр байхад тайвшруулах өдөр бас бий гэдгийг нефтийн бүтээгдэхүүн импортлон борлуулагчид харуулж байх шиг. Өнгөрөгч нэгдүгээр сарын эхээр шатахууны үнийг огцом буюу литр тутамд 260-300 төгрөгөөр нэмэгдүүлсэн билээ. Харин Цагаан сарын өмнөхөн ихэнх шатахуун түгээх станц үнээ 50 төгрөгөөр бууруулаа. Цагаан сарын үеэр шатахууны үнэ ийнхүү буурч байгаа нь өндөр үнэтэй хоол хүнс, дээл хувцас, бэлэг сэлтэд хэтэвчээ хоосолсон монголчуудад олзуурхууштай л хэрэг.

Нөгөө талаас бараг хоёр сарын өмнө нэгэн баасан гаригийн орой шатахууны үнийг түүхэнд байгаагүйгээр нэмж олон нийтийн бухимдлыг оволзуулсан импортлогчид гэмээ цайруулж байгаа нь яамай даа. Гэхдээ шатахууны үнэ шат дараатай буурч байгаа ч бензиний үнийн огцом өсөлтөөс үүдэн үүссэн өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн хөөс дарагдахгүй, харин ч баяр ёслолыг далимдуулан улам даамжирч байгаа нь тун ч таагүй.

Монголд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, байгууллага нэг бус бий ч нэрнээс цаашгүй амьгүй албатууд учраас шатахууны үнээс улбаатай өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг буцаагаад буурах ёстой гэж хэл үг, хэрүүл тэмцэл хийх нь огт үгүй. Харин шатахууны үнийн өсөлт дээр С.Ганбаатарын тэргүүлдэг МҮЭХ-ныхон сайн ажиллалаа. Тэдэнд олон нийтийн өмнөөс талархал илэрхийлсэн ч болно. Ам.долларын өсөлттэй холбоотой үнээ огцом өсгөсөн нефтийн бүтээгдэхүүн импортлогчидтой тус байгууллагынхан сайн “үзэлцлээ”. Эцэст нь ялалт байгуулав.

Монголын эдийн засгийн форум болохтой холбоотой урьдчилсан хэлэлцүүлгүүдийн нэг нь “Нефтийн бүтээгдэхүүний хараат байдал, даван туулах нь” сэдвээр болсон. Газрын тосны газрын даргын үүрэг гүйцэтгэгч, НИК компанийн захирал нар тус хуралд илтгэл тавьж оролцсон. Уг хурлын үеэр МҮЭХ-ны төлөөлөл болох залуучууд өнөөдөр ам.долларын үнэ харьцангуй суларч, төгрөгийн ханш чангарах төлөвтэй байхад яагаад үнээ бууруулахгүй байгаа юм бэ? Хоёрдугаар сарын 8-ны дотор бууруулна гэж Засгийн газрын гурван талт зөвшилцлөөр хэлэлцэж тохирсон шүү дээ гэж баримт дэлгэн харуулж байсан.

Албаны болон хувийн секторыг төлөөлсөн дээрх хоёр илтгэгчийн хэнийх нь ч амнаас үнэ бууруулахтай холбоотой үг унаагүйд хуралд оролцогчдын олонх нь бухимдаж байлаа. Харин дараахан нь “Шунхлай” компаниас эхлээд үнээ бууруулж, өнөөдөр ихэнх шатахуун түгээгүүрийн ханшийн самбарт литр тутамд 50 төгрөгөөр доошилсон ханш харагдаж, иргэдийг жаахан тайвшруулж байна.

Төр өөрчлөлт авчирч чадах уу

Нефтийн бүтээгдэхүүний импортыг төр гартаа авах тухай асуудал шинээр сөхөгдөн яригдаж буй. Одоогоор хэн ч үүнийг зөв буруу гэж шүүмжлэх, дүгнэн цэгнэх боломжгүй байна. Харин НИК компанийн гүйцэтгэх захирлын хувьд “Бид өнгөрсөн хугацаанд газрын тосны газар гэж Засгийн газрын агентлагтай байнга хамтарч ажиллаж ирсэн. Төр өнөөдөр импортыг гартаа авснаараа яг юуг яаж сайжруулахыг ойлгохгүй байна” гэж хэлж байсан. Цаанаас авахдаа өөр өөр үнээр авдаг ч дотоод зах зээлд нефть импортлогчдын хувьд үгсэн хуйвалдах, ашиг олох нь их байна гэсэн хардлага төрд бий. Тиймээс төр импортыг гартаа авч, одоогийн импортлогчдод дотоодын жижиглэн худалдаалах зах зээлийг нь даалгана гэсэн төсөл байгаа билээ.

Импортлогчдын хувьд улсын хэрэгцээ шаардлагын өмнөөс хүнд хэцүүг үүрэн ажилладаг нь үнэн. Тэдэнд дотоод, гадаад зах зээлтэй холбоотой тоочиж барахгүй хүндрэл бэрхшээл бий байх. Гэхдээ зарим тохиолдолд үнээ үгсэн хуйвалдаж, өгсөөдөг нь оргүй зүйл биш гэдэг нь нэг бус удаагийн үйлдлээр батлагдсан гэхэд хилсдэхгүй. Төрөөс шатахууны үнийг тогтвортой байлгахтай холбоотой төрөл бүрийн дарамт шахалт байдаг учраас тэд ихэнхдээ тэсч тэвчдэг. Гэвч заримдаа тэсэрч дэлбэрч дур мэдэн үнээ огцом нэмдэг сул талтай. “Импортлогчдын хувьд өнгөрөгч сард үнээ огцом нэмсэн нь олон жилийн алдагдлаа нөхөх гэсэн ч байж болох юм” гэдэг санааг МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш доктор, профессор Б.Эрдэнэбат хэлэв. Тэрбээр “Газрын тосны цочрол ба Монгол I” судалгааг бие даан хийсэн учраас нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн учир начрыг сайн мэдэх нэгэн.

Шатахууны үнийг огцом өсгөж, бас бууруулж явж болох ч энэ бол аль аль талдаа урт насгүй, хорон зүйл. Хэрвээ энэ байдал удаан үргэлжилбэл монголчуудад үнэтэй битгий хэл, “Төмөр хүлгээ” тэжээх хоолгүй ч болох эрсдэл бийг үгүйсгэх аргагүй. Учир нь, манай улсын эрс өсөн нэмэгдэж буй нефтийн бүтээгдэхүүний хэрэгцээнийхээ 98.2 хувийг ОХУ-аас, нэг хувийг БНХАУ-аас, 0.6 хувийг БНСУ-аас импортолж буй. Энэ нь стратегийн бүтээгдэхүүний хувьд үндсэндээ бараг ганц улсын зуун хувийн хараат байдалтай байгаа гэж ойлгож болох

http://www.mongolianeconomy.mn

юм. Энэ байдал нь Монгол Улсыг ч, нефтийн бүтээгдэхүүн импортлогчдыг ч байнгын хүнд байдалд байлгадаг гэсэн үг.

НИК компанийн гүйцэтгэх захирал М.Халиунбат “Энэ бизнес улам бүр түвэгтэй болж байна” гэж дээрх хэлэлцүүлгийн үеэр онцлон тэмдэглэж байсан.

Уул уурхай, дэд бүтэц, аж үйлдвэрлэлийн томоохон бүтээн байгуулалтын ажил эрчимжиж байгаатай холбоотойгоор манай улсын нефтийн бүтээгдэхүүний хэрэглээ эрс өсөн нэмэгдэж буй аж. Тухайлбал, өнгөрсөн онд гэхэд л 1,040,336 тонн шатахуун импортолсон байна. Энэхүү хэрэглээг 2009 онтой харьцуулахад 61.4 хувиар, 2010 оноос 26,1 хувиар тэлсэн аж. Газрын тосны хэрэг эрхлэх газраас хурдацтай өсч буй хэрэглээг 2015 онд гэхэд 1.5 сая гаруй тоннд хүрнэ гэж таамаглажээ. Шатахууны импортын төрлийн хувьд авч үзвэл өнгөрсөн онд импортолсон нефтийн бүтээгдэхүүний 60 хувийг дизелийн түлш эзэлжээ. Энэ нь мөнөөх л уул уурхай, дэд бүтцийн бүтээн байгуулалт эрчимжсэнтэй холбоотой.

Хараат байдлаа хэрхэн бууруулах вэ

ОХУ-ын дотоодын зах зээлд хомсдол үүссэнтэй холбоотойгоор бензиний экспортын татвартаа өнгөрөгч аравдугаар сараас 60-66-90 гэсэн томьёолол хэрэглэж тооцох болсон байна. Энэ нь Нефтийн экспортын татварыг дэлхийн зах зээл дээрх Урал брендийн өнгөрсөн сарын дундаж үнээс 60 хувиар, бензиний татварыг Нефтийн татварын 90 хувь, дизелийн түлшний татварыг Нефтийн татварын 66 хувиар тооцох болсон гэсэн үг.

Оросуудын нефтийн бүтээгдэхүүний экспортдоо тавьсан шинэ бодлого үүгээр дуусаагүй. “Роснефть” Монгол Улсад нийлүүлэх нефтийн бүтээгдэхүүндээ минимум квот тогтоож, Заавал худалдах, худалдан авах гэрээ байгуулжээ. Энэ хүрээнд Монголд сар тутамд Аи-92 10,000 тн, зуны дизелийн түлш 40,000 тн, өвлийн түлш 30,000 тонныг нийлүүлэхээр тусгасан байна. Ийн хатуу нөхцөл тулгасан ч Монгол Улсын хувьд яаж ийгээд авахаас аргагүй. Бидэнд “Нөхцөл хатуу байна, авахгүй” гэж хэлэх эрх байхгүй.

Энэ бүхэн юу хэлж байна вэ гэвэл Монгол Улсын нефтийн бүтээгдэхүүний хангалтын асуудал улам бүр түвэгтэй, түгшүүртэй болж байгааг харуулж байгаа хэрэг. Нэг үгээр хэлбэл, гарц хайх цаг үнэхээр болжээ гэдгийг илтгэж буй юм. Харин Монгол Улс нефтийн бүтээгдэхүүний хувьд нэг улсаас хараат байдлаа хэрхэн бууруулж, хэзээ дотооддоо газрын тос боловсруулах үйлдвэр барих вэ гэдэг хамгийн чухал асуудал юм.

Газрын тосны газрын даргын үүрэг гүйцэтгэгч П.Сарангэрэлийн хэлснээр манайд өнөөдрийн байдлаар 18 хайгуулын талбайд 14 компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 300 мянгаас хоёр сая хүртэл тоннын хүчин чадалтай газрын тос боловсруулах үйлдвэр барих зөвшөөрлийг таван компани аваад буй аж. Гэхдээ энэ тавын дотор зуун хувь үндэсний гэсэн тодотголтой компани одоогоор байхгүй.

Тэгэхээр манай нефтийн бүтээгдэхүүн импортлогч дотоодын компаниудын нэгдэн нийлж үндэсний үйлдвэр барих хүсэл, зориг нь хэр байдаг юм бол доо гэж бодогдоход хүргэж буй юм. Хүсэл сонирхол нь байгаад хөрөнгө хүч, техник технологийн тал дээр туршлага дутаж, төрийн тодорхой бодлого үгүйлэгддэг байж ч болох.

Юутай ч Дархан, Зүүнбаян, Эрдэнэт, Дорнод, Чойр, Сайншандад газрын тосны жижиг үйлдвэр барих төслүүд бий аж. Хамгийн тоймтой тодорхой нь гэвэл Дархан-Уул аймагт баригдах “Дархан газрын тос” компани. Тус компанид Японы хөрөнгө оруулалттай “Монголсэкию” компани болон Монголын “Петровис”, “Жаст”, “Магнай трейд” зэрэг компани консерциум болж оролцсон аж. Өнөөдрийн байдлаар хийгдэж байгаа ажил гэвэл “Дархан газрын тос” компанид төрийн хувь оролцоо ямар байх вэ гэдгийг тодорхой болгох Ажлын хэсэг ажиллаж байгаа гэсэн. Мөн “Дорнод газрын тос” компанид ч төрийн хувь оролцоог ямар байлгах талаар ярилцаж байгаа гэнэ. Яриад суух биш, дотооддоо жаахан ч гэсэн газрын тос боловсруулах ажлыг цаг алдалгүй хийж эхлээч ээ гэдэг саналыг салбар бүрийн олон хүн хэлж, тэмдэглэж байсан юм. Алт, зэс, нүүрс тэргүүтэй 80 төрлийн ашигт малтмал



хэвлийдээ тээсэн Монгол нутаг газрын тосны нөөц ч чамлахааргүй бий. Харин чанга атгаж, “чулуу” болгох эсэх нь зөвхөн монголчуудын ур ухаан мэдэх хэрэг. Манай улсын газрын тосны баталгаат нөөц 196 сая тонн бөгөөд үүнээс ашилалтын баталгаат нөөц 20.17 сая тонн. Монголын газрын тосны олборлолтод монополь эрхтэй оролцож ирсэн “Петро Чайна Дачин Тамсаг” компани гэхэд л 1993 оноос хойш нийт 5.3 сая тонн түүхий нефть олборлож, экспортолсон тухай баримтыг дурдахад Монгол Улсын дотооддоо газрын тос боловсруулах үйлдвэр барих шаардлагыг тодотгож буй хэрэг.

Улсын нөөцгүй нөөц

2017 он хүртэл газрын тос, нефтийн бүтээгдэхүүний чиглэлээр төрөөс баримтлах бодлогыг дөнгөж одоо гаргаад буй. Үүнд Газрын тосны хууль эрх зүйн орчныг сайжруулах, газрын тосны үндэсний аж үйлдвэрийн суурийг бий болгож, салбарыг хөгжүүлэх, газрын тосны хайгуул, орборлолтыг нэмэгдүүлэх зэрэг цөөнгүй сайхан асуудлыг тусгаж өгчээ. Үйлдвэр барих асуудал эртнээс яригдсан. Гарц шийдэл нь бий ч ажил урагштай явахгүй байгаа болохоос. Үйлдвэртэй болохоос өмнө Монголын өнөө маргаашийн хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудал бас бий. Энэ нь газрын тос боловсруулах үйлдвэр баригдах хүртэл нефтийн бүтээгдэхүүний хэрэгцээгээ хэрхэн тогтвортой хангах вэ гэдэг юм. “Петровис” компанийн гүйцэтгэх захирал Д.Энхчимэг “ОХУ-д сонгууль болох гэж буйтай холбоотойгоор дотооддоо жижиглэнгийн үнээ хатуу барьдаг. Татварын өндөр тариф тавиад байгаа. Тэдэнд бэлэн бүтээгдэхүүн

http://www.mongolianeconomy.mn

гаргах сонирхол төдийлэн байхгүй байгаа” хэмээн ярьж байсан. Тэгэхээр Монголд сонгууль болохтой зэрэгцэн хойд хөршид Ерөнхийлөгчийн сонгууль болно. Харин монголчуудад сонгууль болтол шатахууны үнэ нэмэгдэхгүй байх гэсэн таамар байна. Учир нь, улстөртэй холбоотойгоор гадаад зэх зээлд юу ч болж байсан улстөрчид дотоодын үнийг яаж ийгээд зохицуулж барина. Харин сонгууль болсны маргаашнаас л байдал эвгүйдэж мэдэх байх шүү гэсэн таамгийг олон нийт дэвшүүлж байна. Дотоод зах зээлд ийм таамаг дэвшүүлж болох ч харин гадаад зах зээл буюу дангаараа Монголын нефтийн зах зээлийг барьдаг ОХУ-д сонгуультай холбоотой ямар нөхцөл байдал үүсэхийг хэн ч таашгүй. Тиймээс газрын тосны газрын даргын үүрэг гүйцэтгэгч П.Сарангэрэлийн хувьд дотоодынхоо нефтийн бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэхэд анхаарах нь хамгийн ойрын зорилт болоод байна гэдгийг онцгойлон тэмдэглэж байсан.

Өнөөдөр манайд стратегийн бүтээгдэхүүн болох нефтийн бүтээгдэхүүний улсын нөөц байдаггүй гэж хэлж болно. Энэ нь, төрд нефтийн бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх агуулах сав байдаггүйтэй холбоотой. Тиймээс хэлтэй амтай ч гэсэн бүхэл бүтэн улсын нефтийн бүтээгдэхүүний хангамжийн асуудлыг хар толгойгоороо хариуцаж ирсэн хувийн 10 гаруй импортлогч компанийнхаа савыг төр ашигладаг гэсэн үг. Ахиухан савтай компанийн савыг төр түрээсэлж, тодорхой хэмжээгээр бүтээгдэхүүн хадгалдаг байна. Гэхдээ энэ нь өчүүхэн бага. Үндсэндээ улсын нөөц нь зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын бүтээгдэхүүний нөөцөөр тодорхойлогддог гэж үзэж болох юм. Харин Сарангэрэл “Улс яаралтай өөрийн нөөцтэй болох ёстой. Юуны өмнө дөрвөн чиглэлд нийт 60 мянган тоннын нөөц бүрдүүлэх хэмжээний савны зураг төсөл гаргаад байгаа. Санхүүжилтийг нь яаралтай шийдүүлэхээр Засгийн газарт асуудлыг өгсөн” гэж мэдээлсэн. Яг өнөөдрийн байдлаар А92 26 хоногийн, А-80 20 хоногийн, дизелийн түлш 10 хоногийн нөөцтэй байгаа /Хоёрдугаар сарын 8-ны байдлаар/ аж.

Сонгуулийн жил улстөрчдийн зүгээс иргэдэд хайр зарлах нь их ч эцсийн дүнд нь үр тариа, ургац хураалт, бензин шатахуун гээд бүх салбарт эрсдэл өндөртэй байдаг нь олон жилийн туршлагаасхарагдсан.Тиймээснефтийн бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх асуудал түгшүүртэй бизнесийн хамгийн ойрын түгшүүр юм. ■



Төсөв

Төсвийн зарцуулалтад Дулмаа анхаарна

Б.Уганбаяр

Хөлс хүчээ шингээж олсон нэг төгрөг ч гэсэн үнэ цэнэтэй санагддаг. Тэгвэл хүн бүр хөлс хүчээ дуслуулан олсон тэрхүү орлого бүрээсээ тодорхой хэмжээгээр татварт суутгуулж байдаг. Харамсалтай нь манай монголчуудын хувьд миний орлогоос авч байгаа энэ мөнгө хэнд хэрэгтэй вэ, үр дүн нь юу байх вэ гэдгийг нарийн бодож тунгаадаггүй. Нэг үгээр хэлбэл, татвар төлөгчдийн мөнгөөр бүрдэж буй улсын төсвийн зарцуулалт зөв, буруу явах нь иргэн Доржид нэг их хамаатай зүйл биш санагдаж, харин ч эсрэгээрээ улс мөнгөө яаж зарцуулах нь надад падлийгүй гэсэн бодол тээн явах нь бий. Гэтэл “Татвар бол соёл иргэншлийн төлөө өгч буй бидний төлбөр юм” хэмээн нэгэн мэргэн хүн хэлсэн байдаг тухай эдийн засагч Д.Жаргалсайханы хэлснийг ишлэе. Аж ахуйн нэгж, малчин, эмч, цагдаа гээд хүн бүхэн л ямар нэг хэмжээгээр төрд татвараа төлж байдаг. Энэ нь эргээд иргэдийн ая тухтай, эдийн засаг, эрүүл мэнд, эрх чөлөөний хувьд аюулгүй байх нөхцөлийг бүрдүүлж өгдөг гэж энгийнээр хэлж болно.

Төсвийн мөнгө байр, сургалтын зардал болж байна

Төсвийн зарцуулалтад иргэдийн оролцоо чухал гэдгийг гуравдугаар сарын 5-6-нд Төрийн ордонд болох Монголын эдийн засгийн чуулганаар тусгайлан хэлэлцэх юм. Тус чуулганы үгтаж “Төсвийн зарцуулалт ба татвар төлөгчдийн хяналт” сэдэвт хэлэлцүүлэг болсон юм. Энэ үеэр төсвийн зарцуулалтад иргэдийн хяналт, оролцоо чухал байгааг хуралд оролцогч албаны болон иргэний нийгмийн байгууллагын хүмүүс баримт жишээгээр хэлж байлаа. Тухайлбал, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь “Улсын төсвөөс өнөөдөр хэн нэгэн төрийн албан хаагч аав, ээж, аль эсвэл үр хүүхдэдээ гурван өрөө байр ч өгсөн байсан. Түүнчлэн »

http://www.mongolianeconomy.mn

БОАЖЯ-ны нэг мэргэжилтэн гэхэд л төсвийн мөнгөөр гадаадад дөрвөн удаа магистрын сургалтад сурсан байх жишээтэй. Өнөөдөр манай төсвийн хяналт, зарцуулалт иймэрхүү л яваа" гэв. Төсвийн ил тод байдлын чиглэлээр сүүлийн арваад жил дагнан судалгаа шинжилгээ хийн ажиллаж байгаа тэрбээр төсвийн зарцуулалтад иргэдийн хяналт, оролцоог бий болгох чиглэлээр хэлэх ярих зүйл бишгүйтэй нь анзаарагдсан. Мөн "Улстөрчид иргэдээ төлөөлөх биш, өөрсдийгөө хоохойлох зорилгоор төсвийн мөнгийг зарцуулж байна. Түүнчлэн төсвийн мөнгөөр юунд хөрөнгө оруулалт хийхээ л ярьдгаас үүнийг хийснээр ямар дүн гарах тухайгаа тодорхойлж хэлдэггүй" хэмээн эдийн засагч Д.Жаргалсайхан онцолсон. Дээр нь аж ахуйн нэгжийн татварыг ашгаас нь биш орлогоос нь авдаг буруу систем байсаар байгааг тэрбээр санууллав.

"Онч Аудит" ХХК-ийн ерөнхий захирал Д.Ончинсүрэн "Иргэн бүр л төсвийн зарцуулалтад хяналт тавьж, өөрийнхөө эрхийг эдэлж байх ёстой. Тэгж байж баталгаатай ирээдүйг өөрөө бүтээж чадна" гэдгийг дурдсан. Нөгөө талаас төсвийн зарлагыг хянаж байдаг төрийн аудит болон төсвийн зарлагын Дэд хороо ажлаа ёс төдий хийж, үүргээ огтхон ч биелүүлэхгүй байгааг ч тэрбээр хэлсэн. Харин хууль тогтоогч, хэрэгжүүлэгч УИХ, Сангийн яамны төлөөлөл төсвийн зарцуулалт тал дээр арай өөр байр суурьтай байв. Сүүлийн хоёр жилийн хугацаанд төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйг сайжруулах чиглэлээр дорвитой өөрчлөлт хийгдсэн гэдгийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга Д.Зоригт онцоллоо. Түүний хэлснээр Төсвийн тухай хуулийг шинэчлэн баталж, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиуд болон холбогдох дүрэм журмыг нь баталсан нь эерэг үр дүнг авчирна гэж үзэж байгаа аж.

Тэгвэл "Иргэд төсвөө хянана" иргэний нийгмийн сүлжээний зохицуулагч Д.Цэрэндорж "Шинээр гарч буй хууль тогтоомж, дүрэм журам ерөнхийгөөс тодорхой чиглэлд явж байгаа ч аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтнууд хуулиа тэр бүр мөрдөхгүй. Төсвийн мөнгийг үргүй зарцуулсан алдаа дутагдал гарсан ч хариуцлагын тогтолцоо байхгүй байгаа тухай сөргүүлэн хариулсан. Тэрбээр төр, засгийн байгууллагынхан хурал дээр төсөв мөнгө хүрэлцэхгүй хэцүү байна гэж зовлон тоочдог хэрнээ өөрсдийнхөө ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх болохоороо хаанаасаа гаргаад ирдэг байна аа гэж гайхахаар хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулдаг. Би зураг хөрөгтэй нь жишээ татья. Баянзүрх дүүргийн төр, захиргааны ордон, Нийслэлийн төр, захиргааны "Хангарьд" ордон гээд сүрлэг барилгууд баригдсан. Одоо нийслэлийн Сүхбаатар дүүргийн төр, захиргааны байр, Хан-Уул дүүргийн төрийн үйлчилгээний байр гэж бас том барилгууд баригдаж байна. Сүүлийн хоёр, гуравхан жилийн дотор сүндэрлэсэн төрийн барилгуудаас жишээ татахад энэ. Эндээс төрийн хүмүүс татвар төлөгчдийн мөнгийг өөрсдийн хэрэгтэй гэсэн зүйлд гар татахгүй зарцуулаад, иргэдэд хэрэгтэй зүйлд тэр бүр зарцуулахгүй байгаа нь харагдаж буй хэрэг юм" гэж хатуухан шүүмжилсэн юм.

Аймаг нийслэлийн төсвийн ил тод байдал /оноогоор/

Жич: Тус судалгааг гаргахдаа үндсэн 60 асуултын дагуу 100 хүртэлх оноо өгч аймгуудын төсвийн ил тод байдлыг нь дүгнэжээ. Үүнд хамгийн өндөр оноо авсан Ховд аймаг гэхэд л боломжит онооны талд нь хүрээгүй байна. Мөн нийт аймгуудын дундаж оноо нь 32.5 байгаа нь орон нутгийн түвшинд төсвийн ил тод, нээлттэй байдал маш хангалтгүй байгааг илтгэж байна.

Аймаг/нийслэл	Оноо
Ховд	47.2
Улаанбаатар	45.0
Архангай	42.2
Сэлэнгэ	40.2
Увс	39.9
Булган	38.0
Завхан	36.3
Төв	36.0
Дорноговь	35.9
Говь-Алтай	35.6
Дорнод	35.0
Баян-Өлгий	33.2
Өмнөговь	31.7
Өвөрхангай	29.3
Хөвсгөл	29.0
Говьсүмбэр	28.9
Сүхбаатар	28.0
Дархан-Уул	25.8
Баянхонгор	22.7
Хэнтий	19.9
Орхон	19.5
Дундговь	15.0

Эх сурвалж: Нээлттэй нийгэм форум "Орон нутгийн төсвийн ил тод байдал-2011" судалгааны тайлан

Тойргийн мөнгө ба төсвийн тодотгол

Монгол Улс хөрөнгө мөнгөтэй болж, төсвийн хэтэвч зузаарахын хэрээр сайн засаглалын асуудал суларч байгааг ч олон хүн хэлсэн. "Олон улсын төсвийн түншлэл" хэмээх байгууллагаас Монголын Засгийн газар төсвөө хэр ил тод нээлттэй хэлэлцэж, шийдвэрлэж байгааг судлахад 2008 онд 36 хувьтай гарсан бол 2010 онд 60 хувь болж дээшилжээ. Энэ уг нь сайхан мэдээ ч бодит хөрсөн дээрээ буюу хуулийн хэрэгжилт, гүйцэтгэл тийм ч хангалттай биш байгааг Нээлттэй нийгэм форумаас гаргасан судалгаа эсрэгцүүлэн баталж байна. Тус байгууллагын судалгаа хөдөө, орон нутгийн төсвийн ил тод байдал дунджаар 34 хувьтай байгааг тогтоожээ. Энэ нь төсвийн зарцуулалтад иргэдийн хяналт, оролцоо хангалтгүй байгаагийн тод илрэл. Дээр нь олохынхоо хэрээр үрэлгэн загнадаг зан ч манай төсөвт ажиглагдаж байна.

"УИХ, Засгийн газрын гишүүдэд тойргийн мөнгө бий болсноос хойш хариуцлага нь эрс муудсан. Ойр, ойрхон төсвийн тодотгол хийдэг байдал үүнийг баталж байгаа юм. УИХ, Засгийн газар цаашлаад хөдөө, орон нутгийн эрх баригч, төлөөлөгчид гэх мэт төсвийг баталж, боловсруулахад оролцдог хүмүүс хоорондоо наймалцдагаас сөрөг нөлөө их байна" гэдгийг Н.Дорждарь шүүмжилсэн. Мөн энэ жилээс улсдаа өрийн хязгаар тогтоож өгсөн нь ч хувийн салбарынхны өрийн хэмжээг анзаарахгүй байгаа нь их эрсдэлийг ч дагуулах магадлалтай гэдгийг тэрбээр мөн онцлов. Учир нь, хэрэв эдгээр улсын томоохон компаниуд дампуурахад хүрвэл өрөө төлж чадахгүйд хүрч, төсвийн мөнгө рүү ороҳдоо тулдаг аж.

Эдийн засгийн чуулганд зориулж, нийт монголчуудад хэрэгтэй нэгэн чухал сэдвээр шийдэл эрэлхийлж, ийн урьдчилан хэлэлцсэн салбар салбарын төлөөллийн сайхан саналууд басхүү ширүүхэн шүүмжлэлүүдийн үр дүн гарна байх гэж найдъя. Ямартай ч иргэд төрөл бүрийн татвар хэлбэрээр төрд төлж буй мөнгийг хэр үр дүнтэй зүйлд зарцуулж байна вэ, үүнд хөрөнгө оруулалт хийснээр иргэн Дулмаа миний амьдралын чанарт өөрчлөлт орж, сайжрах болов уу гэж дүгнэж цэгнэдэг болох хэрэгтэйг дээрх мэргэжилтнүүдийн үг үзэл бодол илэрхийлнэ. Ингэхийн тулд юун түрүүнд иргэдийн саналыг төсөвт урьдчилан тусгах боломж

http://www.mongolianeconomy.mn

бололцоо хууль эрх зүйн орчныг илүү нарийвчлан бүрдүүлэх нөгөө талаас тэдний оролцоог шат шатанд нэмэгдүүлэхэд анхаарч, ойлгуулах хэрэгтэйг "Петровис" ХХК-ийн ерөнхий захирал Ж.Оюунгэрэл хэлэв. Түүнчлэн Төсвийн ил тод байдлын цахим хуудсанд байршуулсан мэдээлэл иргэдэд ойлгомжгүй, хэтэрхий мэргэжлийн байгаа тул хялбаршуулах ажлаа Сангийн яам яаравчуулах хэрэгтэй ч олон хүн санууллаа. Дээр нь хууль, эрх зүйн хүрээнд төсвийг ил тод, олон нийтэд нээлттэй болгох боломжийг бүрдүүлэх гэж оролдсон ч иргэд, татвар төлөгчид, хуулийг хэрэгжүүлэгчид хаа хаанаа тэр бүр биелүүлэхгүй назгайрсан байдалтай байгаа талаар ч санал, шүүмжлэлүүд гарсан. Тиймээс иргэний нийгмийн байгууллагууд идэвх, санаачилгатай иргэдтэй хамтран хууль, дүрмийнх нь дагуу биелэлтийг нь шахаж, шаардаж, үр дүнг нь нэхэж байх хэрэгтэй гэдэгт хуралд оролцогчид эцэст нь санал нэгдсэн юм. ■

Д.Энхбатын булан

"Халамжийн" бодлого

Эрх баригчид маань халамжийн бодлогын талаар их ярьдаг. Хавтгайруулсан халамжийн бодлого бол тэдний төр, засагт тогтох, дахин сонгогдох гол хэрэгсэл нь болдог гэдгийг хүн бүр мэднэ. Ер нь хавтгайруулсан халамжийн бодлогоос өөр тийм хүчтэй, өргөн хүрээтэй хэрэгждэг төрийн том бодлого Монголд бараг л байхгүй болов уу.

Халамжилна гэдэг бол сайхан үг. Гэхдээ халамжийн бодлогууд их олон янз, үнэхээр сайн сайхнаас эхлээд маш аюултай, тэр бүү хэл бүхэл бүтэн улс үндэстнийг устгах, колончлох зориулалттай нь ч байдаг гэдгийг олон хүн анзаардаггүй.

Нарийн судалгаа, шүүлтүүртэй, шаталсан хэтийн зорилготой, ниммийн тодорхой бүлэгт, тодорхой хугацаанд зориулсан сайн бодлого гэж бий. Бас хэнийг ч ялгахгүй хавтгайруулан олгодог, хүсээгүй байхад хүчээр өгдөг, улс төрийн хахуулийн шинжтэй нь ч бий. Чухам аль нь Монголд хэрэгжээд байнаа гэдгийг та өөрөө мэдэх хойно.

Түүхэнд нэгэн "агуу их халамжийн" буюу "ХалаМанж"-ийн гэж миний энд нэр өгөөд буй бодлогын тухай домог байдаг. Энэ бодлого монголчууд бидний хувь заяатай ч цаагуураа холбоотой. Тэр их бодлогын ачаар бид тусгаар тогтнолоо олж 200 гаруй жилийн колончлолоосоо салсан гэхэд бараг хилсдэхгүй. Уг нь энэ бодлогыг Хятадын төрийн нэгэн их түшмэл Монголыг бус харин Хятад орноо Манжийн дарлалаас чөлөөлөх бодолтойгоор бодож хэрэгжүүлсэн гэдэг.

Энэ бодлого нь Манж хүнийг бурхан мэт тахин дээдлэх, хүндэтгэн халамжлах гурван хуулиар хэрэгжсэн байна.

Нэгдүгээрт, Манж хүн бол тэнгэрийн суудалтай учир энгийн иргэн бус заавал ноён байх ёстойг хуульчилсан байна.

Мэдээж хэрэг, тэр олон ноёнд олон зарц, хамжлагат, өөрийн хот, тосгон хэрэгтэй. Нэг тосгонд хоёр захирагч ноён байх боломжгүй учир манж эр бүр өөр өөрийн тосгон, албаттай болохоор их Хятад гүрнээр таран суурьшжээ. Тэгээд тэд бүгдээрээ л ноён болж жаргаж эхэлсэн байлгүй. Харин Манж нутаг эзгүйрчээ.

Хоёрдугаарт, Манж хүн бол тэнгэрийн удамтай учир элдвийн хар ажил хийх ёсгүй, насан туршийн тусгай цалин пүнлүү эдлэхээр хуульчилжээ.

Удалгүй, мужаан, дархан, тогооч, эрдэм мэдлэгтэй манж хүмүүс байхгүй болж бүгд л тогтмол сул цалинтай учир наргиж хэвтэхээс өөр "ажилгүй" болжээ. Газарт ажиллах манж хүн үгүй болж бүх ажлыг нь хятадууд хийдэг болсон байна.

Гуравдугаарт, Манж эр хүн тэнгэрийн хүү учир ямар ч гурван хятад хүүхнийг инж төлөлгүйгээр өөрийн хүслээрээ эхнэрээ болгон авч болохыг дархалжээ.

Тэр үеийн Хятадад сайхан хүүхнийг худалдан авахад их мөнгө төлдөг ёс байсан ч манж эр хүнд энэ ёс хамаарахгүйг хуульчилсан байна. Харин хэдэн жилийн дараа манж эрийн гэр бүл гэж хэн байх билээ ? Мэдээж хэрэг, бүгд хятад хүмүүс байна.

Манж Чин улсын их хааны дэргэд ажиллаж, манж хүнийг бурхан мэт шүтэж, тэднийг хавтгайруулан "халамжлах, хайрлах" хуулийг гаргасан тэр түшмэлийг хятадын ард түмэн үнэхээр үзэн ядаж, урвагчийн дээдээр нэрлэн харааж байсан гэдэг. Тэр түшмэл бол хавтгайруулсан халамжийг бодлогын мөн чанарыг ойлгосон агуу ухаантан байсан байна. Хятад орон 100 жилийн дараа л тэр түшмэлийн их ухааныг ойлгосон гэдэг.

Хэдэн зууны туршид байлдаад дийлээгүй, Их эзэн Чингэсийн Монголыг хүртэл эрхэндээ оруулсан Манжийн их төрийг нэгэн түшмэл ганцаараа, бүр тодруулбал, нэгэн халамжийн бодлогын хүчээр мөхөөн сөнөөсөн ийм нэгэн түүх домог байдаг.

Өнөөдөр Манжийн хүчирхэг үндэстэн хаана байна? Тэд халамжлуулан алга болжээ. Харин тэдний өмнөөс халамжийг нь үргэлжлүүлэн авахыг хүсэгчид та бидний дунд байсаар байна уу ? Сайн хараарай.

Мөн хавтгайруулсан "ХалаМанжийн" агуу муу бодлогыг Монгол нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг хүсэгчид ойр хавьд чинь байна уу? Байх шиг байна аа ...

Харин Та манж хүн шиг халамжлуулмаар байна уу, эсвэл хувь заяаныхаа эзэн монгол хүн шиг өөртөө итгэж, өөдрөгөөр зүтгэж амьдармаар байна уу ? ■

http://www.mongolianeconomy.mn

Төв аймгийн Зуунмод сумын тавдугаар багийн иргэн Г.Эрдэнэмөнх

Ядуурлыг хэрхэн бууруулах вэ?

Ядууралд ялгавартай бодлого хэрэгтэй

Д.Зоригт

Ядуурлын талаар судалдаг цөөхөн эдийн засагч нарын нэг болох доктор С.Даваасүрэнтэй уг асуудлаар ярилцсан юм. Гэхдээ энэ удаа уламжлалт ярилцлагаас зайлсхийж ядуу өрхийн бодит амьдралд тулгуурлаж мэргэжлийн хүний дүгнэлтийг сонсохыг зорилоо.

Өнөөдөр Монгол Улсын эдийн засаг 17 гаруй хувиар өссөн. Үүнийг дагаад ядуурал ч мөн адил өсч 40 орчим хувьд хүрчээ. Уг нь эдийн засаг өсвөл ядуурал буурах учиртай. Яагаад дагаад өсөөд байна вэ?

Бодит байдал ба амьдрал

Хар гэрийн зүүн талын орон дээр 40 гаруй насны эр хэдэн жилийн шороо тоосонд дарагдаж, урд нь ямар өнгөтэй байсан нь үл мэдэгдэх ноорхой хүрмэндээ хамаг биеэ хураан бодол болон суух. Энэ бол Төв аймгийн Зуунмод сумын тавдугаар багийн иргэн Г.Эрдэнэмөнхийнх. Айлын том охин “Амьдрал хэцүү байна аа. Гэр хүйтэн” гээд санаа алдаж, тунгалаг хар нүднээс нь урсан гарах нулимс халтар нүүрэн дээгүүр нь зам татуулах нь өр өвтгөм. Мөнгөнзаяа “Манай ээж дөрөв хоногийн өмнө группын мөнгөө гээчихсэн. Манайх уржигдар гурилаа дууссан. Олон хоног гал түлээгүй хүйтэн байна” гэв.

13-хан насандаа ахадсан амьдралын шуурган дунд хүйтэн гэрт, хоосон ходоодтой өнжих энэ охины мөрөөдөл биеийн тамирийн багш болох, идэх дуртай амттан нь алим. Гэхдээ хэзээ хамгийн сүүлд алим идсэнээ санахгүй байлаа. С.Эрдэнэ-Оюун хэсгийн ахлагчийн хэлснээр гэрийн эзэгтэй Гухъяабазар нь төрөлхийн сэтгэцийн эмгэг өвчтэй аж. Гэрийн гишүүд бүгд тогтсон орлого, эрхэлсэн ажилгүй. Эрдэнэмөнх “Ах нь эхнэрийн группын мөнгө, улсаас өгч байгаа таван хүний 21 мянган төгрөгөөр голоо зогоодог” гэв. Энэ гэр бүлийн хувьд хүнсний ногоо, элсэн чихэр тэр ч бүү хэл давс авдаггүй. “Өлсөхгүй даарахгүй л амьдарч байвал боллоо. Хэдэн төгрөгтэй болчихвол блок цохиод мөнгө олж болох л юм” гэрийн эзний мөрөөдөл энэ. Хэдийгээр сэтгүүлч миний бие дулаан хувцас өмссөн ч гэрт даарсандаа эрүү дагжиж байсан бол дан ноосон цамц өмсөөд танихгүй хүнийг гайхан харж зогсоо тавхан настай жаахан охин хүйтнийг огт ажирсан шинжгүй нусаа хүд хийтэл татна.

С.Даваасүрэн:

-Графикаас харахад нийгмийн халамжийн мөнгө тараалт нэмэгдсэнтэй холбоотой ядуурал мөн дагаад өсчээ. Ямар шалтгаантай вэ гэхээр дээрх мэт өрхийн хувьд нийгмийн халамжийн мөнгө орлогынх нь гол эх үүсвэр болж байгаа нөхцөлд тэдний үзэл бодолд шууд нөлөөлдөг. Магадгүй тэдний ажил хийх сонирхлыг бууруулж болох юм. Ажил хийхийн оронд нийгмийн халамжийн мөнгөөр л өнөө маргаашаа зогоохыг хүсдэг сэтгэлгээ суулгачихсан байж болно. Г.Эрдэнэмөнхийн ярианаас ажиглахад “Блок цохиод мөнгө олж болох л юм” гэснээс биш. Блок цохих гэж хөөцөлдөөгүй байна. Ажиллах хүчний оролцооны түвшин гэж бий. Идэвхтэй ажил хайгч ч гэж хэлдэг. Тэгвэл энэ үзүүлэлт нийгмийн халамжийн мөнгө тараах эхэлснээс хойш долоон хувиар огцом буурсан. Эндээс нийгмийн халамжийн мөнгө тараах нь ядуу иргэдийн ажил хийх сонирхлыг бууруулж, бэлэнчлэх сэтгэлгээ суулгасан гэж таамаглаж болно.

Эх сурвалж: /Ядуурал: Өсөлт ядуурлыг бууруулах уу илтгэлээс/

-Ирэх зургадугаар сард хүний хөгжил сангаас 21 мянган төгрөг олгох хугацаа дуусна. Тэгвэл хүмүүсийн сэтгэлгээ өөрчлөгдөж ажил хийж магадгүй гэж ойлгож болох уу?

-Төрөөс 21 мянган төгрөг өгөх нь зогсвол ядуу иргэдийн хувьд тэдэнд дусал залгаж байгаад гэнэт салгаад хаячихтай адилхан. Тиймээс бүр ч илүү сөрөг нөлөө үзүүлж магадгүй. Нэгэнт энэ мөнгөөр амьдралаа залгуулж байсан иргэд боловсролын түвшин доогуур учраас ажилд тэнцэхгүй улам л ядуурч, амьдрах итгэл үнэмшилгүй

http://www.mongolianeconomy.mn

болж ч болно. Тиймээс төр, засаг энэ талаар эртнээс бодолцох нь чухал.

Бас нэгэн жишээ

Хэдхэн хоногийн өмнө Төв аймгийн Зуун мод сумын тавдугаар багийн иргэн Д.Нямсүрэн гуай хайртай хүүгээ өвчний улмаас алджээ. Тэрбээр хоолой зангируулан "Хүү минь элэгний өвчтэй явсаар эмчлэх мөнгөгүйн улмаас хүндэрч өөд болчихлоо. Хүү маань л манай амьдралыг авч явдаг байсан юм. Морин тэрэг хөдөлгөөд хэдэн төгрөг залгуулдаг байлаа. Хэцүүхэн амьдралтай бидний ганц өмөг түшиг хүү минь байсан. Нөхөргүй дүү охиныхоо дөрвөн хүүхэд, хөгшин намайг, дээрээс нь өөрийнхөө гэр бүлийн хүн гээд өөрөөсөө гадна долоон хүнийг оройн хоолтой, түлэх нүүрстэй байлгадаг" гээд дуу нь тасалдаж буруу харлаа. Хэсэг хугацааны дараа тэрбээр "Ганц морийг маань хулгай аваад явчихсан" гээд дахиад л хоолой нь зангирлаа.

С.Даваасүрэн:

-Энэ айлын жишээн дээр харахад, хуримтлагдсан буюу циклийн нөлөө их байна. Энэ нь тухайн өрхөд бий болсон нэг хүндрэлтэй асуудал өөр нэгэн бэрхшээлийг араасаа дагуулдаг гэсэн үг юм. Дээрх айлын хүү нь эрүүл мэнддээ зарцуулах орлогогүй учраас өвчин нь хүндэрч амь насаа алдсан байна. Өөд болсон хүү нь дээрх өрхийн өдрийн хоолыг залгуулдаг нэгэн байсан бол одоо тэр өрх улам л ядуу болно. Үүнийг "ядуурлын гүнзгийрэл" гэж нэрлэдэг.

2010 онд ядуу хүн амын дунд ядуурлын гүнзгийрэл 29 хувь байгаа нь ядуучуудын хэрэглээ ядуурлын шугамаас (29 хувь буюу) сард дунджаар 25.6 мянган төгрөгөөр доогуур байгааг харуулж байна. Энэ нөлөөг багасгахын тулд нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах шаардлагатай. Учир нь эрүүл мэндийн капитал өндөр байх тусмаа боловсролын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлдэг. Боловсролын капитал хэдий өндөр байна эрүүл мэндийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулна. Эрүүл мэнд эсвэл боловсролд хийж буй хөрөнгө оруулалт нь ирээдүйн өндөр орлогыг бий болгодог. Харин өнөөдөр манайд энэ талын хөрөнгө оруулалт маш бага байгаа.

–Ядуу иргэдийн олонх нь ажил олдохгүй байгаа учраас л амьдрал хэцүү байна гэж гомдоллодог. Ядуурлын талаар судалдаг хүний хувьд манайд ажлын байрны хомсдол хэр их байна вэ?

-Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооноос гаргасан судалгаанаас харахад ирэх таван жилд уул уурхайн их бүтээн байгуулалтыг дагаад инженер техникийн 5000 ажилтан, 30 мянган мэргэжилтэй боловсон хүчний ажлын байрны эрэлт гарч ирнэ гэсэн байсан. Гэвч энэ их эрэлтийг хангах хэмжээний боловсролтой иргэд ядуу иргэдийн дунд хэр олон байгаа билээ. Ажил эрхлэлтийн тоон үзүүлэлтээр 2010 онд 1.7 хувиар ажилгүйдлийн түвшин буурсан ч ядуурал байсаар байна. Тухайлбал, 2009 онд тэгш бус байдлыг илтгэдэг Жини коэффициентийн судалгаагаар 0.31 байсан бол 2010 онд 0.33 болж өсчээ. Орлогын тэгш бус байдал нэмэгдэн баян, ядуугийн ялгаа улам тодрохыг илтгэж байна. Тиймээс нэн тэргүүнд ядуу иргэдийн "сэтгэлгээний ядуурлыг" арилгах ёстой талаар судлаачид зөвлөдөг. Үүний тулд бид нийгмийн суурь үйлчилгээний чанарт анхаарах хэрэгтэй.

Гарц ба шийдэл

Хэдийгээр эдийн засгийн өсөлт нь ядуурлыг бууруулах суурь нөхцөл мөн боловч хүрэлцээтэй байж чадахгүй байгаа талаар Эдийн засгийн форум угтсан "Өсөлт ядуурлыг бууруулах уу" хэлэлцүүлгийн үеэр оролцогчид хэлж байсан юм. Тиймээс ядуурлыг бууруулахын тулд эдийн засгийн өсөлтийн зөв хүрэлцээг бий болгох хэрэгтэй аж.

С.Даваасүрэн:

-Зөв хүрэлцээг бий болгохын тулд доорх асуудлыг нэн тэргүүнд шийдэх ёстой. Үүнд, иргэдийн сонголтын боломжийг нэмэгдүүлэх, өмчийн эрх, хөрөнгө эзэмших боломжийг бий болгох. Энэ ажилд төрийн оролцоо нэлээд чухал. Төр, засгаас ажил хийх нөхцөлийг бүрдүүлж өгөх хэрэгтэй.

Эдийн засгийн өсөлтийн хөдөлмөрийн мэдрэмжийг өсгөх. Энэ нь иргэдийн дунд бэлэнчлэх сэтгэлгээ суулгаж болох бэлэн мөнгө тараахаас аль болох зайлсхийж, ажлын байрыг нэмэгдүүлэх, боловсрол, эрүүл мэндийн салбарыг дэмжихэд анхаарах хэрэгтэй.

Ядуу иргэдийн амьдрах итгэл үнэмшил, үнэт зүйлс, нийгмийн хэм хэмжээг сайжруулах. Ядуу иргэдийн олонх нь дундаж орлоготой иргэдийн амьдралыг үзэх үзлээс явцуу байдаг. Нийгмийн үнэт зүйлс нь хүртэл өөр байдаг. Тиймээс энэ тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй.

Хот, хөдөөд болон зах хязгаарын бүсэд ялгавартай бодлого явуулах. Энэ бол магадгүй ядуурлыг бууруулах хамгийн том хүчин зүйл ч байж мэднэ. Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар орон нутгийн хоёр иргэний нэг нь ядуу амьдралтай байсан. Газар нутгийн хувьд алслагдмал байх тусмаа орлогын тэгш хуваарилалт алдагддаг.

Хуримтлагдсан нөлөө ба циклийн хамаарлыг зогсоох. Энэ нөлөөг зогсоохгүй л бол одоо ядуу байгаа иргэд ирэх хэдхэн жилийн дотор улам ядуурч, баян хооснь ялгаа нэмэгдсээр байна. Бидний хүсээд байгаа ирээдүй бол тогтвортой хөгжил. Үүнд хүрэхийн тулд баян, хооснь ялгааг арилгах нь чухал.

Гэхдээ өнөөдөр ядуурлын эдгээр асуудлыг шийдэхийн тулд хамгийн түрүүнд нарийвчилсан бодитой судалгааг хийх хэрэгтэй байна. Өнөөдөр Монгол Улс ядуурлыг зөвхөн орлогын түвшингээр нь авч үзэж, судалж байгаа. Тэгвэл бид ядууралд эрүүл мэнд, боловсрол, сэтгэлгээ, амьдрах орчны нөхцөл хэрхэн нөлөөлж байгаа зэргийн талаар зайлшгүй судлах хэрэгтэй байна. Ядууралд юу яаж нөлөөлж байгааг мэдэхгүй бол юуг яаж хийх вэ гэдэг нь ч мөн адил тодорхойгүй байгаа гэсэн үг. Товчхондоо ядуурал гэж юу вэ гэдгээ мэдэх хэрэгтэй. Тиймээс эдгээр асуудлыг яаралтай тодорхой, бодитой болгож, тухайн асуудалд тохирсон ялгавартай бодлогыг төрөөс явуулах хэрэгтэй байгаа талаар бидний хэдэн эдийн засагчид ярьсаар ирсэн. Одоогоор төрийн бодлого тухайн нөхцөлд тохирсон ялгавартай байж чадахгүй байна. ■

Инноваци

Мэдлэг зарна

Эртээ урьдын цагт мөнгө олох ганцхан арга байжээ. Энэ нь түүхий эдийг худалдаж, түүнээсээ ашиг олох байсан аж. Тэгвэл өнөөгийн нийгэмд мөнгө олох олон арга гарч иржээ. Хамгийн "супер" нь мэдлэг. Мэдлэг гэх нөөцийг баялаг болгох тэр арга замыг инноваци гэж дэлхий нийт нэрлэдэг. Харин манайд бол шинэ ойлголт юм. ▸▸

http://www.mongolianeconomy.mn

Фотог Э.Зоригт

Энэ талаар ШУТИС-ийн Компьютерийн техник, менежментийн сургуулийн багш, Эрдэм шинжилгээ, инновацийн эрхэлсэн дэд захирал, доктор, профессор Л.Оюунцэцэгтэй ярилцлаа.

-Инновацийн талаар их ярьдаг болжээ. Тэгвэл яг юуг инновацийн гэдэг талаар тайлбарлахгүй юу?

-Энэ талаар сүүлийн үед их ярьж, эрж хайж байгаа нь үнэн. Ерөнхийдөө инновацийн гэдэг нь шинэ зүйлтэй, шинжлэх ухаанч, мэдлэгтэй байх шаардлагатай. Тиймээс мэдлэг гэж юу вэ гэдгээ эхлээд мэдэх нь чухал. Ерөнхийдөө хүний танин мэдэхүйн явцад бий болсон үр дүнг мэдлэг гэж үзээд байгаа. Тухайлбал, малчин биш хүн хөдөө гарч мал маллаад ирэхээр мал сайн мэддэг болно. Энэ нь мэдлэг юм. Мэдлэгийг мэдээллээр дамжуулж авдаг. Тэр олж авсан мэдлэгээ амьдралд ашиглаж сайн үр дүн гарч, ашиг олвол тэр нь инновацийн юм.

-Инновацийг гэж их ярих болсон. Тэгвэл хэрхэн хөгжүүлэх вэ?

-Бид мэдлэгийн эдийн засгийн талаар яагаад яриад байна вэ гэхээр мэдлэг гэдэг ойлголт өөр үүрэг гүйцэтгэж, мэдлэгийг өөрөөр харж эхэлсэнтэй холбоотой. Тиймээс бид эхлээд юуг хөгжүүлэх талаараа мэдэх хэрэгтэй. Өнөөдөр эдийн засгийг бүрдүүлж байгаа ихэнх нөөц хязгаарлагдмал байна. Газрын доорх баялаг, капитал, хүний хөдөлмөр гэдэг ч юм уу. Уламжлалт эдийн засагт эдгээр нөөцийг боловсруулж, нийгмийн хэрэгцээг хангах хандлагатай байсан. Харин одоо мэдлэг нь капиталын үүрэг гүйцэтгэдэг болчихлоо.

Ер нь инновацийн тухай ойлголт хүний хөгжлийн явцад бага багаар хуримтлагдсаар ирсэн тэр мэдлэг, мэдээллийг яаж ашиглах талаар яригдаж эхэлснээс хойш гарч ирсэн гэж хэлж болно. Мэдлэг өөрөө баялгийг бий болгох, үйлдвэрлэл явуулах гол түүхий эд болсон хэрэг л дээ. Байгалийн баялаг бол биш шүү. Өнөөдөр мэдлэгт суурилсан эдийн засаг, мэдлэгийн эдийн засаг гэж хоёр ойлголтын тухай яриад байгаа. Мэдлэгт суурилсан эдийн засаг нь мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, олж авах, ашиглах боломжийг бий болгодог. Харин мэдлэгийн эдийн засаг нь дараагийн үе буюу хөгжингүй шат юм.

Тиймээс эхлээд мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох учиртай. Мэдлэгийн эдийн засаг, инновацийн гэх ойлголтод өнөөдөр заавал бодит зүйл хамаарахгүй. Бидний эдийн засгийн бус гэх нийгмийн салбарууд ч үүнд хамааралтай болоод байна. Тухайлбал, шинжлэх ухаан боловсрол нь мэдлэгийг үйлдвэрлэдэг гол салбар. Уламжлалт эдийн засагт мөнгийг мэдлэг болгох үе шат байсан. Шинжлэх ухаанд хөрөнгө оруулаад, шинэ нээлт хийх, эсвэл сургуульд төлбөрөө төлөөд мэдлэг олж авах ч юм уу. Харин өнөөдөр олж авсан мэдлэгээ баялаг болгох тухайд яригдах тэр олон арга зүй, гарц зэргийг инновацийн гэж нэрлээд судлаад үйл ажиллагаандаа тусгах тал дээр дэлхий нийт анхаарч байна. Тэгвэл манайд мөнгө нь мэдлэг болчихоод цаашаа явахгүй байгаа юм.

-Ямар мэдлэг баялаг болж чадах вэ?

-Хамгийн түрүүнд хүнд хэрэгтэй, үр ашигтай мэдлэг байх нь чухал. Хаа хамаагүй хэрэггүй мэдлэг бол чухал биш. Хүн өөрөө миний олж авч байгаа мэдлэг юунд хэрэгтэй вэ гэдгийг бодох ёстой. Хамгийн энгийнээр хэлэхэд хувь хүн, албан байгууллага, улс орны өмнө тулгамдсан асуудлыг шийдэхэд мэдлэг хэрэг болох учиртай. Нөгөө талаас хүн мэдлэгийг бий болгодог. Тэгэхээр хүнд бас шинэ шаардлага гарч ирж байгаа юм. Хүн тасралтгүй сурах хэрэгтэй. Үүнтэй холбоотой суралцагч байгууллага, суралцагч үндэстэн хүртэл гарч ирээд байна. Энэ нь эргээд өрсөлдөх чадвартай холбоотой. Өрсөлдөхийн тулд бид насан туршдаа суралцах хэрэгтэй. Суралцахын тулд яах вэ? Энэ нь мэдээлэл харилцаа холбооны үсрэнгүй хөгжлөөс шууд хамаарна.

-Инновацид юуг хамааруулж үзэх талаар тодорхой шаардлага байгаа юу?

-Гурван гол хүчин зүйлийг харгалзан үздэг. Нэгдүгээрт, Шинжлэх ухаан технологийн хувьд шинэлэг санаа байх учиртай. Хоёрдугаарт, тэр санаа практикт хэрэгжих бололцоотой байх ёстой. Гуравдугаарт, хүнд хэрэгтэй байх. Ингэж байж л мөнгө болно, мэдлэг. Гэхдээ эдгээр нь яг тийм гэсэн тогтсон дүрэм журам биш л дээ. Мөн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх нь нэн тэргүүний асуудал. Хууль баталгаажиж гэмээнэ инновацийн тухай тодорхойлолт нэг болох юм.

Инноваци хөгжвөл

БНСУ, Японулснь бидний мөрөөддөг тэр ирээдүйг бүтээчихсэн явж байгаа. Тэдэнд байгаль эх, эд баялаг харамгүй заяагаагүй. Гэхдээ эдгээр орон жижигхэн эрэг боолтоос эхлээд, нано технологи хүртэл инновацийг хөгжүүлэх замаар эдийн засгаа тэтгэж чадсан учир өнөөгийн хөгжилд хүрчээ. Харин манай оронд тэднээс илүү боломж, баялаг байгаа. Өөрөөр хэлбэл, байхгүйгээс шинийг бий болгох гэлгүй гаднын тэргүүн туршлага, бүтээн байгуулалт, инновацийг нэвтрүүлснээр Монгол бүтээгч улс болвол бид хүнээс гуйхгүй "хөлд орох" ажээ. Хөлд орохын тулд инновацийг хөгжүүлэх тэргүүлэх салбарын тухай ярих хэрэгтэй.

Эрүүл мэндийн салбар: Монгол хүний эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилсан сэргийлэх зорилгоор

Эрдэсийн боловсруулалт: Өндөр технологт тулгуурлан стратегийн ордуудыг ашиглах, өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох, шинэ нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн бий болгох.

http://www.mongolianeconomy.mn

Эрчим хүчний үйлдвэрлэл: Олон эх үүсвэрээс эрчим хүч үйлдвэрлэх, экс-пртлох. -Барилга, авто зам, төмөр зам: Аймаг, нийслэл болон бүсийн төвүүдийг хатуу хучилттай авто зам, төмөр замаар холбох.

Хүнс, ХАА, боловсруулах салбар: Хүн амыг эрүүл хүнсээр хангах, экспортод чиглэсэн стратегийн бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх

Мэдээллийн технологи: Өндөр технологи бий болгох талаар гээд олон санал Монголын эдийн засгийн форумын "Инновацийн орчин, технологийн гарц" хэлэлцүүлгийн үеэр гарсан. Харин эдгээрийг шийдэхийн тулд хамгийн түрүүнд хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх нь чухал гэдэг тал дээр оролцогчид санал нэгтэй байсан. Гэхдээ Инновацийн тухай хуулийн төслийг УИХ-аас хэлэлцээд хойшлуулсан талаар ҮХШХ-ны Шинэтгэлийн бодлогын газрын дарга Б.Ганбат "Шалтгаан нь Инновацийн тухай хоёр хууль УИХ-д зэрэг өргөн баригдсантай холбоотой. Хоёр хуулийг нэгтгэх шаардлага гарсан. Засгийн газрын "Инновацийн тухай хууль", УИХ-ын таван гишүүний өргөн барьсан "Технологийн инновацийн тухай хууль"-ийн төслүүд УИХ-д зэрэг очсон гэсэн үг. Тиймээс ойлголтын зөрүү гарсан. Зөвхөн шинжлэх ухааны байгууллагын үр дүнг нэвтрүүлэх нь л инноваци гэж ойлгоод байсан юм. Энэ ойлголт бол хуулийн хүрээний таван гол зорилгын ердөө ганц нь. Гэхдээ одоо ойлголтын зөрүүг арилгаж хуулийг нэгтгэсэн тул хуулийг дахин өргөн барих болсон" гэв.

Хуулийн таван гол зорилгод, дэд бүтэц бий болгох буюу шинжлэх ухааны парк байгуулах, тодорхой хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын үр дүнг үзэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх, "start up" буюу гарааны компанийг байгуулах, инновацийн гол зорилгыг хөгжүүлэх зэрэг багтаж байгаа аж. Эдгээр зорилт нь дээрх гарсан саналуудыг шийдээд зогсохгүй өөр бусад нааштай үр дагавар авчрах талаар талууд хүлээлттэй байгаа аж. Харин зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд хөрөнгө мөнгө тулгамдсан асуудал гэдгийг мэргэжилтнүүд хэлж байгаа. "2011 оны арван хоёрдугаар сард Засгийн газраас өндөр технологийг хөгжүүлэх хөтөлбөр баталсан. Уг бодлогын баримт бичигт санхүүжилтийн асуудлын талаар нэлээд сайн тусгаж өгсөн. Тэр дундаа технологийн компаниудыг төрөөс дэмжих тухайд анхаарсан байгаа. Ер нь одоо батлагдах гэж байгаа инновацийн хуулиас гадна тодорхой бие даасан бодлогууд гаргах хэрэгтэй. Монгол Улсын гарааны капиталыг бүрдүүлэгч гол хүчин зүйл бол мэдээж уул уурхай. Тиймээс дунд хугацааны зорилтод уул уурхайн салбараа түлхүү дэмжиж бий болсон хөрөнгөөр урт хугацаанд инноваци, мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх юм. 2021 он гэхэд мэдлэгт суурилсан эдийн засгийн суурийг тавьсан байх зорилго дэвшүүлэн ажиллаж байна" гэж Б.Ганбат ярьсан юм.

Өнөөдөр өндөр хөгжилтэй гаднын орнууд энгийн амьдралын хэвшлээс эрдэм мэдлэг, эх орныхоо бүх л бүтээн байгуулалтыг "Ногоон"-руу чиглүүлж байна. Манай орон ч ялгаагүй "Хүрэн эдийн засаг"-аас "Ногоон эдийн засаг"-руу шилжих зорилго тавиад байгаа. Харин үүний тулд инновацийг "ногоон хөгжил"-тэй хамт хөгжүүлэх нь чухал талаар мэргэжилтнүүд зөвлөж байна. "Өрсөлдөх чадвар, Инноваци ба ногоон шийдэл" хэлэлцүүлгийн үеэр МУИС-ийн багш, доктор, профессор Т.Чулуун

Инновацийн үнэлгээ

Инноваци ба хөгжил Инновацийг хөгжүүлэх шаардлагад бизнесийн таатай орчин, өрсөлдөх чадвар гээд эдийн засгийн бүх л асуудал хамааралтай байдаг талаар мэргэжилтнүүд ярьсан. Тэгвэл эдгээр хөгжил манайд ямар байгаа вэ?

Эдийн засгийн салбарын бүтцийн өөрчлөлт, /хувиар/

Салбар	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
ХАА	24.9	20.7	20.1	20.9	21.7	19.5	20.6	18.8	21.6
Аж үйлдвэр	23.4	22.1	25.4	29.9	30.2	37.7	35.7	36.3	34.2
Үйлчилгээ	51.7	57.2	54.5	49.2	48.1	42.8	43.7	44.9	44.2

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2005-2009 /Үндэсний статискийн/

Өнөөгийн байдлаар Монгол Улс эдийн засгийн харьцангуй өндөр өсөлттэй орнуудын тоонд орж байгаа. 1994 оноос эхлэн эдийн засгийн өсөлт жил тутам 3.8 хувь, харин 2001 оноос 5.5 хувьтай болж, өнгөрсөн онд 2011 онд 17.3 хувьд хүрсэн билээ. Үүнтэй холбоотой орлогын түвшин ч дээшилж байгаа аж. Манай улс бага орлоготой орноос бага-дунд орлоготой орнууд (Lower middle income countries)-ын эгнээнд шилжиж, ангилал дээшилсэн байна. Бизнесийн таатай орчин бүрдүүлэх нь эдийн засаг төдийгүй инновацийн хөгжилд ихээхэн чухал үүрэгтэй. Ийм ч учраас дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшинг тодорхойлоход эдийн засгийн чөлөөт байдлын үнэлгээг түгээмэл хэрэглэдэг байна. 2009 онд энэхүү үнэлгээнд дэлхийн 141 орныг хамруулж, үр дүнг "Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний тайлан"-д тусгаснаас үзэхэд манай улс 6.91 гэсэн нэгдсэн үнэлгээгээр 63 дугаар байранд оржээ. /Эх сурвалж: Fraser institute/ Хамгийн өндөр үнэлгээтэй гурван орноор Хонконг (8.97), Сингапур (8.66), Шинэ Зеланд(8.30) шалгарсан байна.

Түүнчлэн олон улсын холбогдох байгууллагуудаас улс орнуудын өрсөлдөх чадварын түвшинг тодорхойлж мөн тайлан мэдээлэл гаргадаг. 2011-2012 оны "Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан"-д 142 орныг хамруулсан ба гурван бүлэг нийт 12 үндсэн үзүүлэлтээр өрсөлдөх чадварын түвшинг үнэлсэн үр дүнгээс үзэхэд манай улс 3,86 онооогоор 96 дугаар байранд оржээ. /Эх сурвалж: World Economy Forum/ Инновацийн хүрээнд явуулсан дээрх судалгааны үр дүнд Монгол Улсын инновацийн хөгжлийн түвшин 20-30 хувьтай гарсан гэсэн үг. Мөн олон улсын үйлдвэрлэгчдийн ассоциацаас хамтран 142 орныг инновацийн орчноор нь жагсаахад манайх 112 дугаарт оржээ. Энэ нь ч аргагүй биз. 2010 онд шинжлэх ухаан технологийн 300 гаруй төсөл манайд хэрэгжсэн байна. Үүнээс ердөө л гурав нь шинэ бүтээлийн гэрчилгээ авчээ. Харин Шинэ Зеланд, Америк зэрэг оронд 10 төслийн хоёроос гурав нь үнэлэгдэж, үйлдвэрт ашиглагдаж, иргэдийн амьдралд үр ашгаа өгдөг аж.

http://www.mongolianeconomy.mn

“Өнөөдөр дэлхий нийт сэргээгдэх эрчим хүч, “Ногоон хөгжил”-руу явж байна. Энэ бол тун цагаа олсон хэрэг. Эдгээрийг хөгжүүлэхийн тулд төрийн тууштай бодлого, сайн засаглал хэрэгтэй. Тиймээс инновацийг ногоон шийдэлтэй хэрхэн холбох вэ гэдэг чухал” гэсэн юм.

Тэгэхээр инновацийг ногоон шийдэлтэй хэрхэн холбож хөгжүүлэх тухайд Монголын эдийн засгийн форумаар ярилцах юм. Ийм ч хүлээлт нийгэмд байна. ■

Нийгмийн даатгал

Тэтгэврийн нөөц сантай болох уу

Одоо мөрдөгдөж буй нийгмийн даатгалын тогтолцоо иргэдэд өгөөжтэй байж чадаж байна уу. Хөдөлмөр эрхэлж буй монголчуудын 90 гаруй хувь нь эрхэлж буй цалингаасаа өвөө, эмээ болохоороо авах тэтгэврийн мөнгөө хуримтлуулдаг. Гэвч насаараа ажиллаж, цалин бүрээсээ суутгуулсан мөнгө нь хожим амьдралд нь хүрэлцэхгүй, цайныхаа сүүг чүү чамай худалдан авах хэмжээний хуримтлал болдог. Энэ тогтолцоо хэр зөв болох, үүнийг иргэдэд ээлтэйгээр хэрхэн өөрчилж болох талаар Монголын эдийн засгийн чуулганаар хэлэлцэнэ. Тус форумын урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр илтгэл тавьсан төлөөлөгчид одоо байгаа тэтгэврийн даатгалын сангийн үйл ажиллагааг улам сайжруулахаас гадна тэтгэврийн нөөц сан, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг нэвтрүүлэх, эрчимжүүлэх саналыг тавьж байлаа.

Манайх хуучин улсын төсвөөс санхүүждэг даатгалын бус тогтолцооноос 1995 онд ажил олгогч ба ажилтан хоёул шимтгэл төлдөг нийгмийн тогтолцоонд шилжсэн. 1999-2000 оноос сайн дурын дансны тогтолцоог ажиллуулж эхэлсэн. Энэ нь ажил эрхэлдэггүй ч сайн дураараа нийгмийн даатгалд тодорхой татвар төлдөг иргэдийг хэлж буй. Тэгвэл өнөөдрийн байдлаар ердөө 580 мянга гаруй нь тэтгэврийн даатгалд заавал хамрагдах үндэслэлтэйгээр хөдөлмөр эрхэлж байгаа бол сайн дурын даатгалд 63 мянга гаруйхан иргэн хамрагдаж байгаа гэх судалгаа байна.

Түүнчлэн эдийн засгийн идэвхтэй хүн амын 53.6 хувь, малчдын 5.1 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 19.6 хувь нь тэтгэврийн даатгалын шимтгэл төлж байгаа нь тун хангалтгүй тоон үзүүлэлт гэдгийг нийгмийн даатгалын салбарынхан хэлж байна. Энэ нь ирээдүйн өндөр настнуудын олонх нь тэтгэвэр авах “эрхгүй” болж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл, заавал даатгал болон сайн дурын даатгалын алинд нь ч хамрагдахгүй учраас тэр. Иймд иргэдийн амьдралын баталгаа, амьжиргааг одоо байгаагаас нь бууруулахгүйн тулд улсын тэтгэврийн даатгалаас гадна тэтгэвэр олгож болох арга замуудыг нээх шаардлагатай байгаа юм.

Үүнд Тэтгэврийн нөөц санг бий болгох нь чухал гэдгийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Стратеги, төлөвлөлтийн газрын дарга Н.Аюуш “Тэтгэврийн тогтолцооны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдэх арга зам” сэдэвт илтгэлдээ дурдлаа. Тэтгэврийн нөөц сан байгуулах нь одоогийнхоос юугаараа дээр вэ гэхэд, “Дэлхийн өндөр хөгжилтэй олон оронд өндөр настнуудад зориулсан нөөцийн сан үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь тэтгэвэр бага тогтоогдсон, хүнд өвчний эмчилгээнд шаардлагатай төлбөр гэх мэт бусад халамж, үйлчилгээнд зориулсан нийгмийн халамж үзүүлэх сан юм. Тэтгэвэргүй өндөр настны тоо ирээдүйд арилах, залуудаа тэтгэврийн даатгалын шимтгэл төлөөгүйгээс төрийн үйлчилгээ авч чаддаггүй зарим тогтолцоог үгүй хийх чухал шийдэл юм. Цаашлаад тэтгэвэр нь бага тогтоогдсон иргэний цалингийн дунджаас хамаарч, суурь тэтгэвэр олгох үйлчилгээг үзүүлдэг гаднын туршлага байна” гэж товчхон хариуллаа.

Харин түүний энэхүү саналд хэлэлцүүлэгт оролцогч НХХ-ийн сайд асан Ши.Батбаяр “Тэтгэврийн нөөц сан байгуулах нь ашигтай ч бас сул талтай. Жишээ нь 2008 оны санхүүгийн хямралын үеэр дэлхийн ийм төрлийн сангууд алдагдал хүлээж эхэлсэн. Мөн өндөр настны санд найдаж, тэтгэврийн шимтгэл төлөх сонирхолтой хүний тоо буурна гэсэн үг” хэмээн хэлсэн. Мөн тэрбээр тэтгэврийн даатгалын системд дараах ажлуудыг яаралтай хиймээр байна. Үүнд, хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэрт гардаг явдлыг өөрчлөх, эрэгтэй, эмэгтэй хүний тэтгэврийн насыг ойртуулах, улмаар 2018 он гэхэд 60 болгох, 1960 оноос хойш төрөгсдийн шимтгэл хөрөнгөөс 3-5 хувийг өнөөгийн тэтгэвэрт зориулалгүйгээр санхүүгийн захад юм уу, Засгийн газрын бондод оруулж хуримтлалын бодит давхарга үүсгэх.

Мөн ажил олгогчийн даатгалыг нэн яаралтай хууль зүйн үндэстэй болгож, хувийн сайн дурын даатгалтай хамтруулан тэтгэврийн тогтолцооны нэгэн шинэ давхарга бий болгох, Хуваарилалтын хэлбэрийн тэтгэврийг үе үе ихээр нэмдэг улс төржсөн аргаас татгалзаж тогтмол бага хэмээр индексчилдэг журмыг тогтвортой мөрдөх хэрэгтэй” гэлээ. »

http://www.mongolianeconomy.mn

Хувийн тэтгэврийн сан ирээдүйн баталгаа мөн гэв үү

Гаднын зарим оронд иргэд хувийн тэтгэврийн сандсайндурааараатодорхой хэмжээний шимтгэл төлж, нэмэгдэл тэтгэвэр авдаг систем байдаг. Үүнийг “Тэтгэврийн ууган сан” төрийн бус байгууллага Монголд нутагшуулахыг зорьж байгаа юм. Хувийн тэтгэврийн санд хөдөлмөр эрхэлж буй иргэн ч хамрагдах боломжтой юм. Энэ нь тэтгэвэрт гараад одоогийнхоосоо илүү “цалин” авах боломж гэнэ. Тус санд хамрагдахдаа иргэн ирээдүйд сар бүр тэдэн төгрөгийн тэтгэвэр авна хэмээн урьдчилан тогтоож, графикийн дагуу мөнгөө байршуулж болох, эсвэл одоо ажиллаж буй цалингийнхаа тодорхой хувиар шимтгэл төлөх боломжийн аль нэгийг сонгоно. Аль аль нь иргэнд ээлтэй, ирээдүйг нь баталгаатай болгож буй хэрэг гэдгийг “Тэтгэврийн ууган сан” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал “Хувийн тэтгэврийн системийн Монгол дахь үүсэл, санаачилга” сэдэвт илтгэлдээ дурдсан юм. Харин энэ тогтолцоог нэвтрүүлэхэд хууль эрх зүйн орчныг нь сайн бүрдүүлэх шаардлагатай аж.

Хэлэлцүүлэгт оролцогч Б.Нарангэрэл “Хувийн тэтгэврийн санд орлогоосоо тодорхой хувь илүүчлэх боломж өнөөгийн нөхцөлд үнэндээ алга. Гэхдээ ач холбогдлыг нь иргэдэд таниулж, ойрын жилүүдэд нутагшуулах нь зүйтэй юм. Энэ нь иргэдийн ирээдүйн амьжиргааг дэмжсэн, алсын хараатай бодлого мөн гэж бодож байна” гэлээ.

Нэг эх үүсвэрээс тэтгэ

Монголчууд Нийгмийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Хүний хөгжил сан гэсэн гурван эх үүсвэрээс өндөр насны тэтгэвэр, оюутны тэтгэлэг, эх орны хувь хишиг тэргүүтэй халамжуудыг авдаг. Тэгвэл үүнийг “Монгол хүний хөгжлийн нэгдсэн данс” буюу Урьдчилан сэргийлэх, төвлөрүүлэх сан (УСТС)-д нэгтгэж, халамж, үйлчилгээ нэг эх үүсвэрээс гаргах нь ихээхэн ач холбогдолтойг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын орлогч дарга Ж.Жаргалсайхан онцолсон.

Урьдчилан сэргийлэх, төвлөрүүлэх санг байгуулснаар “Хүний хөгжил сан” -гаас иргэдэд өгч буй бэлэн мөнгөний замбараагүй тараалтыг өөрчилж, уг сангийн үйл ажиллагаанаас олсон ашгаас зохих хэсгийг УСТС-гийн зохих дансанд шилжүүлж болно гэж тооцож байгаа аж. Мөн нийгмийн даатгалын сангуудад шимтгэлээр орж ирж буй орлогыг УСТС-гийн нэг дэд дансанд төвлөрүүлж, Эрүүл мэндийн даатгалын санг дэд хэлбэрээр байгуулна. Үүнээс гадна төрөөс иргэдэд үзүүлж буй төрөл бүрийн халамж, хөнгөлөлт, дэмжлэгийн хөрөнгийг УСТС-ийн дэд дансанд байршуулахаар төлөвлөжээ. Энэ бүгдийг бүрдүүлэхэд “Монгол хүний хөгжлийн нэгдсэн сан”(УСТС)-гийн тухай хууль, Эрсдэлийн тухай хууль шинээр гаргах шаардлагатай болж байгаа юм. Үүнээс гадна Нийгмийн даатгалын болон халамжийн багц хууль, Хүний хөгжил сангийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль зэрэгт нэмэлт, өөрчлөлт оруулах буюу шинэчлэн боловсруулах шаардлагатай болж байгаа аж. Энэ нь халамж нэртэй олон байгууллагын тоог цөөлөх, зарим үргүй зардлыг арилгаж, иргэдийн амьдралын баталгаанд түшиглэсэн тогтолцоо болохыг илтгэгч онцолж байв. ■

Хүний хөгжил

Эрүүл мэндийн салбарт эрс шинэчлэл хэрэгтэй байна

Б.Март

Монгол хүний эрүүл энх байх нь амьдарч буй орчин, авч буй эмнэлгийн үйлчилгээнээс ихээхэн шалтгаалах аж. Тэгвэл өнөөдөр Улаанбаатар хот эрүүл амьдрах орчинтой бил үү. Манай эмнэлгийн үйлчилгээ, оношлогоо, эмчилгээ хэр найдвартай билээ. Монголын эдийн засгийн форумыг угтсан “Эрүүл мэндийн салбар асуудал ба шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр эрүүл мэндийн салбар дахь гажуудал, засаж залруулах зүйлсийн талаар мэргэжлийн хүмүүсийн хэлсэн үгнээс ишлэл авъя.

Нэг түрүүвчтэй болгоё

Эмнэлгийн салбарын засаглал учир нь олдохгүй олон даргатай, зорилго санаа нь нэгдмэл бус байдаг. Тухайлбал, ЭМЯ, Эрүүл мэндийн даатгалын сан, Даатгалын зөвлөл, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, аймаг, дүүргүүдийн удирдлага, МХЕГ, Сангийн яам, Төрийн албаны зөвлөл болон бусад байгууллага хамтран Монгол Улсын эрүүл мэндийн салбарыг толгойлж байна. “Нэг ямаанд жаран ухна” гэдэг шиг. Ингэж олуулаа даргын үүрэг гүйцэтгэх гол зорилго нь эрүүл мэндийн гэх тодотголтой төсвөөс хувь хүртэх явдал. Тиймээс энэ салбарт хамааралтай эрх мэдэл, бодлогын түвшний асуудлыг ЭМЯ-нд төвлөрүүлж, шаардлагагүй даргын үүргийг цуцалж, зардал, орлогыг нэг түрийвчинд багтаах нь үргүй зардал, хүнд суртлыг арилгах чухал гарц гэдгийг ЭМЯ-ны Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр IV төслийн зөвлөх А.Болд “Эмнэлгийн менежментийн тулгамдсан асуудлууд, шинэчлэлийн чиглэл” гэсэн илтгэлдээ дурдав.

Эрүүл мэндийн салбарын гүйдлээ олохгүй олон даргын суудлын дүр төрхийг Эрүүл мэндийн эдийн засагч, зөвлөх Ц.Нацагдорж илтгэлдээ “Төрийн өмчийн эмнэлгүүд хүний нөөц (Төрийн албаны зөвлөл) болон төсвийн (СЯ) хувьд төвлөрсөн эрх мэдлийн дор үйл ажиллагаа явуулдаг. Хэдийгээр эмнэлгийн түвшинд төсөв боловсруулдаг боловч төсвийн хуваарилалт ба санхүүжилт Сангийн яамны түвшинд эцэслэгддэг тул анхны төслийн агуулга бүтнээрээ хадгалагдаж чаддаггүй. Энэ нь цаашдын хөгжил, шинэчлэл хийх замд ихээхэн саад болж байгаа” гэсэн юм.

Үүгээрээ санхүүгийн болон засаглалын хувьд эрүүл мэндийн салбар бие даах нь чухал гэдгийг онцолж буй. Ингэхдээ эрүүл мэндийн даатгалын шимтгэл, татвар, орлого, зарлагыг нэгдсэн сангийн тогтолцоонд шилжүүлж, төрийн санд байршуулах, бодлогын асуудлыг зөвхөн ЭМЯ хариуцах нь зүйтэй гэв.

Нэгдсэн сантай болсноор иргэдийн халааснаас эмчилгээний төлбөрт ▸▸

http://www.mongolianeconomy.mn

бага мөнгө гаргах, амьдралын бүх түвшний иргэдийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах, эрсдэл, гамшгийн үед хэрэглэх, иргэд ядууралд автахаас сэргийлнэ гэлээ. Учир нь гэр бүлийн гишүүдийн нэг нь л хүндээр өвчлөхөд тухайн өрх байдгаа зарж, барьцаалж, эмчилгээний төлбөрт өгсөөр ядуусын эгнээнд шилжих жишээтэй.

Эрүүл мэндийн шалтгаанаар нэн ядуугийн эгнээнд улсын хэмжээнд нийт өрхийн 1.8 хувь нь шилжсэнийг судалгаагаар гарсан тухай Ц.Нацагдорж дурдсан.

III шатны эмнэлгийн үйлчилгээнд шууд хандах нь буруу

Яг ёс дүрмээрээ бол иргэн эхлээд өрхийн эмнэлэгт үзүүлж, үйлчилгээ авах ёстой. Үүний дараа шаардлагатай бол дүүргийн нэгдсэн эмнэлэгт хандаж, хэвтэн эмчлүүлэх эрхтэй. Бүр болохгүй бол нарийн мэргэжлийн эмнэлэгт буюу III шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээг авах журамтай. Гэтэл өнөөдөр иргэд III шатны эмнэлэгт шууд хандаж, өндөр төлбөр төлдөг. Үүний цаана тус шатны эмч нар үндсэн үүргээ бус I, II шатлалын эмнэлгийн тусламжийг иргэдэд үзүүлж байна. Өрхийн эмнэлгийн эмчийн бичих ёстой эмийг зүрх судасны нарийн мэргэжлийн эмч бичиж, дүүргийн сувилагчдын хийх тариаг илүү хүнд өвчтэй хүнд үйлчлэх ёстой улсын эмнэлгийн сувилагч тарьж байна. Энэ зөв тогтолцоо гэж үү.

Гаднын өндөр хөгжилтэй орнуудад улсын эмнэлгүүд хэвтэн эмчлүүлэх орныхоо тоог аль болох цөөрүүлэх зарчим барьдаг байна. Учир нь III шатлалын эмч нар иргэдийн өвчнийг оношилж, шаардлагатай эмчилгээг зөвлөөд, доорх шатлалын эмнэлэг рүү явуулах зарчимтай. Ингэснээр улсын эмнэлгийн ачаалал багасаж, иргэд ч түргэн шуурхай үйлчлүүлдэг" хэмээн Ц.Нацагдорж ярьсан. Мөн энэ тогтолцоонд манайх аажим аажмаар шилжих нь зүйтэй гэдгийг ч онцолсон. Үүний тулд нарийн мэргэжлийн өвчнүүдийг ангилсан хувийн эмнэлэг, сувилалын газрын тоог нэмэх шаардлагатай гэсэн санааг дэвшүүлж байв.

Мэргэшсэн эмч бус менежерийн бодлого дутагдаж байна

Өмнөх нийгмийн үед "Орос ах" нарын сургалтын бааз болгон манайд бэлэглэсэн улирсан баларсан үеийн тоног төхөөрөмжөөсөө бид салаагүй л байна. Үүнтэйгээ адил ОХУ-д дээр үед төгссөн өндөр настай академич, профессоруудыг удирдлагаараа тавьдаг хэвшмэл сэтгэлгээ үе дамжин уламжлагдсаар байна. Гэтэл үнэндээ манайх шиг эмнэлгийн багаж, төхөөрөмжтэй, эрүүл мэндийн салбар төдийгүй бусад салбарын бодлого гаргах түвшиндөө одоогийн болоод ирээдүйн чиг хандлагыг гадарладаггүй настай багш нарын системтэй улс ховор гэдгийг илтгэгчид төдийгүй хэлэлцүүлэгт оролцогчид ярьж байв.

Мэдлэг, тушлагатай, ачтай өвгөн буурал эмч, мэрэгжилтнүүдийг илүү харж байгаа юм биш. Гэхдээ яалт ч үгүй эрүүл мэндийн салбарт мэргэжлийн менежмент дутагдаж байгааг мэргэжилтнүүд ярьж байсан. Мөн эрүүл мэндийн салбарын хөрс суурийг эрүүлжүүлж, үйлчилгээг эздэд нь чанартай хүргэхээс гадна манайд шаардлагатай тоног төхөөрөмж, гаднын туршлагатай мэргэжилтнүүдийг татах чадвартай, гадаадад мэргэшсэн, одоо болон ирээдүйн байдлыг мэдэрч чаддаг залуу менежер нэн даруй шаардлагатай байгаа аж. Түүнчлэн энэ чиглэлийн мэргэжилтэн дагнан бэлтгэх, эмч, сувилагчийн сургуульд суралцаж буй оюутнуудыг чадваржуулж, гадаадын улс оронд мэргэжил дээшлүүлэх арга хэмжээг улсаас даруй авах шаардлагатай тухай мэргэжилтнүүд тэмдэглэсэн.

Эрүүл хотын төлөө

Азийн цагаан дагина хэмээгддэг байсан Улаанбаатар хүн амьдрахад аюултай хотын тоонд ороход тун ойртоод буй. Хөрс, ус, агаарын бохирдлоос үүдэлтэй нийслэлчүүдийн амьсгалын замын өвчлөл, уушгины хорт хавдар, уушгины өмөн үү, хоол боловсруулах эрхтний өвчлөлийн тархалт нэмэгдэж, улмаар амиа алдагсдын ихэнх хувийг эзэлж буйг олон судалгаа харуулж байна. Бид юу хийх ёстой вэ?

Эрүүл хотыг бий болгох хэрэгтэй. Үүний тулд хот төлөвлөлтийг өөрчилж, хүний эрүүл мэндэд, байгаль орчинд ээлтэй загварыг бий болгох гэдгийг НЗД-ын орлогч Ц.Цогзолмаа "Эрүүл хот" илтгэлдээ дурдав.

Тэрбээр "Засгийн газраас "Эрүүл хот" үндэсний хөтөлбөрийг баталсан. Тиймээс энэ зунаас нийслэл маань аажим аажмаар эрүүл хотын жишиг рүү явах болно. 1980-аад оны эхээр эхэлсэн эрүүл хот болох санаачилга өдгөө 10000 гаруй хотыг сүлжээндээ багтаажээ. Түүний нэг нь манай хот болох юм. Эдгээр орон эрүүл хот болохын тулд дугуйн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг олноор бий болгож, нийтийн тээврийн хэрэглээг нэмэгдүүлэх, нийт тээврийнхээ тодорхой хувийг дугуйн хэрэглээнд шилжүүлэх, дугуйг хамтран ашиглах тогтолцоо бий болгох, "Автомашингүй өдөр" арга хэмжээг олшруулах, ногоон орчныг бий болгох, эрүүл орчинтой хамт олон зэрэг арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлдэг" гэв.

Тиймээс иргэн бүр өөрөө өөртөө эрүүл орчинг бий болгож, хувийн автомашинаар бус дугуй, нийтийн тээврээр зорчиж, ногоон орчныг гэр бүлдээ бэлэглэх хэрэгтэй байгааг чухалчилсан. Хог хаягдлын хувьд дахин боловсруулах үйлдвэр байгуулахаар яригдаж байсан ч чимээгүй болсон. Энэ нь нийслэлчүүдийн хогны онцлогоос болсныг илтгэлдээ дурдсан. Учир нь нийт хог хаягдлын 60 гаруй хувь нь үнс бөгөөд үнсийг дахин боловсруулж, ямар нэг зүйлд ашиглах боломжгүй байдаг аж. ■

http://www.mongolianeconomy.mn

Ч.Отгочулуугийн булан

Швейцариас ирсэн захидал

Эдийн засгийн хурдтай өсөлт яагаад монголчуудын амьдрал, амьжиргаанд илт нөлөөлөхгүй байна вэ? Энэ асуултын хариуг эрсээр Монголын бодлого боловсруулагчид, оюуны манлайлагчид улс орныхоо хөгжлийн бодлогыг өрсөлдөх чадвар судлалаас хайх нь зүйтэй гэдгийг ойлгож эхэллээ. Статистикийн хувьд эдийн засаг өсөж байгаа хэдий ч боловсрол, дэд бүтэц, эрүүл мэнд зэрэг суурь салбар дахь бодит хөгжлийг хэмжиж байхыг чухалчлах болов. Түр зуурын зохиомол, тоон өсөлтөд хууртагдүй урт хугацааны, тогтвортой, бодит хөгжилд анхаарахын ач холбогдлыг монголчууд ухамсарлах болжээ. Мэдээж хөгжлийн энэ үеийг тойрч биш дайрч гарсан олон үндэстэн, улс бий. Ухаантай хүн бусдын алдаа, онооноос сурдаг жишгийг даган бид Швейцари улсад байрлах Дэлхийн өрсөлдөх чадварын төвтэй хамтран Монгол Улсын өрсөлдөх чадварын тайланг хоёр дахь жилдээ боловсруулан гаргаад байна. Тус тайланд үндэслэн Дэлхийн өрсөлдөх чадварын төвийн захирал, профессор Стефан Гарелли Монгол Улсын босгыг давж буй сорилтуудын талаар захидал бичжээ. Тэрбээр таван зүйлд онцгой анхаарахыг монголчуудад зөвлөж байна.

Нэг. Мөчлөг дагасан төсөв

Эдүгээ Монголын эдийн засаг уул уурхайгаас хэт хамааралтай байна. Экспортын 90 орчим хувийг эрдэс баялгийн түүхий эд бүрдүүлдэг бөгөөд Оюутолгой, Тавантолгой бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үед дээрх үзүүлэлт улам өсөх нь тодорхой. Нүүрсний экспорт зэсийнхээс давж, нийт экспортын 40 хувийг бий болгох болов. Үүнээс үзэхэд Монголын эдийн засаг дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хэт хамааралтай байна. Гэтэл түүхий эдийн үнэ өсдөг шигээ буурдгийг мартаж болохгүй. Жишээлбэл, 2008 оны зун 9000 ам.долларт хүрч байсан тонн зэсийн үнэ ердөө хагас жилийн дотор 2700 ам.доллар болтлоо навс унаж байсан. Харин 2011 онд “Economist” сэтгүүлийн аж үйлдвэрлэгчдийн түүхий эдийн үнийн индекс 21.6 хувиар унасан явдал монголчуудын хувьд анхаарлын дохио болж байна.

Уул уурхай түшиглэсэн эдийн засагтай Казахстан, Катар, Австрали болон Канад зэрэг улс орлогоо төлөвлөх, улмаар түүндээ тохируулан төсвийн бодлого баримтлах арга замаа хэдийнэ олсон. Эдгээр орон сайн цагт орлогоо хуримтлуулж, үнэ унасан муу үед түүнийгээ төсвийн хөрөнгө оруулалт маягаар хэрэглэх зориулалт бүхий “мөчлөг сөрсөн сан” байгуулсан юм. Иймэрхүү тогтворжуулалтын сангууд нь “олсныхоо хэрээр үрэх” зуршлаас сэргийлдэг. Монголчууд ч мөн түүхий эдийн үнийн хэлбэлзлээс зайлсхийсэн, мөчлөг дагасан хариуцлагагүй төсвөөс сэргийлсэн санхүүгийн тогтолцоог жинхэнэ утгаар нь бий болгох биз ээ.

Хоёр. Үнийн өсөлт

2008 онд 25 хувьд хүрч байсан инфляци 2011 онд 11 хувь болж буурчээ. Гэвч энэ нь тайвшрах шалтгаан биш юм. Ирэх саруудад хэрвээ эдийн засгийн өсөлт 20 хувиас давбал үнийн өсөлт дахин гаарах аюул бий. Түүнчлэн 2012 оны төсөв Монголын түүхэн дэх хамгийн том төсөв бөгөөд 4.1 хувийн алдагдалтай байх төлөвтэй. Төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэрийг 53 хувиар нэмж байна. Иргэн бүрт олгож буй 21 мянган төгрөг, оюутны тэтгэлэг, өндөр настнуудад олгох бэлэн мөнгө зэргээс харахад иргэдийн гар дээр эргэлдэж буй мөнгөний хэмжээ зэгсэн нэмэгдэхээр байна. Дээрээс нь өсөн нэмэгдэж буй экспорт (2011 онд гурван тэрбум ам.долларaас илүү гарсан) эдийн засагт урсан орж буй мөнгөн урсгалыг өсгөхөөр байгаа. Төвбанк үүнд хариу үйлдэл үзүүлж, банкуудад заавал байлгах нөөцийг 11 хувь болгож, бодлогын хүүг 12 хувьд хүргэсэн байна.

Ерөнхийдөө уул уурхайгаас орж ирэх их мөнгөн урсгалаас эдийн засгийг хамгаалах нэгэн арга зам нь (норвегичуудын туршлагаас үзэхэд) Үндэсний баялгийн сан байгуулах явдал юм. Өнөөдөр энэ сан дэлхийн олон компанид хувь эзэмшдэг бөгөөд, хөрөнгө оруулалтынхаа өгөөжөөр Норвегийн ард түмний сайн сайхан байдлыг хангах зориулалт бүхий нийгэм, эрүүл мэнд, тэтгэвэрийн тогтолцоог санхүүжүүлдэг ажээ. Ийнхүү норвегичууд газрын тос ба байгалийн хийн орлогынхоо зарим хэсгийг “хөлдөөж”, хожим урт хугацааны сайн сайхны төлөө зориулахаар байгаа юм.

Гурав. Барилгын салбар дахь үнийн “хөөс”

Үл хөдлөх хөрөнгийн зах зээл дэх үнийн “дэлбэрэлт ” нь эдийн засгийн хувьд маш том тогтворгүйжүүлэгч хүчин зүйл болдгийг саяхны Дубай, Ирланд, АНУ болон зарим талаараа Шанхайд болсон хямрал харууллаа.

Иймэрхүү хөөсрөл нь ихэвчлэн эх үүсвэрийн илүүдэл, зээлийн хэт зөөлөн бодлого болон зээл олгогч байгууллагуудыг зохистой хянаж, зохицуулж чадаагүйгээс үүдэлтэй байдаг. Гэтэл ийм хөөсрөлийн хямрал нүүрлэх эрсдэл нэмэгдэж буйг илэрхийлэх эхний шинж тэмдгүүд Монголд ажиглагдаад эхэлжээ. Барилгын салбар 65 хувийн өсөлтийг үзүүлсэн байна. Улаанбаатарын хүн ам сүүлийн жилүүдэд 70 хувиар өсөж 1.2 саяд хүрсэн бөгөөд нийт хүн амын бараг тал нь нийслэл хотдоо амьдарч буй.

Уурхайчдын өндөр цалин (жишээ нь Оюутолгойн барилгын ажилд 10,000 монгол, 6000 хятад хүн ажиллаж байна) Улаанбаатар дахь орон сууцны үнийн хөөрөгдлийн нэг “тэжээл” болох магадлалтай. Түүнчлэн улс төрчдийн амлалтаас үүдэлтэй бэлэн мөнгө тараах, бас нэг дор орон сууцны зориулалтаар их хэмжээний зээл олгох нь ч барилгын салбарт шингэх мөнгөн урсгалыг нэмэгдүүлж болзошгүй.

Үүнээс сэргийлэх нэг шийдэл нь банкны салбар болон бусад зээл олгогч байгууллагуудад моргейж болон хэрэглээний зээлийн хатуу хяналтын тогтолцоог бий болгох явдал юм.

http://www.mongolianeconomy.mn

Жишээ нь Швейцарид орон сууцны зээл авах гэж буй иргэн худалдан авах гэж буй байрныхаа үнийн дүнгийн 20 хувийг өөрөө хуримтлуулж бий болгосон байх үүрэгтэй. Үл хөдлөх хөрөнгөө богино хугацаанд эргүүлэн зарах тохиолдолд маш өндөр татвартай. Хэрвээ энэ нь тухайн хүний хоёр дахь байр бол төлөх татвар бүр ч өндөр болдог.

Канадад орон сууцны зээлдэгч заавал даатгалд хамрагддаг. Харин Америк болон Их Британид төрийн болон хувийн байгууллагууд ядуу иргэдэд зориулж санхүү болон өр төлбөрөө хэрхэн зохицуулах талаар зөвлөгөө өгдөг. Хэрвээ зээлээ эргэн төлөх боломжгүй нь нотлогдвол зээл огт өгөхгүй. Энэ талаар банкны зээлийн ажилтнууд тодорхой заавар дүрэмтэй байдаг.

Нөгөө талаас аялал жуулчлалын салбар ч үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн тэлэлт, ялангуяа газрын үнийн өсөлтөд нөлөөлөх тал бий. Жишээ нь зочид буудлын сүлжээ мэтийн хөрөнгө, санхүү сайтай томоохон компаниуд газрын үнэ, үл хөдлөх хөрөнгийн зах зээлд өсөлт бий болгодог. Тэгвэл Катар, Оман зэрэг улс аялал жуулчлалын салбартаа зориулж тусдаа газар гаргаж өгдөг. Энэ тусгай бүс нь аж үйлдвэрийн юм уу эсвэл оршин суугчдад зориулсан орон сууцны салбартай өрсөлдөхгүй гэсэн үг. Ийм замаар газрын үнэ нутгийн оршин суугчдын хувьд худалдаж авч болохуйц хямд үлдэж чаддаг.

Дөрөв. Эдийн засгаа төрөлжүүлэх

Монголын эдийн засаг нь эрдэс баялгийн экспортоос хэт хамааралтай байгааг дээр дурдсан. Үүний зэрэгцээ гадаад худалдаа нь хоёр “аварга” хөрш болох Хятад, ОХУ-аас хэт хамаарч байна. Хятад руу гарах нүүрс, зэсийн хэмжээ эрс ихсэхийн хэрээр энэ орон Монголын хувьд хамгийн чухал худалдааны түнш гэсэн байр сууриа улам бэхжүүлж байгаа юм. Үр дүнд нь хятадууд өнөөдөр Монголын нийт экспортын 90 хувийг шингээж байгаа бөгөөд энэ орны түүхий эдийн эрэлт Монголын ирэх жилүүдийн эдийн засгийн өнгө төрхийг тодорхойлохоор байна. Харин Орос нь монголчуудын худалдааны хоёр дахь гол түнш бөгөөд Монголын нийт импортын 22 хувийг бий болгож байна.

Тиймээс дээрх хараат байдлаас гарахын тулд дэд бүтэц, ялангуяа зам тээвэр, эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийх нь чухал юм. Мөн эрдэс баялгийн орлогоороо нэмүү өртөг бий болгох салбарыг хөгжүүлж чадсанаар жинхэнэ үр өгөөжөө өгөх учиртай.

Тав. Нийгмийн өв соёл, үнэт зүйлс

Улс орнуудын өрсөлдөх чадвар нь “бүх улсад таарах онол”-оор сайжрахгүй. Бүх өвчнийг анагаадаг ганц эм гэж үгүйтэй ижил. Тиймээс тухайн орны сэтгэлгээний онцлог, үнэлэмж чухал нөлөөтэй билээ.

Эдүгээ Монголын нийгмийг уул уурхайн ертөнц (Оюутолгой ба Тавантолгой), хотын ертөнц (Улаанбаатар), үндэсний хэв маягаа хадгалж үлдсэн ертөнц (хөдөө) гэж гурав хуваж үзэж болохоор байна. Энэхүү нийгмийн гурван хэсгийг холбох гүүрийг зөөлөн дэд бүтцэд хөрөнгө оруулах замаар барих учиртай. Тухайлбал, интернэтийг хөгжүүлж, түүгээр дамжуулан хичээл сургалт явуулах нь улс орны бүх иргэнд хаана байгаагаас үл хамааран адил сайн боловсрол олгоход нөлөөлнө. Канад улс нутгийн хойд хэсэгтээ энэхүү туршлагыг сайн хэрэгжүүлж чадсан юм.

Дүгнэлтийн оронд.

Мянга мянган жилийн турш дулаан цагт хадлан тэжээлээ базааж, тарчиг цагт түүгээрээ малаа тэжээж ирсэн нүүдэлчин ухааны уламжлалыг эдүгээ эдийн засгийн бодлогодоо шингээх цаг болжээ. Нүүдэлчин монгол уурхайчин монгол болохдоо ч гээж үл болом нарийн ухаан үүнд орших буюу.

Жич: Стефан Гарелли нь Дэлхийн өрсөлдөх чадварын тайланг сүүлийн 25 жилийн турш тасралтгүй боловсруулж байгаа юм. Тэрбээр Монгол Улсад 2010 онд айлчлан ирж, Өрсөлдөх чадварын 10 алтан дүрэм хэмээх лекц уншиж байсан билээ. Тус лекцийг www.ecrc.mn хаяг бүхий цахим хуудаснаас үзэх боломжтой.

Тэд бидний тухай

Уул уурхайн тэсрэлт дундах бохир баячууд ба үндсэрхэг үзэл

Орчуулсан Б. Энхцэцэг

Дэлхий нийтийн цаг үеийн асуудал хөндсөн томоохон нийтлэлүүдийг дагнан тавьдаг Австралийн The-globalmail.org цахим сайтын Азийг хариуцсан сэтгүүлч Aubrey Belford Монголын тухай энэхүү материалыг бичиж нийтлүүлжээ. Тэрбээр The New York Times , The International Herald Tribune зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байгалийн гамшиг, терроризмийн чиглэлээр нийтлэл бичдэг чөлөөт сэтгүүлч юм.

Хятад улсын хэрэгцээт баялаг дээр сандайлсан Монгол Улс огцом өсөлтийг таалан сууна. Гэвч геополитикийн тоглоом, гаднын их мөнгөнөөс үүдэн Чингисийн үр сад хуучны өсөлттэйгээ хэрхэн шинэ харилцаагаа зохицуулах бол гэдэгт зарим нэг монголын санаа нэлээд зовниж байна.

Төгсжаргалын Мөнх-Эрдэнэ анх хип хоп хөгжимтэй танилцаж эхлэхдээ Улаанбаатар хотын хахаж цацсан утаатай борчуудын хорооллын жаал хүү байжээ. Зөвлөлт холбоот улс задарч, Монгол хэмээх нүүдэлчин ард түмний доторх мянга мянган зөвлөлтийн цэрэг, коммунист дэглэм ч дагаад бутарчээ. Улмаар Монголд ардчиллын хуй салхи

http://www.mongolianeconomy.mn

гэнэт дэгдэн, чөлөөт зах зээл сэргэх үндэс тавигджээ. Зах зээлд шилжсэн он жилүүдийн төгсгөл хийгээд шинэ мянганы эхээр тус улсад тэсхүйеэ бэрх өвөл цаг айлчилсан учраас мал сүрэг үй олноор хиарч, үгүйрч хоосорсон хэдэн зуун мянган нүүдэлчин ард түмэн гэрээ ачаалан Улаанбаатарыг зорьжээ.

Мөнх-Эрдэнийг өсвөр насандаа Dr Dre, Snoop Dogg болон Cypress Hill-ийн дуунуудтай танил болж байх тэр үед эргэн тойронд нь зүдэрсэн малчдын цуваа Улаанбаатар хотын борчуудын хороолол руу хөвөрч байжээ. Өнөөдөр Gee хэмээх тайзны нэрээрээ олонд танигдсан 28 настай Мөнх-Эрдэнэ нүүдэлчин соёлоос хотын иргэншилд суурьшсан орчин цагийн монголчуудын тод жишээ юм.

Биерхүү, халзан толгойтой тэрбээр хоёр гарынхаа шуун дээрээ Нью- Йорк хотын “Wu-Tang Clan” реп урсгалын хамтлагийг шивүүлжээ. Тэрбээр бөөгийн бэлэглэсэн төмөр толь зүүж, хас тэмдэг, булга, цаа бугын арьсаар дэгжирхэнэ. Улаанбаатарын аймшигт замын түгжрэл дунд унаатай атал мөлхөж явах бухимдал төрүүлсэн асуудал Gee-гийн хүүхэд насны үеийнхээс эрс өөрчлөгдснийг харуулах аж. Хүнсэнд дугаарладаг үе улирч, хотоор хахсан ганган машин, Ирланд шар айрагны газар, Солонгос хоолны сүлжээ энэ бүгд хөрөнгөжиж буйн дохиог илгэх авч ядуусын хүрээлэл өргөн тэлсээр.

Gee өөрийгөө “мессеж”-тэй / хип хопчид амьдралын үнэн мөнийг дууныхаа үгэнд шингээж илэрхийлдэг гэдэг утгаараа/ дуучин гэж үздэг. Монгол залуусын дунд тэрбээр томоохон байлдан дагууллыг бий болгож яваа. Эдийн засгийн тэгш бус байдал, хээл хахуульд идэгдсэн улстөрчид, уул уурхайгаас үүдэлтэй байгалийн сүйрэл гээд олон асуудлын эсрэг хүчтэй зогсдог нэгэн. Гэвч түүний болон бусад олон монгол хүний дунд эдгээр ойлголтын үндэс хэрхэн хаана бүрэлддэгийг орон сууцны орц дахь шөнийн цэнгээний газар руу ороод явчихсан нь тодхон харуулж байлаа. Бүгчим халуун орчинд их сургуулийн оюутнуудаар дүүрсэн олны өмнө, тайзан дээр ихэмсгээр “Монголд өдөр өдрөөр өсөн нэмэгдэж буй тэр зүйл юу вэ ” хэмээн асуулаа. Харин залуус хэмнэлийг алдалгүйгээр гараа дээш өргөн “Хужаа” хэмээн хашгиралдах ажээ. Яг л англиар хятадуудыг “chink” хэмээх үгээр хочилдог шиг монголчууд тэднийг хужаа гэж дууддаг юм билээ. Мөн түүний “Жонон” ардын урлагийн хамтлагтай хамтран бүтээсэн томоохон бүтээлийн нэг нь ийм нэртэй. Хонины олон гулууз махны өмнө сүх барьчихсан, заналхийлсэн өнгө аясаар дуулж байгаа түүний клипийг Youtube сайтад 100 мянган хүн үзжээ.

Баргил хоолойгоор түүний дуу ингэж эхэлдэг

“Ходоодоороо хорвоог сэтгэх хужаагаас

Хол илүү би бол Монгол хүн учир

Хужаа минь өмнө сөгдөх тун!...”.

Яруу алдарт эзэн Чингис хааны газар нутаг шунахай хятадуудад аажим аажмаар эзлэгдсээр. Асар их мөнгө урсан орж ирсээр байх авч ховдог шунахай сэтгэл, дотоод хагарал, цусаао бохирдуулах явдал ноёрхох болсон. Харин одоо монголчууд нэгдэж, гаднынхныг шахан гаргах цаг нь болсон гэдгийг залуус түүнийг даган дуулах үест тэрбээр оюун санаандаа дүрслэн омогшино. Хятад, Орос хэмээх тэнхлүүн хоёр гүрний дунд шахагдсан монголчууд дэлхийг байлдан дагуулагч өвөг дээдсийнхээ өмнө түүхэн тодорхойгүй цаг үетэй тулан ирлээ хэмээн цуурайтах дуудлага юм. Энд үндсэрхэг үзэлтнүүдийн давалгаа газар авч, Нео-нацизм туйлдаа хүрчээ.

“...Мөнгөөр авсан янхан, мөнгөөр авсан сайд дарга нар

Монгол биш, та нарын эрлийз гэдгийг сайтар хар

Хужаад хууртахгүй хурлийз биш Монгол өсөж байна

Хуучин бүхнийг хуу хамах Монголын эрин дөхөж байна...”

Хятадын өсөлт хаа газрын хуучин дэс дарааг алдагдуулж, эдийн засгийг нь өөртөө тохируулан өөрчилж улс төрийн тогтолцоог дайвалзуулан байна. Магадгүй нэг ч улс гүрэн Хятадын эдийн засгийн соронзод хүчтэй татагдчихсан эсвэл өсөн нэмэгдэж буй геополитикийн нөлөөнөөс тэр аяараа айн чичирч байгаа гэж бодохгүй байгаа нь лавтай.

Хятад, Орос хоёр их гүрнээр хүрээлэгдсэн, хүчин мөхөс ардчилсан Парламентын засаглалтай Монгол Улс Франц улсаас гурав дахин том газар нутагтай авч энэ нь гуравхан сая иргэний эзэмшил. Харин тус улсын хилийн цаана 1,3 тэрбум хүн, тоолж баршгүй үйлдвэр байх бөгөөд эртний “өстөн” ахархан хугацаанд хөлжиж, бяд суусаар байх аж. Монголын хөрс шороо өөртөө Хятадын эдийн засгийн тэсрэлтийг цэнэглэх үнэтэй хөрөнгө агуулж байгаад хамаг учир оршино. Саяхныг болтол хэний ч гар хүрээгүй өдийг хүрсэн Монголын баялаг нүүрс, зэс, алт, уран гэх мэт бараг бүх эрдсийг агуулдаг ба мөнгөн хөрөнгөөр илэрхийлбэл хэдэн их наядаар үнэлэгдэх гэнэ. Харин тэдний хамгийн том худалдан авагч нь Хятад улс.

Тус улсын уул уурхайн “бүүм”-д гар дүрж чадвал Монгол нь хуулийн дагуу эсвэл өөр бусад арга замаар ядахдаа л бохир баян болох боломжтой газар юм. Аль хэдийнэ дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй орнуудын тоонд орчихсон яваа Монгол улсын эдийн засаг өнгөрсөн онд 14,8 хувиар өссөн бол тун удахгүй 20 хувь болохоор хүлээгдэж байна. Хүн амын бараг тал хувь нь амьдардаг социалист үеийн хот төлөвлөлтөөс аажим аажмаар салан холдож буй Улаанбаатар бол өөрөө “бүүм” хот. Хотын төв талбай буюу Сүхбаатарын талбай нь Чингис хааны шинэхэн хөшөөгөөр сүр жавхаа нэмсэн. Монголын анхны “Louis Vuitton болон Zegna” брэндийн дэлгүүрийн өмнөх гоёмсог талбайн хажуугаар хуучны орос тээврийн хэрэгслүүд дуу хадаан давхин өнгөрөх нь тус улсын нэг хүнд ногдох ДНБ ердөө л 3000 доллараас ихгүй гэдгийг сануулна. Өндөр настнууд дээл хэмээх нэртэй үндэсний хувцаараа чамирхан гудамжаар алхах зуур залуус хип хоп, панк, електро хөгжмийн үнэнч фэн болжээ.... ■

Үргэлжлэл бий.

http://www.mongolianeconomy.mn

“Mongolian Economy” сэтгүүлийн асуулт

-Монголын эдийн засгийн форум улсын хөгжилд хэрхэн нөлөөлдөг гэж Та бодож байна вэ?

Д.Батжаргал /Санхүү, эдийн засгийн сургуулийн захирал/:

-Монголын эдийн засгийн форумын үеэр бид нэгдсэн нэг санааг олж чаддаг нь хамгийн том амжилт юм. Төр, хувийн хэвшил, эрдэмтэн судлаачид нэг дор цуглаж, ямар ч бүлэг болж талцалгүй зөвхөн эх орныхоо ирээдүйн сайн сайхны төлөө санаа бодлоо уралдуулж, хөгжил ийм байх хэрэгтэй талаар үзэл бодлоо хэлдэг. Энэ олон санаанаас аль сайныг нь шилж аваад бүх тал хөгжлийн тухайд нэгдсэн нэг ойлголттой болж чаддаг. Нэгдсэн нэг ойлголтой болно гэдэг хөгжлийн гарааны эхний цэг юм.

Ер нь дэлхий нийт аливаа асуудлыг тодорхойлж, түүнийгээ тал бүрийн байр сууринаас ярьж, хэлэлцэж зөв шийдвэрт хүрдэг. Үүний нэг том жишээ нь ДАВОС-ын эдийн засгийн чуулга уулзалт юм. Бүх орны төлөөлөл нэгдэж, дэлхийн эдийн засаг, ирээдүйн хандлага, өөрийн орны эдийн засгийн хөгжил гээд олон асуудлыг олон талаас нь ярилцаж, зөвлөлддөг. Хүн бүр аливаа асуудлын зөвийг олохыг хичээдэг нь бидний төрөлх мөн чанар. Тиймээс “Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй” гэдэг шиг Монголын эдийн засгийн форум бүгдээрээ хэлэлцэх боломжийг бүгдэд олгодог билээ.

О.Чулуунбат /УИХ-ын гишүүн/:

-Монголын эдийн засгийн форумын үеэр олон санаа уралдаж, өрсөлддөг. Тиймээс Монгол Улсын хөгжилд нөлөөлөхөөс аргагүй. Ер нь өрсөлдөөн гэдэг хөгжлийн гол хөдөлгүүр шүү дээ. Тус чуулганд хөдөлгүүр хүч авдаг гэсэн үг. Гэхдээ илүү олон санаа, байр суурь, төлөөллийг оролцуулах нь чухал. Тухайлбал, гаднын томоохон хөрөнгө оруулагч, бизнесийн салбарынхан гэвэл өөр бусад салбарынхныг татан оролцуулах хэрэгтэй. Зарим тохиолдолд дарга нар л хэлсэн бол дэмжээд байдаг. Бүх дарга зөв ярихгүй, хийхгүй. Харин түүнийг тунгаах ухаалаг толгой олон байх тусмаа өрсөлдөөн сайжирна. Ингэж чадвал хөгжлийн хөдөлгүүр маань улам л хүчтэй болох юм.

Н.Рагчаасүрэн /Эдийн засагч/:

-Би өмнө нь Монголын эдийн засгийн форумд оролцож байгаагүй. Харин энэ удаа оролцох болоод байна. Ямартай ч шинэ санаа, нэг үзэл бодол, хамтын ажиллагаа гээд олон талыг дэмжиж чадсан санал санаачилга гаргаж чаддаг гэж уг форумын талаар оролцогчид ам сайтай байдаг юм билээ. Миний хувьд бодлого боловсруулагчид болон эдийн засгийн бүх салбарынханд хэрэгтэй шинэ санаа, зөвлөмж цөөнгүй гарах байх гэж найдаж байна.

Д.Даваасамбуу /УИХ-ын даргын зөвлөх/:

-Энэ форумын үеэр эдийн засгийн боловсрол олгох, харилцан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шинэ шилдэг санал санаачилга гаргах хэрэгтэй. Үүний тулд л Монголын эдийн засгийн форум зохиогддог. Заримдаа ингэж чаддаггүй юм шиг санагддаг. Хөгжлийн олон зорилт, хөтөлбөрийг “Мөрөөдлийн жагсаалт” шиг жагсаагаад биччихдэг. Гэхдээ тэдгээр зорилт нь биелэхгүй тохиолдол цөөнгүй. Тиймээс эдийн засгийн үр ашгийг хэрхэн дээшлүүлэх, зорилгоо яаж хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй байна. Бид олон сайхан санаа гаргадаг гэхдээ энэ санаа, зорилго зорилтыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын эх үүсвэрээ хэрхэн бий болгох талаар ярилцаж, арга замыг мөн хайх хэрэгтэй.

Б.Бямбасайхан / “Newcom” группын гүйцэтгэх захирал/:

-Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөл, эрдэмтэн судлаач, нийгэмд өөрийн байр суурийг эзэлсэн лидерүүд Монгол Улсын хөгжлийн талаар санал солилцох, мэтгэлцэх хамгийн нээлттэй талбар бол Монголын эдийн засгийн форум. Энэ форумын зорилго нь эдийн засгийн бүх асуудлыг алдаа мадаггүй шийдэх биш. Харин шинэ санаа, нэгдсэн үзэл баримтлал, үр ашигтай эдийн засгийн боломж зэргийг бий болгох нь чухал юм. Энэ удаагийн эдийн засгийн форумд миний бие зохион байгуулагчдын багт ажиллаж, орлогч даргын үүргийг гүйцэтгэж байгаа. Форумаар эдийн засгийн тогтвортой хөгжил, ногоон эдийн засаг, инноваци, эдийн засгийн өсөлт ядуурал гээд олон талын сэдвээр нээлттэй хэлэлцэнэ. Тэр дундаа “Ногоон хөгжил”, сэргээгдэх эрчим хүчийг Монгол Улс хэрхэн хөгжүүлэх вэ, энэ нь манай улсын эдийн засгийн нэг хэсэг болох нь зөв үү гэдэг дээр нэлээд нухацтай ярина.

Мөн усны асуудлыг хөндөж байгаа нь маш цагаа олсон хэрэг юм. Чуулганы угтаад хэлэлцэх сэдвүүдийн хүрээнд салбар хуралдаанууд болж, олон санал санаачилга гарсан байгаа.

Б.Лхагважав /Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх/:

-Эдийн засгийн ертөнцөд болж байгаа процесс, ирээдүйн чиг хандлагын талаар оролцогчид санаа бодлоо чөлөөтэй илэрхийлнэ гэдэг нь маш том боломж. Мөн өнөөдөр бид гаднынхантай нэг зиндаад, нэг сэтгэлгээгээр тэр ч бүү хэл нэг хэлээр, нэг ширээний ард суугаад алдаа оноогоо ярилцаж, туршлага солилцох нь олон талын ач холбогдолтой. Тэгэхээр форумын үеэр юун дээр алдаж,оносон талаараа мэдэж авах нь хамгийн чухал юм. ■

http://www.mongolianeconomy.mn

Санхүүгийн зах зээл

Тархигүй эдийн засаг

Б.Энхцэцэг

“Сааль яах вэ саваа бэлдэж үз”

“Санхүүгийн салбар гэдэг эдийн засгийн тархи” хэмээн “Financial Times” сонины эдийн засгийн мэдээллийн тоймч, редактор Мартин Волф хэлсэн байдаг. Тэгвэл дэлхийг алмайруулсан Монголын эдийн засгийн огцом өсөлтийг санхүүгийн салбар дагаад гэлдрэх үү эсвэл дагуулаад давхих уу гэдэг асуудал өдгөө хөгжлийн шаардлагаар Монгол Улсын өмнө тулгарч байна.

Өмнөх жил нь ердөө л 6.4 хувь байсан Монголын эдийн засаг өнгөрсөн онд 17,3 хувийн цойлсон өсөлтийг үзүүлж, ертөнцийн нүдийг бүлтийлгэж, чихийг дэлдийлгэсэн. Тэгвэл луу жилд Монголын эдийн засгийн өсөлт ямар байх бол оо гэдэг таамаг тун сонирхолтой сэдэв болоод буй юм. Олон улсын валютын сангаас 2012-2016 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт дунджаар 14 хувь байна гэсэн таамгийг хэдийнэ дэвшүүлсэн. Тус байгууллага 2013 оны өсөлтийг таамаглахдаа Оюутолгойн орд ашиглалтад орох үгүйгээс хамаг зүйл шалтгаална гэж үзэж буй. Хэрвээ Оюутолгой ашиглалтад орох юм бол Монголын эдийн засаг могой жилд 22.9 хувийн өсөлт үзүүлнэ гэжээ. Сайхан хэрэг шүү. Харин үүнтэй холбоотой Монгол Улсын эдийн засгийн өсөлт энэ онд 26 хувьд хүрнэ хэмээсэн Ерөнхий сайдын ашдын билгийг тэмдэглэхэд илүүдэхгүй болов уу. Ийнхүү эдийн засгийн хурд авсан өсөлттэй холбоотой “Сааль яах вэ саваа бэлдэж үз” хэмээн Монголын банкны холбооны ерөнхийлөгч М.Болд хэллээ. Тэрбээр Монголын эдийн засгийн чуулганд зориулсан “Эдийн засгийн өсөлт ба санхүүгийн салбар” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр тавьсан “Монгол Улсын санхүүгийн салбарын дэд бүтэц ба өнөөгийн байдал” илтгэлдээ дээрх ишлэлийг дурдсан юм.

“Financial Times”-ийн тоймчийн хэлсэнчлэн санхүүгийн салбарыг эдийн засгийн тархи гэж үзэх юм бол Монголын эдийн засаг өдгөө өндөр өсөлтийг үзүүлж байгаа хэдий ч тархигүй байгаа гэсэн үг аж. Тархи байж гэмээнэ хөгжих учиртай биш бил үү. Тэгэхээр асгарсан амжилттай эдийн засгийн өсөлтийг алгуур дөтлөх санхүүгийн салбарын өнөөгийн хөгжил тархи нь болоод залуурдаад явах биш, хөтлүүлчихээд, чирэгдэж яваа нь жам ёсны хөгжил биш гэдгийг дээрх хэлэлцүүлэгт санаа бодлоо нэмэрлэсэн мэргэжлийн хүмүүс хэлж байна.

Өнгөрсөн хугацаанд Монголд орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ гэрлийн хурдаар өссөн. Үүнтэй уялдан ҮНБ болон ДНБ хоёрын зөрүү нэмэгдэх хандлагатай байна гэдгийг Монголбанкны Валют, эдийн засгийн бодлогын газрын ахлах эдийн засагч Г.Мөнхбаяр илтгэлдээ онцолсон юм. Өөрөөр хэлбэл, огцом өсөлтийг үзүүлээд буй Монголын эдийн засагт гаднаас орж ирж буй их хөрөнгө оруулалтаас биедээ нааж авахаасаа илүүтэй өгөх нь ихсээд байгаа юм байна.

“Орлого нэмэгдсэн атал ядуурал буурахгүй байгаа нь өөрөө эдийн засгийн мөн чанарыг харуулж байна. Өндөр тооноос илүү хүн болгоны оролцоотой хэн бүхэнд хүртээмжтэй эдийн засгийн чанар ханхалсан хөгжил чухал юм” гэж Мөнхбаяр онцоллоо. Мөн тэрбээр санхүүгийн салбарын тулгамдсан асуудлыг дараах гурван зүйлтэй холбон тайлбарлалаа. Нэгдүгээрт, эдийн засгийн бодлого хоорондоо уялдахгүй байгаа бөгөөд эдийн засаг дахь төрийн оролцоо хэт нэмэгдэхийн хэрээр бусад секторыг шахан гаргах үзэгдэл илүү хурдацтай явагдаж байна. Хоёрдугаарт, орлогын хүртээмж жигд бус байдлаас үүссэн дотоодын хуримтлалын түвшин бага байх явдал гэнэ. Өнөөдөр иргэдийн



http://www.mongolianeconomy.mn

олонхынх нь орлогын түвшин доогуур байгаа ч ахиу хэрэглэх хандлага иргэдийн дунд өндөр байгаа аж. Цаашаа хийсэн мөнгөгүй хүн өөртөө болоод өрөөлд хөрөнгө оруулах замаар хувийн үнэлэмжээ дээшлүүлж өөрийгөө хөгжүүлэх боломж бага байдаг. Тиймээс энэ бол хавх гэж онцлов. Гуравдугаарт, санхүүгийн зах зээлийн 95 хувийг эзэлдэг банкны салбарын зээлийн хүү, барьцаа өндөр байгаа нь жижиг, дунд болоод үндэсний үйлдвэрлэлийг хүлээсэнд оруулчихсан аж.

Өнөөдөр зээлийн хүү аажимдаа бууж байгаа хэдий ч хангалттай хэмжээнд буурахгүй байна. Энэ нь хадгаламжийн хүүнд захирагдаж буй хэрэг гэнэ. Мэргэжлийн хүний хэлж буйгаар тоглоомын дүрэм нь угаас тийм аж. Харин хадгаламжийн хүү гэгч ноёнтон дээрээ инфляци гэдэг эзэнд дарлуулдаг. Ийм санхүүгийн зуучлал өөрөө тун түвөргтэй, өртөг өндөртэй байгаа учир эдийн засгийн өсөлт иргэдэд хүртээмжтэй байж чадахгүй байгаа юм. Энэ ч үүднээс Монголбанк цаашид тавагтай хоолноос хумсалдаг инфляцийг овоо хараандаа онилсоор байх болно гэдгийг ч Төвбанкны ахлах эдийн засагч хэлсэн.

Харин М.Болд ерөнхийлөгч Монголбанкны хувьд мөнгөний ялгавартай бодлого явуулах цаг нь болсон гэж үзэж байгаагаа илэрхийлсэн. Хэрэглээний зээлийг шаардлагатай үед татаж, үйлдвэрлэлийн зээлийг хорихгүй байх нь зүйтэй. Жилийн жилд мах, сүүний үнэ өсдөг. Тэгвэл энэ чиглэлийн үйлдвэрлэлийн зээлийг хангалттай тавьж өгснөөр асуудал цэгцрэх талтай ажээ.

Эдийн засгийн өсөлтийг санхүүгийн салбар хангаж чадах уу

“Баялгийн тэгш хуваарилалтыг төр биш, санхүүгийн зах зээлээр дамжуулж хийдэг юм. Өөрөөр хэлбэл, санхүүгийн зах зээл баялгийн тэгш хуваарилалт хийх боломжийг бүрдүүлдэг. Төр сая төгрөг тарааж байна. Энэ бол нэг удаагийн тэтгэмж болохоос баялгийн хуваарилалт огт биш. Харин төр бодлогоор дэмжиж зах зээл хөгжих, эрүүл тогтолцоог бий болгох үүрэгтэй. Зах зээл өөрөө хөгддөг. Гэхдээ үндэсний хүчирхэг санхүүгийн байгууллагууд зах зээлийг тодорхой шаардлагад нийцсэн хөгжилд хүрэхэд гол үүрэг гүйцэтгэдэг” хэмээн Монголын санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч Ө.Ганзориг хэлэв.

Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газрын эдийн засагч Ш.Алтанцэцэг “Өндөр хөгжилтэй орнуудад нийт санхүүгийн зах зээлд банкны салбарын эзлэх байр суурь дээд тал нь 70 хувь бусад нь 30 хувийг эзэлдэг. Монголынх шиг хэт нэг талыг барьсан бүтэц байдаггүй. Санхүүгийн зуучлалын байгууллагууд харьцааны хувьд тэнцвэртэй байж гэмээнэ зах зээл төрөлжих учиртай. Иймд цаашид банкны салбарыг бэхжүүлж, банк бус санхүүгийн зуучлал, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх хэрэгтэй” гэв.

Харин ҮХШХ-ны Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газрын дарга Г.Батхүрэл “Одоогийн байгаа системээр санхүүгийн салбар эдийн засгийн өсөлтийг хангаж чадах уу гэвэл үгүй. Бид дунд хугацааны чиглэлийнхээ хүрээнд нэг салбараас хэт хамааралтай байдаг энэ өрөөсгөл системийг төрөлжүүлэн эрүүлжүүлж, харьцааг нь зөв тогтоох зорилт тавин ажиллана” хэмээлээ. Үүн дээр Худалдаа хөгжлийн банкны ерөнхийлөгч Рандолф Коппа хэлэхдээ “Санхүүгийн салбарт банк ч гэсэн өнөөдрийн 95 хувийг хадгалаад байхыг хүсэхгүй байгаа байх гэж бодож байна. Энэ бол зах зээлд хувь эзэмшихэд ач холбогдол өгөөд байх тоглоом биш. Түрүү жил ДНБ-ий өсөлт 17 хувьтай байсан бол банкны салбарын өсөлт 40-50 хувьтай байсан. Гэхдээ энэ нь хурдацтай хөгжиж байгаа орнуудтай харьцуулахад харьцангуй доогуур үзүүлэлт юм. Зүй тогтлоороо бол ДНБ 30-40 хувь, банкны салбар 70-80 хувь байх ёстой. Банкны салбарт зээлийн хэмжээгээ эрчимтэй өсгөхийн тулд хөрөнгө хэрэгтэй байгаа юм. Үүнтэй



уялдан хөрөнгийн зах зээл хурдацтай хөгжих шаардлагатай байна. Ирэх жилүүдэд санхүүгийн салбар бүхлээрээ өсч банкны салбар 70-аас дээшгүй хувьд хүрсэн байх учиртай” хэмээн учирласан.

Сангийн яамны санхүү эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Батбаяр“Санхүүгийн салбарын хөгжил тэр болгон эдийн засгийн хөгжлийг автоматаар чирч явдаггүй олон судалгаа баталдаг. Ялангуяа банкны салбар нь түрүүлж хөгжөөд эдийн засгаа богино хугацаанд халааж байгаад эргээд татаад унагачихсан жишээ Исланд улсад байдаг. Монголд эрсдэлийг тус тусдаа хариуцаж үүрээд эдийн засагтаа шууд “шок” үүсгэхгүй хэмжээнд шингээж чадах санхүүгийн салбар хэрэгтэй байна” гэлээ. Юун түрүүнд санхүүгийн салбарын эрх зүйн орчинг бүрэн бүтэн болгох хэрэгтэй байгааг хэлэлцүүлгийн үеэр бараг хүн бүр хэлж байсан.

Хөрөнгийг хэрхэн хөгжил болгон хувиргах вэ

Бичил зээл олголтоор Монгол Улс дэлхийд тэргүүлэх бүрэн үндэслэлтэй гэдгийг М.Болд хэллээ. Улиран өнгөрсөн туулай жилд арилжааны 14 банк нийт 5,5 их наяд төгрөгийн зээл олгожээ. Өмнөх онд зээлийн өсөлт 70 хувьтай байсан бол зарим жил 100 хувьд хүрч байсан байх юм. Ирээдүйд энэ тоо үлэмж хэмжээнд өсч 2030 он гэхэд 170 орчим их наяд төгрөг болох таамгийг банкирууд дэвшүүлжээ. ҮХШХ-ны Дунд хугацааны хөтөлбөрийн тэргүүлэх таван чиглэлд тусгаснаар бол дотоодын банкны салбараас ирэх дөрвөн жилд 4,9 их наяд төгрөгийн санхүүжилт хүлээгдэж буй. Тус салбарт дээрхээс гурваас дөрөв дахин их буюу 20 их наяд төгрөгийн санхүүжилт хийх ч боломж бүрдэх талтайг Болд захирал тэмдэглэсэн. Гэхдээ энэ бол тийм ч амар хоол биш бөгөөд банк санхүүгийн салбарын дэд бүтцийг сайжруулсны үндсэн дээр хөрсөн дээр буух тоо гэнэ. Сайжруулах ёстой санхүүгийн дэд бүтцэд банк, даатгал, хөрөнгийн зах зээл орох юм. Үүнийг хийхгүйгээр манайх олон улсын санхүүгийн зах зээлтэй яагаад ч хөл нийлэх боломжгүй аж. Санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх шаардлагатай маш олон үйлчилгээ бий аж. Тухайлбал, Монголд хөдлөх хөрөнгийн бүртгэл огт байхгүй учир хөдлөх хөрөнгөгүй иргэдийн хувьд зээл хаалттай байдаг. Банкны зээлийг иргэдэд хүртээмжтэй,

http://www.mongolianeconomy.mn

аль аль талдаа чирэгдэл багатай болгохын тулд зээлийн мэдээллийн сан болоод зээлийн батлан даалтын санг хөгжүүлэх хэрэгтэйг ч хуралд оролцогчид тэмдэглэсэн.

Мөн түүнчлэн олон улсын нягтлан бодох бүртгэлийн системийн хэм хэмжээг банк, санхүүгийн байгууллагууд мөрдөх шаардлага тулгарч буй юм. Хэрвээ үүнийг хийж чадахгүй аваас Монгол Улс олон улсад өрсөлдөх чадваргүй хоцрогдсон хэвээр он жилүүдийг үдсээр байх нь. Дээр нь сайн засаглал, нээлттэй ил тод байдлыг хангах, нөгөө талаар улиг болсон Хадгаламжийн даатгалын хуулийг гаргах шаардлагатай байгаа гэх мэт асуудлуудыг Болд ерөнхийлөгч дэвшүүлэн тавьсан. Зоосны нөгөө тал буюу хууль тогтоогчдын зүгээс юу хийх ёстой вэ гэвэл хууль эрх зүйн орчинг сайжруулах. Өнөөдөр эдийн засгийн тогтвортой байдлаа хууль гаргагчид өөрсдөө эвдээд сууж байгаад тэрбээр шүүмжлэлтэй хандаж байв. Энэ удаагийн Монголын эдийн засгийн форумын хүрээнд төр, хувийн хэвшил ойлголтоо цэгцэлж нэгдсэн байр сууринд хүрэх нь нэн чухал юм гэдгийг ч тэрбээр нэмж хэлсэн. Гэхдээ төрийн хэт их зохицуулалт өөрөө эдийн засгийн өсөлтийг боомилох талтайг ч хүмүүс онцолж байлаа.

Монгол Улсад өнөөдөр гадаадаас харьцангуй өндөр хүүтэй зээл олддог нь олон улсын зах зээлд рейтингийн хувьд тааруу үнэлгээтэй байдагт оршдог байна. Энэ нь манай улс эрсдэлтэй зээлдэгч гэсэн үг л дээ. Өндөр хүүтэй авчихсан их мөнгөө эргүүлээд аж ахуйн нэгжид зээлэхэд өндөр хүүтэй л өгөх болдог. Энэ нь бид улсынхаа үнэлгээг сайжруулах тал дээр анхаарах хэрэгтэйг хэлээд байна.

Хадгаламжийн даатгалын сан, тэтгэврийн санг эдийн засгийн эргэлтэд оруулах нь Монгол Улсад урт хугацааны зээл олдох боломжийг бүрдүүлэх сайн талтай аж. Төр, хувийн хэвшил аль аль нь дутуугаа нөхөж дундууруа дүүргэх замаар бэлтгэлээ сайтар базааж гэмээнэ хөрөнгө хөгжил болон хувирна гэдэгтэй хэлэлцүүлэгт оролцогчид санал нэгдэж байлаа. Ө.Ганзориг “Эдийн засгийг төрөлжүүлэн олон тулгууртай болгохын тулд гадаадын компаниудыг Монголоос аль болох их үйлчилгээ авахуулах замаар нэмэгдсэн өртгийг бүрдүүлэх хэрэгтэй. Тухайлбал, Монголд үйл ажиллагаа явуулж буй компани Монголын даатгалын компанид даатгуулдаг, Монголын банкаар үйлчлүүлдэг байх ёстой. Глобальчлалыг нэн тэргүүнд тавьж, гадаадын хөрөнгө оруулалтыг эрхэмлэх нь зүйтэй. Орон болгон өөрсдийн зах зээл дээр тодорхой хэмжээний үндэсний эрх ашиг, сонирхлыг хамгаалсан тогтолцоог бий болгодог шүү дээ” гэв.

Итгэлцлийн түвшинд шалан дээр унасан нэр хүндтэй Монголын хөрөнгийн зах зээл Лондоны хөрөнгийн биржийн загвараар хөгжихөөр болсон. Үнэт цаасны суурь хууль түүнтэй холбоотой цөөнгүй дүрэм журмыг өөрчилж байж хүмүүсийн итгэл сэргэж хөрөнгийн зах зээл хөгжих боломж бүрдэх гэнэ.

Санхүүгийн хамгийн учир дутагдалтай салбар бол даатгал юм. Тэтгэврийн эсвэл тодорхой нэг эрсдэлийн сан гэхээс илүү даатгалын салбарыг банкны болон хөрөнгийн зах зээл дээр гарч болох эрсдэлүүдийг бууруулах гол зөөлөвч гэж харах ёстойг оролцогчид хэлж байлаа. Даатгалын зуучлалын асуудал дээр маш олон зохицуулалт үгүйлэгдэж байгаа аж. Энэ салбарыг Засгийн газраас хүчээр босгож ирэх шаардлага ч бий гэнэ. Ялангуяа манай даатгалын 16 компанийн даатгаж чадахгүй байгаа эрсдэлийг үүрэлцэх үндэсний давхар даатгалын компани гарч ирэх ёстой гэж үзэж байна.

Монголын эдийн засгийн чуулганыг үтсанхэлэлцүүлгүүдийндоторсанхүүгийн салбарынх хоёр үе шаттай болсон нь тус салбар ямар өргөн хүрээтэй, шийдэл хүлээсэн асуудал олонтойг харуулж буй хэрэг гэж үзэж болох юм. ■

Баялгийн орлогын зохистой удирдлага

Нөөц баялгийн хяслан

Б.Баяртогтох

“Өнөө үеийн хэрэгцээгээ хангахдаа ирээдүй үеийн хэрэглээний боломжид сөргөөр нөлөөлөхгүй тийм хөгжлийг тогтвортой хөгжил гэнэ”

Брундлэндийн комисс

Нөөц баялаг нь хөгжилд нөмөр нөөлөг болдог болов ч заримдаа өмөг түшиг байх шинж чанараа алддаг. Товчхондоо үүнийг баялгийн хараал хэмээн дэлхий нийт нэрлэдэг. Нөөц баялгаар баян байдал нь аливаа орны эдийн засгийг гажуудуулж, улмаар нөөц баялгийн ашиглалт үр ашиг багатай болж, хөрөнгө оруулалт бууран, өсөлтийн чиг хандлага алдагдахад хүргэдэг байна. Үүнийг л өнөө цагт нөөц баялгийн хяслан гэж тэмдэглээд байгаа юм. Манай улс энэхүү

http://www.mongolianeconomy.mn

хяслангаас зайлсхийхэд чиглэсэн зарим нэг бодлого хэрэгжүүлж байгаа.

Тухайлбал, Санхүүгийн тогтвортой байдлын тухай хуулийг баталж, Санхүүгийн тогтвортой байдлын, Хүний хөгжлийн, Тогтворжуулалтын санг байгуулсан. Гэхдээ эдгээр нь Аляскийн байнгын сан, Казахстаны Үндэсний газрын тосны сан, Кувейтын Хөрөнгө оруулалтын газар, Зүүн Тиморын Нефть бүтээгдэхүүний сан, Чилийн зэсийн сан, Норвегийн Тэтгэврийн сан шиг хүчирхэг болох эсэхийг мэдэхгүй. Төрийн мэргэн бодлогоос л шалтгаалах нь ойлгомжтой юм.

Ухаалаг төр

Норвег, Канад, Австрали, Ботсвана зэрэг улс баялагтай байхын зэрэгцээ ухаалаг төрийн амьд жишээ болж байна. Ботсвана эрдэнийн чулуу олборлолтоороо дэлхийд тэргүүлж, баялгаа хөгжил дэвшил болгон хувиргаж чаджээ. Тэгээд баялаг хэмээх мөнгөний авдраас олсон орлогынхоо ахиухан хэсгийг эрүүл мэнд, боловсролын салбартаа зориулахын зэрэгцээ тусгай санд буюу ирээдүй хойч үедээ зориулж хуримтлуулдаг аж. Энэ бол баялгийн удирдлагын сайн засаглал, ил тод байдал ном дүрмээрээ хэрэгжиж байгаагийн сайн жишээ ажээ.

Мөн Индонез, Малайз зэрэг газрын тос экспортлогч орон хөдөө аж ахуйгаа хөгжүүлж, улс орноо аж үйлдвэржүүлсэн нь баялгийн хараалаас зайлсхийх үр дүнтэй аргад тооцогдож байна.

Тэгвэл баялагтай хэдий ч хоосрол ядуурал, авилга хээл хахууль,хүнд суртал, тэмцэл зөрчилдөөний талбар болсон улс орны түүх дэлхийд олон. Үүнд, Ангол, Судан, Конго, Нигер багтана. Тухайлбал, Өмнөд Номхон далайн Науру Улс фосфортаа экспортолж, 1960-1970-аад оны үед нэг хүнд ногдох орлогоороо дэлхийд хоёрдугаар байрт орж байжээ. Харин өнөөдөр ордоо ашиглаж дууссанаар орлогогүй болж, уурхайн орчны байгаль, экологи нь ч сүйджээ. Ази, Номхон далайн бүсийн олон улс баялгийн хараалаас холдож чадсан хэдий ч засаглал сул, өргөн хүрээний эдийн засгийн болоод сөрөг үзэгдлийг сааруулах төлөвлөгөө боловсруулаагүй байгаа нь баялгийн хараалд өртөх эрсдэл өндөр хэвээр буйг шинжээчид анхааруулсаар байна. Нөөц баялгийн хясланг дайрч бус, тойрч явах арга ухаан нь төрийн ухаалаг бодлого ажээ. Төрийн бодлого өнөөдрийг дэнсэлж, учрах эрсдэлийг тооцох нь ухаалаг төр байхын үнэт зүйл хэмээн Нээлттэй нийгмийн форумын судалгаанд онцолжээ.

Манай улсад ямар бодлого байна вэ?

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн захирагч Хелен Кларк “Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь уул уурхайн салбарт ногдож байгаа нөхцөлд зөв бодлого барихгүй бол дунд ба хэтийн хугацаанд “Голланд өвчинд” өртөх эрсдэл байгааг анхаарах хэрэгтэй” хэмээн мэдэгдсэн нь бий. Харин Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд “Бид эдийн засгийг төрөлжүүлэх хэрэгтэйг ойлгосон. Уул уурхайгаас орж ирэх татварыг Хүний хөгжил санд оруулснаараа эрүүл мэнд, боловсрол болон бусад салбарыг санхүүжүүлэхэд ашиглана. Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталсан. Энэ хуулиараа бид уул уурхайгаас орж ирэх орлогыг ил тод, үр өгөөжтэй ашиглаж ядуурлыг бууруулах явцыг зохицуулна” гэж хэлсэн билээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Ил тод, хариуцлагатай уул уурхай, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлж, түүнээс олох орлогыг ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн бие даасан хөгжлийг хангах олон тулгуурт бүтцийг бий болгох, хүний хөгжлийг дэмжиж, боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулна” хэмээн тодорхойлжээ.

Төрийн бодлого ийн тодорхой ч амьдрал дээр бодитоор хэрэгжүүлж чадахгүй байна гэж эдийн засагчид үздэг. “Сангийн тогтолцоо бол эрүүл эдийн засаг. Тиймээс сангаар дамжуулан баялгийн орлогоо тэгш хүртээх нь үр дүнтэй” хэмээн МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш Б.Эрдэнэбат ярьж байна. ■

Зөвхөн сонсогдох тоон өсөлт бий болчихоод байна шүү дээ

СЭЗДС-ийн Экономикс, Эконометриксийн Тэнхмийн эрхлэгч Ц.Батсүх:

-Уул уурхайн орлого хуваарилалтын гол зарчим бол газар доорх баялгийг газрын дээрх баялаг болгож хувиргахад оршдог. Бид зэс, алтаа худалдсаныхаа хариуд авсан мөнгөн орлогыг иргэдэд бэлнээр тарааж, түүнийгээ Хятадын бараа болгох нь газрын дээрх баялгийг бий болгохгүй. Иймээс уул уурхайн орлогын хуваарилалтын эцсийн үр дүн түүний хуваарилалтын үр ашиг байна. Байгалийн баялгаас олсон орлогоороо “амьдардаг” улс орнуудын хувьд цөөн төрлийн түүхий эдийн үнийн хэлбэлзэл нийт эдийн засагт нь хүчтэй нөлөө үзүүлдэг.

Манай улсад ч уул уурхайн баялгийн үнэ өсөхөд олсон орлогоо үрэлгэн зарцуулж, уналтын үед “бүсээ чангалдаг” хандлага тогтоод байна. Эдийн засгийн сэргэлтийн үеийн тусгай сангийн үйл ажиллагааны зарчим гэж бий. Үүнд Засгийн газар ба Тусгай сан, Үйлдвэрлэгчид ба Тусгай сан, Санхүүгийн сектор ба Тусгай сан, Гадаад сектор ба Тусгай сан гэж багтаан ангилдаг. Гадаад сектор бага Тусгай сангийн тухайд гадаад зах зээл дээр нөхцөл байдал сайжирснаар манай эдийн засаг сэргэж, өсөлттэй байх үетэй давхцах тул уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр байх бөгөөд үүнээс шалтгаалан тусгай санд их хэмжээний хөрөнгө төвлөрнө. Олон улсын тавцан дахь Монгол Улсын нэр хүндийг нэмэгдүүлэх, хүн төрөлхтний эв санааны нэгдэл дээр тулгуурлаж буй хэрэг. Тусгай санд хуримтлагдсан хөрөнгийг эхний үед гадаадын эрсдэлгүй үнэт цаасуудад байршуулах шаардлагатай.

Дотоодод байршуулснаар дотоодын эдийн засгийн тэнцвэрийг алдагдуулах аюултай. Тогтворжилтын сан, хуримтлалын сан гээд сангийн олон хэлбэр бий. Сайн засаглал, урт хугацааны хөгжлийн оновчтой төлөвлөгөө хэрэгжүүлж чадвал байгалийн баялгийн хараалд өртөлгүй тойрч, иргэдээ боловсрол, эрүүл мэнд зэрэг чанартай үйлчилгээгээр хангах боломжтой.

Байгалийн баялгийн орлогын менежмент манайд алдагдаад байгаа юм. Үүний тод жишээ нь эдийн засгийн өндөр өсөлт. Үзэгдэхүүй харагдахүй, баригдахүй зөвхөн сонсогдох тоон өсөлт бий болчихоод байна шүү дээ. Энэ чинь баялгийн орлогын зохистой удирдлага эзэнгүйдэж байгаагийн шинж юм.

http://www.mongolianeconomy.mn

Ногоон хөгжил

40 Нүүрс үү, салхи уу?

Ус-тогтвортой хөгжил

Д.Бэхээ

Монгол Улсад өнөөдөр хамгийн үнэгүй зүйл бол ус билээ. Харин бусад улс оронд хамгийн үнэтэй нь ус. Төр, засгаас нь эхлээд ард иргэд нь усны үнэ цэнийг гүнээ ойлгож, мэдэрдэг, хайрлаж гамнадаг. Харин монголчууд хар усыг харамлаж болохгүй гэсэн зүйр үгээ дагаж, усны үнэ цэнийг уландаа гишгэсэн нь өнөөдрийн усны тулгамдсан асуудлыг үүсгэхэд хүргэсэн гэлтэй. Ер нь улс орны хөгжлийг ард иргэдээ амгалан тайван амьдруулахад чиглэсэн цэвэр усны хангамжаар нь дүгнэж үздэг жишиг байдаг аж. Өөрөөр хэлбэл, ус тухайн улсын тогтвортой хөгжлийн үндэс гэж томьёолдог бол манай улсад ийм бодлого байна уу.

Бөмбөрцгийн нөгөө талд усны төлөө дайн болж, ус алт, зэснээс ч үнэтэйд тооцогдож байна. Цаашдаа цэвэр усны нөөцтэй улс орон хамгийн баян болох хандлага явж байна. Гэтэл манай төр нүүрс, зэс, уул уурхайг түлхүү ярьж, хөгжлийн гарц хэмээн харж байна. Тэгвэл хөгжлийн гарц хэмээгдэж буй Өмнийн говийн том ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах хэмжээний усны нөөц байгаа юм уу. Говийн усны асуудлыг хэрхэн яаж шийдэх гэж байна вэ. Усгүйгээр хэрхэн Оюутолгой, Тавантолгойн ордыг ашиглах вэ гэсэн асуулт гарч ирнэ. Эдгээр асуултад тодорхой хариулах зүйл алга байна, төрийн зүгээс.

Ундны цэвэр усаараа тоглож наадаж буй улс орон манайхаас өөр байдаггүй юм байна. Бидний өдөр тутмын хэрэглээндээ хэрэглэж буй ус бол ундны цэвэр ус. Шүршүүр, 00-д ундандаа уух усаа урсгасаар байна шүү дээ. Мөн алтаа угаасаар байна. Ирээдүй хойч үеийнхээ уух усаар алт угаамааргүй байна гэж Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Д.Баттулга Компанийн нийгмийн хариуцлагын тухай нэгэн хурал дээр онцлон хэлснийг энд тэмдэглэе. Монгол цэвэр усны нөөцөөр тийм баян орон гэж үү.

Дэлхийн нийт усны 2,5 хувийг л цэвэр ус эзэлдэг. Үүний өчүүхэн хэсэг нь Монголд ногддог гээд бодоод үз дээ. Усны нэгдсэн бодлого болоод ойлголт байхгүй явж ирсэн тухайд мэргэжилтнүүд ярьдаг. Усны асуудал үнэндээ бол олон яам, агентлагт харьяалагддаг аж. Тэгээд хоорондоо ямар ч уялдаа холбоогүй байх жишээтэй. Нийгэм цаг үе хурдан хувьсан өөрчлөгдөж буй өнөө үед бодлого, бусад стандарт, дүрмүүд тэр бүү хэл ойлголт, сэтгэлгээ ч даган шинэчлэгдэх ёстой.

Усны үнэ

Ус Монголд үнэгүй болохоор л хайр гамгүй хэрэглэж байна. Гэр хорооллын айл өрхүүд нэг литр усыг нэг төгрөгөөр авч байгаа бол орон сууцны айлууд тоолуурtай тоолуургүйгээс шалт-гаалаад 250-450 төгрөгийн үнэтэй бол аж ахуйн нэгжүүд шоо метрт 800 орчим төгрөг төлдөг. Энэ мөнгө аж ахуйн нэгжүүд, ялангуяа уул уурхайн салбарынханд юу ч биш нь ойлгомжтой. Бид байгаль эхээсээ мөнгөөр хэмжигдэхгүй их ус авч хэрэглэчихээд эргээд эко үйлчилгээний төлбөрт хямд үнэ төлж боломгүй санагдана.

Усны үнийг нэмж байж ус үнэ цэнэтэй болно гэж Усны газрын орлогч дарга З.Батбаяр хэллээ. Тэгвэл нөгөө хэсэг нь усны үнийг нэмснээр асуудал шийдэгдэх үү гэж сөргөн асууна. Монголчууд бидний нэг сэтгэлгээ байдаг. Үнэтэй зүйлээ ихэд хайрлаж гамнадаг бол үнэгүй зүйлээ огт тоодоггүй, үнэгүй юм чинь гэсэн байр сууринаас ханддаг нь үнэн. Тэгэхээр усны мэргэжилтнүүд энэ сэтгэлгээг ашиглаж, усны үнийг ахиухан нэмээд өгвөл аж ахуйн нэгж, иргэд усыг үнэн сэтгэлээсээ гамнаж

http://www.mongolianeconomy.mn

хэрэглэдэг болно хэмээн тайлбарлав. Дэлхийд ус ашигласны төлбөр багасаад байгаа бол манайд эсрэгээр нэмэгдээд байгаа гэнэ. Энэ нь бусад улс усны үнэ цэнийг илүү мэдэрч амьдардаг тул усны хэрэглээндээ анхаарч, гамнах сэтгэлгээгээр хандаж байгаа учраас усны төлбөр багасаж байгаа бол манайд эсрэгээр нэмэгдсээр байгаа аж.

Говийн бүсэд усны хомсдол үүсэх үү?

Энэ нь манай улсын хувьд хамгийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Эх газрын тогтолцоо бас нууцлаг бөгөөд учиртай хэмээн байгаль дэлхий судалдаг нэгэн эрдэмтний хэлснийг санаж байна. Тухайлбал, Монголын говь хэвлийдээ маш их баялаг агуулсан хэрнээ тэдгээрийг ашиглаж хэрэглэхэд хүндрэл үүсгэхүйц нөхцөлийг бүрдүүлсэн нь ус юм. Говийн их наран ээж, газрын баялаг бүхий уул толгодыг гийгүүлсэн ч говьд гол мөрөн харам заяажээ. Усгүйгээр ордуудыг хэрхэн ашиглах билээ. Уурхайнуудын хэрэглэх хэмжээний усны нөөц говьд байна уу. Энэ асуудал Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санааг зовоож, тэрбээр Үндэсний аюулгүй байдлыг Сар шинийн өмнөхөн хуралдуулсан юм. Ус бол улс орны Үндэсний аюулгүй байдалтай зайлшгүй холбоотой. Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг Өмнөговь аймагт ажиллах үеэр бид усаа өгөхгүй шүү хэмээн хатуухан хэлэх иргэдийн харам сэтгэл усны үнэ цэнийг тэнд мэдэрч байгааг илтгэх.

Тавантолгойн нүүрсний орд газрыг ашиглахад усны асуудал хамгийн хүндрэлтэй байгаа. Одоогоор судлагдсан, Тавантолгойд хамгийн ойр, арвин усны нөөцтэй орд бол Балгасын улаан нуур хэмээх гүний орд. Уг ордын гидрогеологийн урьдчилсан хайгуулыг 1984 онд, нарийвчилсан хайгуулыг 1987 онд дуусгажээ. Судалгааны дүнд ордын усны нөөцийг 465л/секунд буюу 40176м3/хоног гэж тогтоосон. Харин 2007-2008 онд “Шандын булаг” компани тус орд дээр нэмэлт судалгаа хийгээд усны нөөцийг нэлээд хэмжээгээр багасган тооцоолжээ. Тус ордын нөөц нь ийм зөрүүтэй байгаа тул нарийвчилсан судалгааг дахин хийхээр Усны газраас энэ жил тендер зарлажээ. Тавантолгой ордын ашиглалтыг тогтвортой хэвийн явуулахын тулд эхний ээлжинд Балгасын улаан нуурыг ашиглах нь ойлгомжтой бөгөөд цаашдаа усны өөр эх үүсвэр хайх зайлшгүй шаардлагатай аж. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга говьд усны өөр эх үүсвэр давхар хайх, гадаргын усыг дамжуулах “Орхон-говь”, “Хэрлэн-говь” төслийн ТЭЗҮ-ийг яаралтай хийх чигийг өгсөн байна.

Усан цахилгаан станц Монголд хэрэгтэй юу?

Янз бүрийн санал бодолтой хүмүүс байдаг. Усны эрчим хүчийг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэх нэг хэсэг байхад боломжгүй гэх хүмүүс ч бий. Гэхдээ хийсвэр ойлголтоор алив асуудалд хандаж боломгүй санагдана. Баримт дээр тулгуурлаж ярья. Яагаад усан цахилгаан станцыг сонгох хэрэгтэй гэж.

Дэлхий нийтийн чиг хандлага нь усны эрчим хүчний хөгжил дээр үндэслэн бусад сэргээгдэх эрчим хүчний үүсвэрүүдийг ашиглахыг зорьж байна. Дэлхийн нийт эрчим хүчний 20 орчим хувь буюу 3000 тэрбум кВт.цагийг усан цахилгаан станцаас үйлвэрлэж байна. Дэлхий нийтийн чиг хандлага нь усны эрчим хүчний хөгжил дээр үндэслэн бусад сэргээгдэх эрчим хүчний үүсвэрийг ашиглахыг зорьж байна. Ялангуяа манай хоёр хөрш орны хувьд усны эрчим хүчийг түлхүү хөгжүүлж иржээ. Хятадын гурван хавцлын усан цахилгаан станц нь дэлхийн хамгийн том нь. Нийт чадал нь 22,000 МВт бөгөөд жилдээ 50 сая тонн нүүрс хэмнэж хүлэмжийн хийг үлэмж хэмжээгээр бууруулах экологийн цэвэр сэргээгдэх эх үүсвэр юм. Хойд хөршийн хувьд Ангар мөрний каскад дээр суурилагдсан усан цахилгаан станцын нийт чадал нь 12,000 МВт жилд 66 тэрбум кВтц үйлдвэрлэдэг. Энэ нь жилд 24 сая тонн нүүрс хэмнэнэ. Энэ мэтээр улс орнууд байгальд ээлтэй хөгжлийг бий болгохыг зорьж байна.

Усан цахилгаан станц нь усны нөөцийг бий болгож усны хомсдлоос гарах, үер усны болон ган гачигаас хамгаалах, нар салхи зэрэг нөхөн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй зэрэгцэн ажиллана, цахилгаан эрчим хүчний өртөг зардал тарифыг бууруулна, хүлэмжийн хийг бууруулахад тус дөхөм үзүүлнэ, том хэмжээний усан сан байгуулснаар ирээдүйд говийн бүсийн аж үйлвэрийн болон ахуйн усан хамгамжийн нөөц эх үүсвэртэй болно, аялал жуулчлал

Монголд ажиллаж байгаа усан цахилгаан станцуудын жагсаалт

УЦС-уудын нэр	Суурилагдсан хүчин чадал кВТ	Барилга байгууламжийн шийдэл	Хөрөнгө оруулалтын төрөл
1.Богдын гол	2000	Ус дэхүүлэх сувгатай	Улсын төсөв
2. Гуулин	400	Услалтын системийн сувгаас	Улсын төсөв
3. Манхан	150	Ус дэхүүлэх сувгатай	Улсын төсөв, орон нутгийн хөрөнгө
4. Мөнххайрхан	150	Ус дэхүүлэх сувгатай	Улсын төсөв
5. Өндөрхангай	200	Ус дэхүүлэх сувгатай	Тоног төхөөрөмж Вьетнам улсын тусламж, улсын төсөв
6.Хархорин	600	Услалтын ситемийн сувгаас	БНХАУ-ын тусламж
7.Үенч	960	Ус дэхүүлэх сувгатай	Улсын төсөв
8. Чигжийнгол	200	Ус дэхүүлэх сувгатай	Вьетнамын буцалтгүй тусламж
9.Тосонцэнгэл	375	Голын голдрилын, усны далантай	ХБНГУ-ын буцалтгүй төвшин өргөх тусламж
10.Эрдэнэбулган	150	Ус дэхүүлэх сувгатай	Дани улсын Засгийн газрын буцалтгүй тусламж
11.Завхан мандал	110	Боомттой	ХБНГУ-ын буцалтгүй тусламж
12.Цэцэн-Уул	150	Боомттой	ХБНГУ-ын буцалтгүй тусламж
13. Дөргөн	12000	Боомттой	Зээл тусламж
14.Тайшир	11000	Боомттой	Зээл тусламж
НИЙЛБЭР ЧАДАЛ	38445		

http://www.mongolianeconomy.mn

Монгол орны усны нөөц, ашиглалт



Нийт усны нөөц 609.5 шоо км буюу 609.5 тэрбум шоо метр

загасны аж ахуй,усалгаатай газар тариалан хөгжүүлэх зэрэг давуу талтай бол усан сан байгуулснаар тодорхой хэмжээний сав газар усанд ордог, ой мод өвс ургамал ан амьтдын уламжлалт амьдралд өөрчлөлт ордог, тосгон суурин газрын хүн амыг нүүлгэн шилжүүлэх үйл явц гардаг, батлагдаагүй цуу яриа, сөрөг сурталчилгаанд өртдөг зэрэг нийтлэг сул тал байдаг бөгөөд эдгээрийн эрсдэлийг тухайн станцын зураг төсөлд тусган сөрөг нөлөөлийг багасгах арга хэмжээ авч байгаль орчны нөхөн сэргээлтийг хийдэг байна..

Манай улсын хувьд усны эрчим хүчийг хөгжүүлэх боломж нөөц бол хэдийнэ судлагдаад гарчихсан аж. Өнөөдрийн байдлаар манайд том жижиг ажиллаж буй 14 усан цахилгаан станц байгаа бөгөөд нийт чадал нь 38445 квт.

Унгар улсын усны нөөц ашиглалтын төв, Монголын усны эрдэм шинжилгээ зураг төслийн хүрээлэнгийн “Монголын усны нөөцийг иж бүрдлээр ашиглах хамгаалах ерөнхий схем” судалгаагаар усны эрчим хүчний нийт нөөц 56 тэрбум кВтц, боломжит чадал 5700 Мвт гэж үнэлэгджээ. Нийтдээ 210 усан цахилгаан станц байгуулах боломжтой газрыг сонгож, үүнээс 150 нь 20 Мвт-ын бага чадлынх байх боломжтой гэсэн байна.

Сүүлийн үед эрчим хүчний салбарынхан том чадлын усан цахилгаан станц барьж байгуулах мөрөөдлөө ажил хэрэг болгохоор ихэд мэрийж буй ч улс төрийн шалтгаанаар эрчим хүчний инженерүүдийн мөрөөдөл бүтэхгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, том чадлын усан цахилгаан станц барьж байгуулснаар хойд хөршөөс эрчим хүчээр хараат байдлаас гарах боломж бүрдэх учраас үе үеийн Засгийн газрууд ажлыг эхлүүлдэг ч нэг л урагш явахгүй өдийг хүрсэн билээ. Өнөөдөр ч Сэлэнгэ мөрөн дээр цуваа усан цахилгаан станцууд барих нь үндэсний аюулгүй байдлыг бататгах талаар ярьж эхлээд байна. Энэхүү асуудлыг Ерөнхийлөгчийн зүгээс дэмжиж байгаад эрчим хүчний салбарынхан төдийгүй усны инженер, мэргэжилтнүүд баяртай байгаа юм билээ.

Энэ жилийн Монголын эдийн засгийн форумыг угтаад усны асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг хийсэн. Уг хэлэлцүүлгээр усны үнэ цэнэ, соёл, гамтай хэрэглээг бий болгох, усны үнэ эдийн засгийн хөгжлийн үндэс суурь болох тухай, ус бохирдуулагчийн төлбөрийн тухай хууль усны хэрэглээнд тодорхой үр дүн өгөх, усны эрчим хүчийг хөгжүүлж, ялангуяа хил даван урсдаг “эх ороонч бус” гол мөрөн дээр томоохон чадлын усан цахилгаан станц барьж байгуулж, үндэсний аюулгүй байдлаа бататгахын зэрэгцээ эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болох цаг болсон гэсэн дүгнэлтийг дээрх хэлэлцүүлэгт оролцогчид хийгээд Эдийн засгийн форумаар энэхүү асуудлыг баяжуулан хэлэлцэх нь зүйтэй хэмээсэн юм.

Иргэд бидний оролцоо

Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах ажил бол иргэд бидний үүрэг. Зөвхөн төр хийдэг зүйл биш юм аа. Хамгийн гол нь ард иргэд усаа хайрлан хамгаалж, гамнах сэтгэлгээтэй бол төрийн бодлоготой бодлогогүй байгаль дэлхий сүйтгэгдэхгүй шүү дээ. Тиймээс байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах уламжлалыг сэргээж, байгальдээ ээлтэй үйл ажиллагаа явуулж, үр хүүхдээ ч зөв хүмүүжлээр өсгөж чадвал бидний тус, том хувь нэмэр, хөрөнгө оруулалт юм аа. Тэгэхээр олон нийтийн сэтгэлгээг өөрчилж, усаа хайрлан хамгаалах, бохирдуулахгүй байхад чиглэсэн үйл ажиллагаа явуулахад анхаарч амьдрах мэссэжийг Монголын эдийн засгийн форумын Ногоон шийдэл-Усны менежмент салбар хуралдаанаас гаргаж, усны үнэ цэнийг бий болгох, усны эрчим хүчийг хөгжүүлэх асуудлын талаар тодорхой зөвлөмж гаргаж, төрийн бодлогод оруулж ажиллах нь өнөө жилийн форумд усны асуудлыг оруулж хэлэлцүүлсний үр дүн болох юм. ■

http://www.mongolianeconomy.mn

Цэвэр эрчим хүч

Нүүрс үү, салхи уу?

Б.Энхцэцэг

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын эрчим хүчний ганц нөөц нь нүүрс. Эрчим хүчний зориулалтаар ашиглах 12 тэрбум гаруй тонн нөөцтэй 200 гаруй нүүрсний уурхай манайд бий. Одоогоор зөвхөн уламжлалт нүүрс шатаах технологийг ашигладаг учир бүтээмж бага байгаагийн зэрэгцээ хүрээлэн буй орчинд халтай "лүд" болж хувираад байгаа юм. Баян хүнийг балаг тойрохгүй гэдэг шиг нүүрсээр бэл бэнчин сайтайн ачаар ч гэх үү, бачаар ч гэх үү Монгол Улсын өмнөд хэсэгт ид олборлолтын ажил өрнөж, импортын ашиг багагүй хувиар нэмэгдсээр байгаа билээ. Гэхдээ тооноос илүү чанар хэмээн үглэдэг хэсэг хүмүүсийн нүдээр нүүрс түүхийгээрээ, боловсруулалтгүй, улсын хилээр гарч байна.

Нягтлан үзвээс Хятадын Үндэсний статистикийн газар "Хятадын нийт импортолсон нүүрсний дундаж үнэ тонн тутамд 115 ам.доллар" гэсэн судалгааг гаргажээ. Гэтэл манай орны нүүрсний экспортын дундаж үнэ 100 ам.доллар байгаа нь дэлхийн дунджаас дор хаяж 10 доллараар /Австрали улс Хятад улс руу 110 ам.доллараар гаргадаг/ бага байгаа юм. "Source watch.com" сайтад өгүүлснээр Хятад улс Монголоос импортолсон хямд үнэтэй нүүрснээс өнгөрсөн онд зургаан тэрбум доллар хэмнэсэн гэжээ. Манай урд хөршийн нүүрсний импорт дотоодын хэрэгцээнээс шалтгаалан ирэх жилүүдэд үлэмж нэмэгдэх хандлагатай байна. Харин нүүрсний үнэ сүүлийн хоёр сард долоон хувиар буурсан бөгөөд энэ онд ч мөн доошилсоор байх төлөвтэй байгааг мэргэжилтнүүд анхааруулж байгаа юм.

Дэлхийн хэмжээнд өдөрт 19 сая тонн нүүрс хэрэглэдэг гэсэн статистик бий. Энэ хэрэглээ ирэх жилүүдэд улам нэмэгдэх хандлагатай байгаа гэнэ. Ер нь цэнхэр гариг дээр 3.6 тэрбум хүн эрчим хүчгүйгээр амьдарч буй. Тиймээс улс орнууд эдгээр хүнд гэрэл цахилгаан хүргэх зорилгоор ирэх 20 жилд хоёр тэрбум хүний эрчим хүчний хэрэгцээг хангахаар ажиллаж байгаа аж. Тэгэхээр нүүрснээс гаргаж авах эрчим хүчийг л нэмэгдүүлж байж харанхуй дундах иргэдэд гэрэл цахилгааныг хурдацтайгаар хүргэх бодлого барих юм байна.

"Бусад эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэх нь чухал. Тэгэхдээ энэ их өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг хангах суурь гол шийдэл нь цэвэр нүүрс юм" гэж Дэлхийн хувийн хэвшлийн нүүрсний хамгийн том компани болох "Пийбоди Энержи" үзэж байна. Тус компанийн "Ногоон нүүрс" хэмээх төлөвлөгөө нь нүүрсийг боловсруулах өндөр технологи ашигласнаар ялгарлыг бүрэн устгах, улмаар олон арван сая ажлын байр бий болгохоос гадна эдийн засгийг үйлдвэржилтийн шинэ шатанд гаргах зорилготой юм байна. Өөрөөр хэлбэл, дэлхийн нүүрсний хөгжлийг тодорхойлогч "Пийбоди Энержи" компани хамгийн гол нь нүүрсийг байгальд ээлтэйгээр ашиглаж хөгжлийг бий болгох хэрэгтэй гэж үзэж байгаа аж.

Тэгвэл манай улсын нүүрсний

Монгол Улсын эрчим хүчний үйлдвэрлэл

Усан цахилгаан станц	0.3%
Дизель станц	1.3%
Оросоос импортлох эрчим хүч	8.1%
Салхины эрчим хүч	0.2%
Нарны эрчим хүч	0.25%
Дулааны цахилгаан станц	89.85%

Эх сурвалж: Эрчим хүчний газар

Монголын нүүрсний экспорт /сая.тн/



Эх сурвалж:

http://www.mongolianeconomy.mn

бодлого томоохон экспортлогч орон болох зорилго тавьжээ. Дөрвөн жилийн өмнө жилд дөрвөн сая тонн нүүрс олборлож гадаад зах зээлд гаргадаг байсан бол өнөөдөр 22 сая тонныг олборлож байна. Ирэх 2020 он гэхэд 70 сая тонн нүүрс экспортлох таамаг бий. Тиймээс энэхүү баялгийг түүхийгээр нь дэлхийн зах зээлийн үнээс хямдаар бус доод тал нь 60, 70 хувийг боловсруулж гаргах нь илүү ач холбогдолтой билээ. Үүний тулд технологийн шинэчлэл хийж, байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулахад анхаарч ажиллах шаардлагатай, мөн уул уурхайн компаниудын менежментийг сайжруулж, зардлыг бууруулах нь тус салбарын өмнө тавигдаж буй том асуудал болоод байна.

Салхитай Монгол

Манай оронд нар жилийн 250 өдөр ээдэг бол талын салхи тасралтгүй хацар илбэж байдаг билээ. Тэнгэр одоор баян гэдэг шиг Монгол Улс салхиар баян. Манай орны жилийн дундаж салхины хурд 4-9 метр секунд.Тэгвэл дэлхий дээрх ихэнх салхин сэнс 4-5 метр секундын хурдтай салхинд эргэж, эрчим хүч үйлдвэрлэх чадалтай байдаг аж. Тэгэхээр манайд салхины эрчим хүчийг хөгжүүлэх боломж нөөц байна гэсэн үг. Ялангуяа Монголын хээр болон цөлөрхөг бүсэд салхи ихтэй. Дээрх бүсэд жилийн дундаж салхины хурд 4-6 м/с бол Хэнтийн ууланд 1-2 м/с, бусад нутагт 2-3 м/с байна.

Дэлхийн эрчим хүчний ирээдүй тодорхойгүй болсон өнөө үед улс орнууд салхинаас гаргаж авах эрчим хүчээ хурдацтайгаар нэмэгдүүлж байна. “Дэлхийн салхины эрчим хүчний консул”-ын үзүүлэлтээс харахад 2011 онд дэлхийн салхины эрчим хүчний чадал 41 Гвт-аар нэмэгджээ. Өнөөдөр нийт 75 орон салхины эрчим хүчний эх үүсвэртэй бөгөөд тэдгээс 22 улс нь хэдийнэ нэг Гвт-аас давсан эрчим хүчийг гаргаж авах хүчин чадалтай болчихсон аж. Мөн түүнчлэн салхи 2013 онд дэлхийн нийт эрчим хүчний 3.35 хувь, 2018 он гэхэд найман хувийг эзэлнэ гэсэн төлөвийг судлаачид гаргажээ. Дэлхийн 48 оронд салхин сэнсийг хэрхэн ашиглах, түүнээс гарах энергийн ашиглалтыг зохицуулах тухай хууль, дүрмийг баталсан байдаг байна.

Манай улсад бүтээн байгуулалтын өртөг өндөртэй энэхүү бизнесийг “Ньюком групп” эхлүүлсэн бөгөөд тун



Монголын нийт газар нутгийн 10 хувь (160000км²) нь салхины өндөр нөөцтэй болох нь тогтоогдсон

удахгүй энэ онд эхний ээлжинд нийт 50 МВт хүчин чадалтай “Салхит” нэртэй салхин цахилгаан станцыг ашиглалтад өгөхөөр төлөвлөж байна. Тус группын гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан “Бид энэхүү станцыг ашиглалтад оруулснаар жил бүр 120 мянган тонн нүүрс, 1,2 сая гаруй тонн ус хэмнэж чадна. Үүгээр ч зогсохгүй, 150 мянга гаруй тонн хүлэмжийн хийг бууруулах боломжтой болно” гэсэн юм. Төлөвлөгөөний дагуу “Ньюком групп” дараагийн ээлжинд Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 300 МВт хүчин чадалтай салхин станцыг 2015 он гэхэд барьж дуусгах юм байна. Харин 2025 онд гурав дахь томоохон төслийн ажил нь дуусаж 1000 МВт-ын станц боссон байх таатай мэдээ бий.

Эрчим хүчний зохицуулах газрын судалгаагаар манай улс эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 93 хувийг нүүрснээс, 6.8 хувийг шингэн ба хийн түлшнээс, зөвхөн 0.2 хувийг л сэргээгдэх эрчим хүчнээс гарган авдаг ажээ. Харин Салхитын салхин станц ашиглалтад орсноор салхи дангаараа манай орны нийт эрчим хүчний таван хувийг хангах юм.

Сэргээгдэх Эрчим хүчний Үндэсний хөтөлбөрт “..2010 оны улсын эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 3-5 хувийг сэргээгдэх эрчим хүчнээс гаргаж авна” гэсэн байдаг. Тиймээс боломж бололцоогоо ашиглан цаашид салхины эрчим хүчний үйлдвэрлэлийг таван хувиас ч ахиулах боломжтойг харгалзан тууштай зорилт тавин ажиллах нь зүйтэй хэмээн “Нүүрс үү, Салхи уу” хэлэлцүүлгийн үеэр оролцогчид хэлж байлаа.

“Нүүрсний асар их баялагтай, мөн олборлолтын өртөг харьцангуй хямд байдаг манай улсын хувьд нүүрс шингэрүүлэх үйлдвэр байгуулснаар газрын тосны үнийн өсөлтийн дарамтнаас ангижрах цаашлаад нефтийн бүтээгдэхүүний хувьд гадаад орноос 100 хувь хамааралтай байдал арилна. Мөн Монгол Улсад химийн үйлдвэрлэл хөгжих үндэс ч тавигдана” хэмээн МУИС, ХХИС, Хими технологийн тэнхимийн багш, доктор Б.Батцэнгэл тус хэлэлцүүлгийн үеэр илтгэлдээ дүгнэн хэлсэн юм.

Мөн түүнчлэн оролцогчдын зүгээс салхин цахилгаан станц технологийн хувьд дангаараа явахад хүндрэлтэй. Нэг хэсэгтээ нүүрстээ тулгуурлаж, салхиар туслуулах нь ойлгомжтой. Салхи нь илүү, нүүрс нь илүү гээд ялгаад байх зүйл үгүй. Аль аль нь хэрэгтэй. Иймд ус хэрэглэдэггүй, утаа бага гаргадаг байгаль орчинд ээлтэй технологи руу бодлогоо чиглүүлж, нөгөө талаар нүүрсийг орчин үеийн шинэ технологиор шатааж, хорыг нь багасгах тал дээр анхаарах замаар сэргээгдэх эрчим хүчний асуудлыг зөв бүтэцтэй авч явья гэсэн саналуудыг дэвшүүлсэн юм.

Оюу Толгой

ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА БА ТОО БАРИМТ

2013 он

7.8 их наяд төгрөг
(6 тэрбум ам доллар)
Уурхайн үйл ажиллагаа эхлэх хүртэлх хугацаанд оруулах нийт хөрөнгө оруулалт

900 тэрбум төгрөг
(700 сая ам доллар)
Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө Монгол улсын Засгийн газарт төлөх татвар, төлбөр

Одоо

4.5 их наяд төгрөг
(3.5 тэрбум ам доллар)
Оюу Толгой төсөлд өнгөрсөн 18 сарын хугацаанд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ

300 тэрбум төгрөг
(250 сая ам доллар)
Монгол улсын Засгийн газарт урьдчилгаа хэлбэрээр төлсөн татвар

10,4 тэрбум төгрөг
(8 сая ам доллар)
Оюу Толгой төсөл өдөр бүр 10,4 тэрбум төгрөгийн бараа үйлчилгээг худалдан авч байна.

Нийт ажилчдын тоо **15,000**

10,000 Монгол ажилчид

Оюу Толгойн уурхай 2013 онд ашиглалтад орж бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлнэ.



Оюу Толгой ХХК Монгол улсын түүхэнд хамгийн том сургалтын хөтөлбөрийг боловсруулж 110 тэрбум төгрөгөөр (85 сая ам.доллар) санхүүжүүлэн хэрэгжүүлж байна.

110 тэрбум төгрөг *(85 сая ам.доллар)*

Энэ ажлын хүрээнд технологийн 2 жишиг сургуулийг барьж байгуулах, 4 МСҮТ-ийг сэргээн засварлах ажлыг гүйцэтгэж, 1200 мэргэжлийн багш бэлтгэж, 3300 Монгол залуусыг сургаж байна.

1,200 мэргэжлийн багш

3,300 мэргэжилтэй монгол залуус

2019 онд Монгол улсын экспортын хэмжээ одоогийнхоос 2 дахин нэмэгдэж үүний тал хувийг Оюу Толгой дангаараа бүрдүүлнэ

Уурхайн үйлдвэрлэл эхэлснээс хойш 10 жилийн дотор авч ажиллуулах Монгол инженерүүдийн нийт хувь

70% Монгол инженер

Уурхай 2013 онд ашиглалтад оруулснаар шууд ажиллах Монгол ажилчдын тоо

3,000 Монгол ажилчид

Уурхай ашиглалтад орсны дараах нийт Монгол ажилчдын хувь

90% Монгол ажилчид

Оюу Толгой төсөлд үндэсний 1000 гаруй ханган нийлүүлэгч компани бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд эдгээрийн 200 нь орон нутгийн ханган нийлүүлэгчид болно.

1000 Үндэсний ханган нийлүүлэгч компани

30 тэрбум төгрөг

Оюу Толгой ХХК Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилд нийт 30 тэрбум төгрөгийн хандив, тусламжийг үзүүлээд байна.

http://www.mongolianeconomy.mn

48 Тиймээ, бид Монголын Economist болох зорилготой

49 Сэтгэл нэг л их догдлонгуй

52 Тэд хөрөнгө оруулалтыг хэрхэн “чулуу” болгож чадсан бэ

Made in Mongolia

Монгол брэндийг хөлд оруулъя

Х.Ананд

Алийг нь дэлхийн брэнд болгож болох вэ? Уул, уурхай, түүхий нүүрс, ашигт малтмал, стратегийн ач холбогдол бүхий 15 орд газар бол сурталчилгаа, бодлого шаардахгүй угаасаа брэнд болчихсон. Ноос, ноолууран бүтээгдэхүүн, чацаргана, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, монгол малын мах, ардын урлаг, хөөмий, уртын дуу бол дэлхийд байхгүй брэнд. Эдгээрийг байгалийн гаралтай, эрүүл мэндэд ач тустай гээд чанарын хувьд хэнд ч зарлан тунхаглаж, бодлого боловсруулах шаардлагагүй. Гэхдээ эцсийн бүтээгдэхүүн гэдгээр бус цэвэр түүхий эд гэдэг утгаараа дэлхийд брэнд юм.

“Монгол брэнд-дэлхийд 2012” чуулга уулзалт саяхан болж өнгөрлөө. Тус форумд оролцогчид “Олон улсын зах зээлд Монгол Улсын брэндийг бий болгох бодлогын асуудал” сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэв. Хэлэлцүүлгээр чацаргана, ноос, ноолууран бүтээгдэхүүн, аялал жуулчлалын салбар гээд брэнд бүхнийг олон улсын зах зээлд гарах нөөц боломж, тулгарч болох бэрхшээлийн талаар оролцогчид ярилцав.

Бидний эцсийн бүтээгдэхүүн болгож, гаднынханд илүү үнэд хүргэж өгч чадахгүй байгаа олон бүтээгдэхүүний нэг нь чацаргана. Ирээдүйд нүүрснээс илүү моодонд орж, Монголын брэнд болох бололцоо өндөртэй, гаднынханд эрэлттэй энэ байгалийн жимсийг “чулуу” болгоход юу дутаад байгааг Монголын чацаргана тариалагч, үйлдвэрлэгчдийн үндэсний холбооны тэргүүн Д.Насанжаргал “Хаан жимс чацарганын тариалалт, үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлэх нь” сэдэвт илтгэлээрээ хөндлөө. Өнгөрсөн онд ердөө л 655.2 тонн чацаргана хураан авсан ч түүнийхээ 5000 гаруй тонныг түүхийгээр экспортолж, тонн тутмыг 4500-5000 ам.долларaар худалдаалжээ.

Чацарганы тариалалтын талбайг 2016 он гэхэд одоо байгаагаас нь 20 мянган га-гаар тэлэх, ургацыг 35 мянган тоннд хүргэхээр “Чацаргана” хөтөлбөрийнхөн төлөвлөж байгаа аж. Чацарганагүй, чацарганаар “өвдсөн” Унгар, Шинэ Зеланд тэргүүтэй орнууд БНХАУ, ОХУ, Их Британи, Итали зэрэг орноос ердөө нэг тонн түүхий чацарганыг 4000-7000 ам.долларaар худалдан авдаг байна.

Чацарганы тос үүнээс ч өндөр үнэтэй аж. Манайхаас чацарганын нэг тонн тутмыг нь 5000 ам.долларaар импортолсон японууд 100 миллграмм чацарганы тосыг 120 ам.долларaар худалдаалдаг байна. Монгол чацаргана гадаад зах зээлд ямар алт шиг үнэтэй эд болохыг Та эндээс анзаарч байгаа биз ээ.

Япон улс чацарганын орцтой гоо сайхны бүтээгдэхүүн хүртэл үйлдвэрлэх туршилт хийж эхэлжээ. Тэгвэл гол түүхий эдээ Монголоос татах нь мэдээж. Иймд ирээдүйд тарих гэж буй 35 мянган тонн чацарганаа түүхийгээр нь экспортлохгүй байх нь чухал юм. Үүний тулд дэвшилт технологитой үйлдвэрүүд шаардлагатайг мэргэжилтнүүд онцлон тэмдэглэж буй. Ядаж л чацарганын тос гаргаж авдаг үйлдвэр байгуулахад төрийн дэмжлэг ихээхэн хэрэг болж буйг хүмүүс ярьж байна. Гэхдээ энэ салбарт хэрэгтэй техник технологийг нэвтрүүлж, чацарганын тос үйлдвэрлэхэд дор хаяж долоон жил шаардлагатай аж. Байгаа баялгаа үнэд хүргэж чадахгүй байгаагийн гол шалтгаан нь тухайн салбарт хэрэгтэй дэвшилт технологи, боловсруулах арга механизм гэдгийг хэлэлцүүлэгт оролцогчид дурдаж байсан.

Үүнээс гадна “Нью жуулчин групп”-ын ерөнхий захирал Ш.Нэргүй “Монголын аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөв” сэдэвт илтгэлээрээ монгол аялал жуулчлалыг дэлхийн брэнд болгох санал дэвшүүлсэн. Тэрбээр байгалийн үзэсгэлэнт газрууд, монгол зан заншил, нүүдэлчин түмний сэтгэлгээ, монгол ахуйн байдлыг үзэх гаднынхны сонирхол их. Манайд аялал жуулчлалын салбар жилээс »

http://www.mongolianeconomy.mn

жилд хөгжиж байна. Тиймээс аялал жуулчлалын тухай хуулийг шинэчлэн найруулж, олон улсын түвшинд ямар бодлого барьж ажиллавал жуулчдын анхаарлыг татах вэ, цэвэр бохир ус, цахилгаан, дулааны шугам сүлжээнд яаралтай холбогдох зэрэг жижиг сажиг асуудлыг ч орхилгүй бодлогын түвшинд авч үзмээр байна. Баазуудын тоог төлөвлөгөөний дагуу зөв зохист газруудад байгуулж, жуулчдын анхаарлыг татах нь зөвхөн энэ салбарт бус эдийн засаг, улс орны хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулна" хэмээв.

"Монголын ноос, ноолууран бүтээгдэхүүний экспорт, брэндингийн өнөөгийн төлөв байдал" сэдвээр ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Батцэцэг илтгэл хэлэлцүүллээ.

Монгол ноос, ноолууран бүтээгдэхүүн чанараараа дэлхийн зах зээлд хоёрт жагсдаг. Монгол Улс ноос, ноолуурыг самнасан, самнаагүй, бохир гэсэн гурван хэлбэрээр экспортолж байна. Чацарганын экспорттой адил зарчмаар энэ бизнес явагддаг. Түүхий эдийг нь бид хангаж, гаднынхан эцсийн бүтээгдэхүүн болгон өндөр үнээр бусдад зарж байна" гэв. Тиймээс бидэнд орчин үеийн тоног, төхөөрөмж, хөрөнгө мөнгө хэрэгтэй болно. Ноос, ноолуур, хөөврийг ашиглан шинэ нэрийн бүтээгдэхүүн гаргах, барилгын дулаалга, тусгаарлагч материалын, техникийн эсгийний үйлдвэрүүдийг шинээр нэмж, ашиглалтад оруулах шаардлагатай. Энэ тохиолдолд бид өөрт байгаа баялгийг гаднын орнуудад хямд үнээр экспортлох бус дотооддоо ч баялаг бүтээх боломжтой болох юм. Үүнд төрийн зүгээс тодорхой анхаарал хандуулж, хамтран ажиллах хэрэгтэй байна" гэлээ.

Монголчуудад өөрсдийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээ дэлхийн брэнд болгох хүсэл их ч гадаад зах зээлд гарч чадахгүй байгаа болон гарч болох арга замуудыг тодорхой болгох асуудал өдгөө тулгамдаад байна. Нэг үгээр хэлбэл, чацаргана, ноос ноолуур, мах зэрэг дэлхийн зах зээлд нэр хүнд олоход ойрхон байгаа монгол брэндүүдийг хөлд оруулах цаг болжээ. ■







Компанийн нийгмийн хариуцлага

Компанийн нийгмийн хариуцлага үнэт чанарын тусгал юм

Х.Хулан

Профессор Брэдли К.Гоогинс нь АНУ-ын Бостон коллеж дахь Компанийн нийгмийн хариуцлагын төвийн захирал асан. Тэрбээр тус коллежийн Кэррол менежментийн сургуульд багшилдаг. Гоогинс үүний өмнө 20 гаруй жилийн турш Бостоны их сургуульд профессороор ажиллахын сацуу Ажил, гэр бүлийн төвийг үүсгэн байгуулсан аж. Тэрбээр бизнесийн нийгэмд гүйцэтгэх үүрэг бөгөөд ажил амьдралын тэнцвэртэй байдлаас нийгмийн хариуцлагын чиглэлээр судалгааны ажил хийж, нийтлэл бичдэг. Гоогинс нь ГОУХАН-ээс өнгөрсөн онд Улаанбаатар хотноо зохион байгуулсан "Өрсөлдөх чадвар ба компанийн нийгмийн хариуцлага" олон улсын хуралд урилгаар оролцсон юм. "Mongolian Economy" сэтгүүлийн Х.Хулан түүнтэй хийсэн ярилцлага хийсэн юм.

-Та манай улсад анх удаа айлчилж байна уу, өөрийн сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?

-Тиймээ, би Монголд анх удаа айлчилж байна. Гуравхан хоногийн хугацаатай ирсэн ч энд үзэж харж, суралцаж буй зүйлс үнэхээр гайхшруулж байна. Намайг юу тэгж их гайхшруулаад байна вэ гэвэл танай орны өргөн уудам нутаг ба хүн амын тоо. Газрын гүнд орших байгалийн баялаг эдийн засгийн огцом өсөлтийг бий болгожээ. Дэлхийн бусад орон буурч буй өсөлттэйгээ тэмцэж байхад танайд ийнхүү өсөлтийн цаг үе эхэлсэн байна. Маргаашийн нийгмийг хэрхэн бүтээн байгуулах вэ гэдэг асуудлын бэрхшээлүүд надад нэлээд сонирхолтой санагдаж байна.

-Та Монголын тухай олон ном уншсан байх. Таны нүдээр харсан зүйлс тань мэдээллийн бодит байдалтай хэр нийцэж байна вэ?

-Шилжилтийн үе дээр гол анхаарлаа хандуулсан. Энэ нь танай орон ба хойд хөрш хоорондын харилцаа, социалист дэглэмээс ардчилал руу шилжсэн тухай түлхүү судалсан. Харин миний уншсан материал дээр зөрөөтэй байсан зүйл бол хүн амын тооны мэдээлэл. Монголчууд ирээдүйгээ их ойлгохыг оролдож, мөн баялгийг ашиглахыг зорьж байна.

Норвеги улс газрын тосоо яаж ашигласан жишээг надад ихээхэн санагдуулж байна. Танай бизнесийн салбар их сонирхолтой байна. Хурлын үеэр сонссон /Тэнгэр санхүүгийн нэгдлийн М.Болд захирлын/ илтгэл

http://www.mongolianeconomy.mn

миний олон улс оронд сонсож байсан илтгэлүүдээс хамгийн мундаг нь байлаа. Тухайн орны манлайлал хаанаа байгааг би ямагт олох гэж оролддог. Төрд үү, хувийн хэвшилд үү? Гэхдээ би Монголд удаан хугацаанд байж үзээгүй тул танай төр, хувийн хэвшил хэрхэн хамтарч ажилладаг тухай хэлж чадахгүй.

-Сүүлийн үед Монгол Улс байгалийн баялгаараа дэлхийн анхаарлын төвд орох боллоо. Та үүнтэй холбоотой тогтвортой хөгжлийн тухай юу хэлэх вэ?

-Байгалийн баялгийг тойрсон асуудлыг ажих миний хувьд сонирхолтой байдаг. Дэлхий даяар энэхүү баялаг нь хэнийх вэ, хэн үүний эзэмшигч нь вэ гэсэн мэтгэлцээн улам их гарах болсон. Өнгөрсөн үед гаднаас орж ирсэн компаниуд эргүүлж өгөхөөсөө илүү их авдаг байсан. Ийм тохиолдолд тухайн улс өөрийн нөөц баялгаас бүрэн ашгийг авч чадахгүйд хүрдэг.

Монгол орны хувьд энэхүү үйл явдал 1990 онд биш, харин 2011 онд тохиож буй нь завшаантай хэрэг. Учир нь, дэлхийн өнцөг бүрээс компаниуд орж ирэн, улс орны хувьд ашигтайгаар тохиролцож нөөц баялгийг авах нөхцөл 2011 онд илүү сайтар бүрдсэн. Улс орон эхэлж өөрийн ашиг сонирхлыг хамгаалж, компанийн эрх ашгийг харин удаах байранд авч үзэх ёстой.

Компаниуд орж ирээд, баялгийг олборлочихоод гараад явлаа гэхэд Монгол хүн 30 жилийн дараа хаана байх вэ, ирээдүйг тогтвортой байлгахын тулд юу хамгийн чухал байгааг хэлэлцэх цаг үе иржээ. Байгаа баялгаа хэрхэн ашиглахаас шалтгаалж жинхэнэ тогтвортой хөгжлийн замаар явах уу эсхүл улс орны дийлэнх хэсэгт ашиг хүртээлгүй албадаад байна уу гэдэг нь харагддаг.

Бусад улс орны жишээг судлах нь чухал. Тэдний суралцсан зүйлээс Монгол мөн суралцаж болно. Чили, Филиппин, Хятад гэхчлэн орнуудын уул уурхайн салбарт өрнөсөн асуудлыг бид нэлээд харсан. Хамгийн гол нь тогтвортой байдлын асуудлыг чухлаар тавих хэрэгтэй. Өнөөдөр ямар байгаа байдал бус, харин хэрхэн яаж төгсгөх үе шат илүү чухал. Үүнд Засгийн газар болон ард иргэд энэ бүхнээс үр ашгийг авч байгааг баталгаажуулах тул тэдний зүгээс томоохон үүрэгтэй оролцохыг шаардана.

Фотог Э.Зоригт

-Та Монголын компанийн нийгмийн хариуцлага сэдэвтэй олон улсын хуралд оролцлоо. Манай улс КНХ-ыг хөгжүүлэхэд цаашид юу хийж болох вэ?

-Өнөөгийн нийгэмд бизнесийн салбарын гүйцэтгэх үүрэг тэргүүн зэргийн ач холбогдолтой болсон. Энэ нь өрсөлдөх чадвартай уялдаатай. Иймд компаниуд заримдаа миний нэрлэдгээр XXI зууны сүм хийдүүд юм. Тэд хамгийн их нөлөө үзүүлдэг бөгөөд сүм хийд, хаан хатдын залардаг байсан өндөр уулан дээр суудаг. Энэ нь өнөөдөр корпорациуд. Хариуцлага гэдэг нь зөвхөн ёс зүйн төдий асуудал биш. Нийгмийг бүрэлдүүлэхэд тэдний үүрэг юу вэ гэдэг нь илүү чухал асуудал. Байгаль орчны асуудалд тэд ямар үүрэгтэй хандаж байна? Түүхээс авч үзвэл компаниуд байгаль орчныг тойрсон асуудал бол бидэнд хамаагүй, Засгийн газрын үүрэг гэсэн хандлагатай байсан. Шинэ технологи, ил тод байдал гарч ирснээр тэрхүү хандлага өөрчлөгдсөн. Эдгээр нь “Компаниуд та нар эрх мэдэл, үр нөлөөтэй учир нийгмийн зарим асуудлыг хариуцна. Иймд үйлдвэрлэж

http://www.mongolianeconomy.mn

буй бүтээгдэхүүнийг аюулгүй, байгаль орчныг бохирдуулахгүй байх ажлыг эхлүүлэхийн тулд Засгийн газрыг зөвхөн хууль тогтоогч мэтээр үзэх нь зохисгүй юм. Та бүгд бизнесийг хариуцлагатай болгох өөрийн гэсэн арга замыг яагаад хайж олж болохгүй гэж.

Хариуцлагатай бизнес гэдэг нь бүх нийтийн сайн сайханд үйлчилнэ. Үүнийг хэр их ашиг олдог хэмжүүрээр биш, харин бид бүгдийг хэдий их хөгжил цэцэглэлтэд хүргэх вэ гэдгээр хэмжинэ. Компаниудын үүрэг өргөжин тэлж, тогтвортой нийгмийн төлөө баялгийг бүтээхийн тулд бүх талын оролцогчидтой хамтран ажиллахыг зорилгоо болгодог болсон. Манай оронд жишээ нь цөөн тооны хүн маш өндөр ашиг олж байгаа байдал анзаарагддаг. Тэр бол тогтвортой байдал биш. Компаниуд зөвхөн ашиг орлого олдог явцуу хүрээнээс нийгэмд томоохон үүрэг гүйцэтгэдэг чиглэл рүү хэрхэн шилжин орох вэ гэдэг асуудалтай нүүр тулж байна.

-КНХ-ыг манайд хандив өгөх хэлбэр гэж ойлгодог. Америкт ямар байдаг вэ?

-Хандив тусламж өгдөг тэрхүү хуучин загвар одоо хүртэл Америкт ноёрхсон хэвээр. Яагаад гэвэл компаниуд ямарваа нэг юмыг буцааж өгч байх хэрэгтэй гэсэн ойлголттой. Буяны үйл ажиллагаа хялбар байдаг. Зүгээр л чек биччихнэ, тэгээд боломж таарууй байвал харин юу ч хийхгүй. Гэтэл өнөөдөр Та хэдий хэмжээний мөнгө өгч байна вэ гэдэг биш, харин энэ мөнгөө яаж олж байна вэ гэдэг асуудал нь чухал болсон. Та бүтээгдэхүүн, үйлчилгээгээ яаж зах зээлд гаргаж байна? Байгаль орчиндоо хэрхэн хандаж байна?

Миний хувьд, КНХ гэдэг нь тухайн компанийн төлөвлөсөн үнэт чанарын тусгал юм. Энэхүү тогтоож өгсөн үнэт чанарт хариуцлага байхгүй ч гэсэн манай үнэт чанар энэ байна гэж компаниуд хэдэн ч жил хэлж болох юм. Өнөө үед компьютерийн хулганыг ганцхан дарахад л тухайн компани өөрийнхөө тухай юу гэж хэлж байна, бодит жишээн дээр ямар вэ гэдгийн хоорондох ялгааг гаргаж чадна. Үүнд, ажилтнууд нь компаний тухай юу гэж боддог, ямар бүтээгдэхүүн үйлчилгээг нийлүүлдэг, байгаль орчны тогтвортой байдалд хувь нэмэр оруулдаг эсэх гэхчилэн багтана. Компаниуд шинэчлэлийн тухай маш сайн ойлголттой байдаг. Нийгмийн бүх хэсэгт шинэчлэл хэрэгцээтэй. Компаниуд тэрхүү шинэчлэлийг хэрхэн нийгэмд шилжүүлэх вэ?

Монгол Улсыг хамгийн сайн жишээ болно гэж үзэж байна. Хэн нэгэн орж ирээд, байгалийн ихэнх баялгийг ухаж олборлочихоод, улс оронд багахан хэсгийг үлдээгээд гараад явчих магадлалтай. Гэтэл Та бүгд үүнээс ч илүү зүйлийг бүтээж чадна. Өнөөдөр компанийн нийгмийн хариуцлагын асуудлыг ихээхэн бодож тунгаах шаардлагатай. Компаниуд төрийн бодлогод хэрхэн эерэгээр нөлөөлж болох вэ гэдэг асуултад өгөх хариуг эргэцүүлэн бодох цаг иржээ.

Хариуцлагатай бизнес гэдэг нь бүх нийтийн сайн сайханд үйлчилнэ. Үүнийг хэр их ашиг олдог вэ гэдэг хэмжүүрээр биш, харин бид бүгдийг хэдий их хөгжил цэцэглэлтэд хүргэх вэ гэдгээр хэмжинэ.

-Та КНХ-ын тал дээрх туршлагаасаа хуваалцана уу. Засаг захиргааны зүгээс хариуцлагатай компанийг яаж урамшуулж болох вэ?

-Хэдэн жилийн өмнө би Америкт компанийн нийгмийн хариуцлагын төвийг хариуцдаг байлаа. Зарим компани нь Форчюн 500-гийн жагсаалтад орсон байсан. Би тэдэнтэй танилцаж, өдөр бүр хамтарч ажиллах болсон. Хэдэн жил өнгөрсний дараа харин тэдгээрийн КНХ-ын түвшин адилгүй байсныг анзаарч эхэлсэн. Иймд би КНХ-д зориулж манлайлал, стратегийг багтаасан таван үе шатыг боловсруулсан. Компаниудын дунд Та өөрийгөө одоогийн байдлаар эдгээр үечлэлийн алин дээр нь байна гэж бодож яваа вэ гэсэн асуулга өгсөн. Эхнийх нь уламжлалт үе шат бөгөөд “Мөнгө өгдөг” гэсэн байхад дараагийнх нь “Бизнесийг ашиглан нийгмийг өөрчилмөөр байна” гэсэн заалттай байсан. Тэгэхэд оролцогчдын 90 хувь нь хоёрдугаар үе шатанд байгаа байхаа гэж хариулсан байв. Энэ нь шинэ утга, арга замыг илэрхийлсэн КНХ-ын хөдөлгөөн дөнгөж эхэлж байна гэдгийг надад сануулж өгсөн.

Компаниуд үүнийг үйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлж болохыг суралцах гэж оролдож байгаа. Энэ чанарын хөдөлгөөн одоогоос 20, 30 жилийн өмнө гарч ирч байсан үеийн түвшинд байгааг би ажигласан. Компаниуд анх чанарын тухай сонсоод “Энэ чинь нээрээ хэрэгтэй санаачилга байна. Үүнийг дэмжие” гэсэн. Дараа нь чанарын ажилтантай болсон. Гэхдээ тэр нь хязгаарлагдмал байсан. Тэгээд оффистой болсон. Тэр нь нэг алхмаар урагшилсан ч бас л хол явж чадаагүй байв. Харин хүн бүр чанар гэдгийг ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэх хэрэгтэйг ухамсарласан үед л жинхэнэ утгаа олсон. Үүний тулд маш их цаг хугацаа орсон. КНХ яг үүнтэй адил. Арван жилийн өмнөх байдлыг харахад, ихэнх гүйцэтгэх захирал КНХ-ын ач холбогдлыг олж харахгүй байна гэж байв. Зарим нь харин стратегийн хувьд л маш чухал зүйл байна гэж хэлж байсан. Ихэнх ажилтан миний бодлоор үүнийг ойлгодоггүй бөгөөд хэрэгжилт ч маруухан. Цөөн хэдэн компани л КНХ-ыг бизнесийн асар том боломж гэж ойлгож, хэрэгжүүлж байна. Гэвч тэдгээрийн тоо одоо ч гэсэн цөөхөн. Олонх компани нийгмийн хариуцлагыг үл ойшоож болохгүйг ойлгож байна. Тэд үзэгч байхаа больж, энэхүү үйлст оролцох шаардлагатай тулгарч байгаа. Гэсэн хэдий ч ямар байдалтай оролцох вэ, компанид ашигтайгаар хэрхэн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх вэ гэдэгт одоо хүртэл суралцсаар байна. Хэрвээ компани үүнийг өрсөлдөх чадвараа болгож ашиглаж чадахүй бол компанид үүнээс өөр том ашиг гарахгүй. Хандив тэтгэлэг, буяны ажилд хүмүүс баярлалаа л гэж хэлэхээс компани, бизнесийг сайжруулахгүй. Нийгэмд ч гэсэн нөлөөлөл үзүүлж тус дэм болж чадахгүй.

Өнөөдөр КНХ нь үнэ цэнийг бий болгох, түүнийгээ бизнесийн загварт оруулж хэрэгжүүлэх, оролцогч талуудтай харилцаж бизнесийн үйл ажиллагаагаар дамжуулан шинэчлэл хийх зэргийг багтаасан цогц үйл ажиллагаа юм. ■

http://www.mongolianeconomy.mn

"Mongolian Economy" сэтгүүлийн нэг жилийн ойд

Тиймээ, бид Монголын Economist болох зорилготой

Д.Бэхбаяр

Цаг хугацаа хурдан юм аа. Яг жилийн өмнө сэтгүүлийнхээ анхны дугаарыг гаргачихаад баярлаж, бас уншигчдын зүгээс ямархуу хандлага ирэхийг сэтгэл догдлон хүлээж байсан сан. Хамгийн түрүүнд Сангийн яамны дэд сайд Ч.Ганхуяг утасдаж, Монголын эдийн засгийн чуулганаар сэтгүүл авах захиалга өгч билээ. Маргааш өглөө нь форум эхлэх байлаа. Бид маш их баярласан, сэтгүүл маань хүмүүст хүрчээ гэж. Удалгүй олон олон хүнээс урмын үг сонсож, улам ихийг хийж бүтээх зориг орсон. Тэр олон мэссэжийн гол утга нь Монголын эдийн засагт ийм сэтгүүл зүйн орон зай үгүйлэгдэж байсан юм, та нар зөв гарч ирлээ гэсэн байв.

Бид анхныхаа дугаараар ямар асуудлыг хөндөх, ямар дизайнтай байх, ямар лого, уриатай байхав гээд л нэг сар гаруйн хугацаанд их хөдөлмөрлөсөн. Үр дүнд нь бид 100 нүүр бүхий монгол, англи хэлээрх сэтгүүлийг хийсэн, чадсан, үнэлгээ авсан. Тухайлбал, будаг нь үнэртсэн шинэхэн дугаараа гаргасан өдрөөс л захиалга эхэлсэн юм. Хүмүүс ийм хурдан захиалдаг юм аа гэж бодож байж билээ. Манай офиссын утас байнга дуугарч, захиалга хийж байсан нь эдийн засгийн мэдээллийн хүлээлт их байсны дохио болсон юм. Мөн дэлхий Монголыг сонирхож буй энэ үед эдийн засгийн бодит мэдээллийг англи хэлээр хүргэж эхэлсэн нь цаг үеэ олсон явдал байв. Үүнийг манай улсад ажиллаж амьдарч буй гаднынхан сэтгүүлийг маань байнгын уншигч болсноос харж болно.

Ер нь манай сэтгүүлийн хамгийн гол зорилго, баримтлах зарчим улс төрөөс хараат бус байдал хүмүүст их таалагдсан. Хэн нэгэн улстөрч, ямар нэг намаас хол хөндий, бүр улс төр ч бичдэггүй сэтгүүл зүйг олон нийт хүлээж байжээ гэж бодоход хүргэсэн. Өнөө ч бид энэ зарчмаа баримталж явна, цаашдын маань ч гол зорилт, бусдаас ялгарах том давуу тал энэ байх болно. Бид хэн нэгэн хүний гар хөл болж, аялдан дагалдахыг хүсээгүй. Зүгээр л эдийн засаг, санхүү, бизнесийн мэдээ мэдээллийг бодитойгоор, энгийн үгээр, ойлгомжтойгоор иргэдэд хүргэж, тэдний эдийн засгийн боловсролд хувь нэмрээ оруулахыг хичээж ажиллах зорилтыг сэтгүүл байгуулахдаа дэвшүүлсэн. Энэхүү зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө л ажиллаж байна. Эдийн засаг хурдацтай хөгжиж байгаа энэ үед иргэд эдийн засгийн мэдлэг, мэдээлэлтэй байх нь чухал гэж үзсэн.Тиймээс эдийн засгийн сэтгүүлчдийн баг бүрдүүлж энэ зорилгынхоо төлөө ажиллаж ирсэн нь тодорхой амжилтыг дагуулсан. Энэ амжилтад хүрэхэд бидэнд олон хүн чин сэтгэлээсээ тусалж дэмжиж, санаа бодлоо хэлж байсан юм. Монголд эдийн засгийн ийм нэг сэтгүүл байгаасай хэмээн хүсэж,цаг заваа харамгүй хайрлан зөвлөж байсан бүх хүнд баярлалаа.

Бид эхлээд гурвуулаа байсан бол өнөөдөр 18-уулаа болжээ. Гурвуулхнаа 100 нүүр бүхий сэтгүүлийг хийж байсан юм. И.Отгонжаргал, Д.Мөнхчимэг бид гурав. Гэхдээ арын албанд зүтгэж байсан хүмүүс бий. Хамгийн гол нь маш чанартай сайн нийтлэл бичиж, сэтгүүлийг хүнд хүргэх, таниулах, үйлдвэрлэх ажил эхлээд бидний нуруун дээр байлаа. Их хичээсэн, ажилласан. Сэтгэл зүрхээрээ нэгдэн ажиллаж байсан Д.Мөнхчимэгтээ хамгаас илүү их баярлалаа гэж хэлэх ёстой. Сэтгүүлийн үйл ажиллагаа жигдрэх тусам бүл нэмсээр эдүгээ орон тооны бус ажилтнуудтайгаа нийлээд 20-иод хүн ажиллаж байна. Зөв сэтгэлтэй, ажилч хичээнгүй, мэдлэг боловсрол өндөртэй залуусын баг бүрдсэнд олзуурхдагаа нуушгүй нь. Тэд мөн сэтгүүлийн нэг нас хүрэх хүртэлх түүхийг бичилцэж яваа хүмүүс, цаашдаа ч олон олон ойн түүхийг бүтээх залуус. Амжилтын үндэс хүн хүч гэдэг. Бидний өнөөдрийг хүртэл бүтээсэн, олсон бяцхан амжилтын маань цөм нь хамт олон маань л юм.

Манай хамт олон

http://www.mongolianeconomy.mn

Өнөөдөрсэтгүүлдэргэдээwww.mongolianeconomy.mn вэб сайт, “Economy” ТВ студи болоод “Ногоон эдийн засгийн өсөлт” ТББ-тай боллоо. Нэг жилийн хугацаанд маш их хөдөлмөрлөснийг энэ бүхэн харуулах биз ээ. Эдийн засаг, бизнесийн мэдээ мэдээллийг цогцоор нь хүргэхийг ийн хичээж ажиллаж байна. Цаг наргүй, амралтгүй ажилласны дүнд амжилт ирдгийг ойлгож мэдэрлээ. Цаашид эдгээр ажлаа улам өргөжүүлж, сэтгүүлийнхээ утга агуулгыг улам төгөлдөржүүлэн, өнгө дизайнд анхаарч, олон хүний мэддэг, унших дуртай сэтгүүл болгохын төлөө явна.

Цаг хугацаагаар хэмжигддэг энэ нийгэмд эдийн засгийн мэдээллийг олон нийтэд илүү хурдтай ойртуулах үүднээс энэ оны нэгдүгээр сараас сэтгүүл 14 хоног тутамд гарч эхэлсэн. Ер нь бидний анхны төлөвлөгөөгөөр 14 хоног тутмын эдийн засгийн сэтгүүл гаргах байсан бөгөөд 2011 онд үйл ажиллагаагаа жигдрүүлэх, сэтгүүлээ хүмүүст таниулахын тулд сар тутам гаргаж байсан юм. Нэг зүйлд их баярласан. Сар тутам гаргаж байсан сэтгүүлээ 14 хоногийнх болгохоор захиалагчид маань хэрхэн хүлээж авах бол гэж жаахан эмээж байлаа. Гэтэл бүх захиалагч сэтгүүлийг маань үргэлжлүүлэн захиалсанд үнэхээрийн их баярласан. Тиймээс тэднийхээ итгэлийг алдахгүйн тулд улам илүү хөдөлмөрлөж, маш сайн чанартай сэтгүүл гаргах юм шүү гэсэн бодол, зорилго тээн ажиллаж байна, манай хамт олон.

Олон хүн манай сэтгүүлийг The economist сэтгүүлтэй адилхан байна, Монголын Economist болох юм уу гэж ярьж, асуудаг. Бид баярлаж байна. Бидний бүтээлийг дэлхийд нэртэй том сэтгүүлтэй зүйрлэж байгаад. Тиймээ, бид Монголын Economist болох зорилготой. Сэтгүүлийн өнгө төрх, загвар дизайны хувьд тус сэтгүүлээс санаа авсан, дуурайсан ч зүйл бий. Яагаад болохгүй гэж. Гэхдээ бид өөрийн гэсэн имиж, нийтлэлийн бодлого бүхий Монголын Economist-ийг бий болгохын төлөө явж байгаа.

Ингээд сэтгүүлийнхээ бүх уншигч, захиалагч болон биднийг дэмжиж ирсэн хүмүүст сэтгүүлийнхээ нэг жилийн ойн баярын мэндийг хүргэхийн зэрэгцээ та бүхний хүсэл тэмүүлэл, туслалцаа дэмжлэгээр бид жигүүрлэн өмнөө тавьсан амжилт өөд мацаж явна гэдгээ хэлье. Маш их баярлалаа, та бүхэнд, мөн хамт олондоо баярын мэнд хүргэж, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. ■

Сэтгэл нэг л их догдлонгуй

И.Отгонжаргал

2011.02.24. Сэтгэл нэг л их догдлоостой. Эл өдрийн үдээс хойш Монголын хэвлэл мэдээллийн салбарт тэр дундаа сэтгүүлийн зах зээлд цоо шинээр мөр гаргах “Mongolian Economy” сэтгүүлийг үйлдвэрээс хүлээн авах учраас тэр. Яарч догдолсон болоод ч тэр үү, цаг нэг л явж өгдөггүй. “Ажил дээр хүн байгаа юм болов уу, ямар ч гэсэн Мөнхчимэг рүү утас цохиод орхиё.

-Сайхан амарсан уу, Мөнхчимэг ээ чи хаана байна вэ?

-Аан, би гадуур явж байна. Удахгүй ажил дээр очно. Сэтгүүл хэзээ үйлдвэрээс ирнэ гэсэн бэ?

-15.00 цагийн үед ирнэ гэсэн. Би ажил руу явахаар гэрээсээ гарч байна. Сэтгүүлээ харна гэхээр сэтгэл догдлоод байна шүү.

-Харин тийм ээ, за удахгүй ажил дээр уулзъя.

Ийн хамгийн дотнын, хамгийн хайртай хамтран зүтгэгчтэйгээ яриад ч догдолсон сэтгэл тайвширдаггүй ээ. Ерөөсөө сэтгүүлээ гоё угтах хэрэгтэй юм байна. Үс зүс, хумс хуруугаа янзлуулахаар гоо сайхны газарт очлоо. Яаран байж гоёж аваад, нийслэлийн Их тойрууд байрлах хэдийгээр хуучны барилга ч тэрүүхэн тэндээ вант улсыг илтгэх мэт “Монреимпэкс “ компанийн хүрэн байшингийн хоёрдугаар давхрын жижигхэн офестоо ирлээ. Бэхээ маань хэдийнэ ирчихсэн, ширээгээ тойрон алхаж, мэндчилэв. Түүний сэтгэл мөн л ихэд догдолсон нь илт. Мөнхчимэг, Энхээ хоёр маань баярын ширээ засахаар дэлгүүр явсан гэнэ. Бэхээ маань ажлын өрөөний хананд тогтоосон жижигхэн цагаан самбар дээр “Маш их ажиллаж, анхны дугааpаа амжилттай гаргаж буй Отгоо, Мөнхчимэг, Энхээ, Баяраа нартаа баярлалаа. Бид хийж чадсан шүү, баяр хүргэе. 2011.02.24” хэмээн цэнхэр тодруулагчаар тод, том гэгч нь бичиж амжсан байлаа.

“Улаанбаатар принт”-ээс “Танай сэтгүүлийг ачаад гарсан шүү” хэмээн утасдаад төд удалгүй сэтгүүл гадаа ирж байгаа дуулдав. Хамгийн түрүүний хайрцагтай сэтгүүл дээр овоорч, онгойлгохыг тэсэн ядан хүлээв. Бүх хүн чив чимээгүй. Зөвхөн будаг нь ханхалсан сэтгүүлийн хуудасны чимээ сонстоно. Аниргүй танхимыг Мөнхчимэгийн “...өө..” гэх дуу эвдэж, биднийг сэртхийлгэв. Тэрбээр эхний алдааг олж харжээ. Графикуудын тайлбарууд янз янзын шрифтээр явчихаж, би уг нь Баяраа ахад их хэлсэн дээ гэв. Тэрбээр ширээн дээрээ очоод суучихсан нухацтай гэгч нь үзэж байна. Дахиад л “ ...өө...” гэх нь сонстлоо. Бас яасан бэ? “Бизнесийн завсарлага” дээр орсон номны зарим хэсгийн найруулга нь жаахан эвгүй болчихжээ” гээд санаа алдав. Дахиад алдаа гарах вий дээ гэж болгоомжилсон миний бие“ ...Өө зүгээр зүгээр энэ зэргийн юм байлгүй дээ. Өнгө үзэмж сайтай маш сайн дугаар гарчээ” гэж сэтгэл санаагаар унасан түүнийг зоригжууллаа.

Бэхээгийн өрөөнд ороод ирсэн чинь түүний царай ялимгүй барайжээ. Яасан бэ хө?

-Сэтгүүлийнхээ хавтсыг хоёулаа гялгараар л хийлгэдэг байж. Матт цаас арай л онцгүй юм аа сурах бичиг шиг гэж урвайв. Хэдүүлээ сэтгүүлийн тавиур дээр байсан дотоод, гадаадын сэтгүүлүүдийг шүүрэн авч харьцуулж үзлээ. Нээрээ ч ихэнх нь гялгар хавтастай байв. Дахин харахаар гялгаргүй хавтастай манай сэтгүүл ч төв өнгөтэй, ажил хэрэгч харагдах шиг. Хэсэг үзэцгээж, за одоо хаашдаа өнгөрсөн. Дараагийнхыгаа л гялгараар хэвлүүлж үзье гэж шийдлээ.

“Батбайгаль”-ийн цав цагаахан аарцтай бялуу, “Шинэ сүү”, зөөлөн чихрийн цуглуулгаар ширээ засснаыг ч анзаараагүй байжээ, сэтгүүлээ үзэж, сонирхоод. Аяганууд ад ч сүү хийжээ. Биднийг сэтгүүлээ сонжиж, янз бүр болж байх хооронд нягтлан Энхээ маань энэ бүгдийг амжуулсан байв.

Бэхбаяр эрхлэгч маань “Жижиг сажиг алдаг эс тооцвол сэтгүүл маань бидний санаж бодож, төсөөлж байсан хэмжээнд гоё гараад иржээ. Цаашдын сэтгүүлийн маань зам мөр сүү шиг цагаахан байж, бидний ажил ▸▸

http://www.mongolianeconomy.mn

улам өргөжин хөгжихийн төлөө” хэмээн сүүн ерөөл өргөв. Ингээд бялуугаа хувааж, бөөн инээдэм наргиан, дуу шуу болцгоолоо. Сэтгүүлээ өлгийдөж авсан бидний баяр хөөр, анхны сэтгэгдэл ийн үл мартагдах түүх болон үлджээ.

Сэтгүүлийнхээ анхны дугаарыг гаргах үеэр Монголын эдийн засгийн форум болно гэдгийг ч тооцоогүй байсан юм байна лээ, дараа нь бодоход. Анхны дугаараасаа л маш сайн эдийн засгийн сэтгүүл гэсэн нэр хүндийг олж авах ёстой гэсэн хатуу зорилгыг өмнөө тавьсан байсан юм. Тиймээс анхны дугаарт оруулах материалын төлөвлөгөөг маш сайн гаргах нь чухал гээд л суусан. Эдийн засгийн чиглэлээр сонин хэвлэлд бичиж нийтлэх ажилд доод тал нь хоёр жил гаруй, дээд тал нь арван жил ажилласан туршлага бидэнд байсан учраас сэтгүүлийн бодлогоо тодорхойлох болон анхны дугаартаа юу юу оруулахаа тодорхой болгох нь нэг их хүндрэлтэй зүйл биш байв.

Өмнөх жилийн Монголын эдийн засгийн чуулганы төлөөлөгчдөд шинэхэн сэтгүүлээр “сурпүриз” барих аз хийгээд боломж бидэнд тохиосон. Тэгвэл сэтгүүлийнхээ нэг жилийн ойгоороо тус чуулганы мэдээллийн оролцож, хурлын төлөөлөгчдийн цүнхэнд нь манай сэтгүүлийг хийсэнд баяртай байна. Түрүү жил Төрийн ордны Их танхимын баруун, зүүн хаалган дээр бид сэтгүүлээ оруулж, тараах санаатай дөхүүлж байтал завсарлаж, гарч ирсэн хүмүүс хүүе хаая гэхийн зууртгүй шүүрээд авцгаасан. Сэтгүүлээ яаж тараана аа, хүмүүсийг цайлж байх үеэр суудал дээр нь тавьсан нь дээр байх гэж хэлэлцэж ярилцаж байсан боловч тэгж ажил удах шаардлагагүй байсан юм. Гэхдээ л хурлын үеэр уулзаж танилцсан, таньдаг мэддэг хүмүүстээ сэтгүүлээ зөөж гүйсээр гар, хөл өвчин орсныг орой гэртээ хариад мэдэрч билээ. Бүтэн хоёр өдөржингөө Ордонд гүйсэн дээ. Магтаал сайшаалын үг ч цөөнгүй сонсож эхэлсэн. Манай сэтгүүлтэй танилцсан хүмүүсийн олонх нь “Танайх Монголын эдийн засгийн форумтай холбоотой юу” гэж аминчлан асуудаг. Одоо ч энэ асуултыг тавих хүн байдаг л юм. Олон улсын байгууллагын болон зарим гадаад хүн “Ноднингийн эдийн засгийн форумын үеэр танай сэтгүүлийг авч үзэж байсан. Түүнээс хойш байнга уншиж байгаа. Монголын эдийн засгийн талаар цэгцтэй, үнэн зөв, цогц мэдээлэл өгдөг сайн сэтгүүл байгаа юм” гэж магтах нь ч бий.

Мөн бидний Монголд эдийн засгийн мэргэжлийн, улс төрөөс хараат бус цэвэр сэтгүүл зүйг хөгжүүлэх үйлс, зорилгыг дэмждэг хувь хүн, дотоод, гадаадын байгууллага цөөнгүй байдагт баярлаж явдгаа нэг насны ойн баярын үеэрээ тэмдэглэхэд таатай байна.

Манай хамт олон мэргэжлийн гэдэг нэр хүндээ байнга өндөрт өргөхийг хичээн, алхам тутамдаа анхаарч ажилладаг. Монгол, англи хэл дээр, 14 хоног тутмын сэтгүүл гаргаж, цахим хуудас ажиллуулах хүнд ажлыг хамтдаа үүрэлцэж яваа гадаад хэлний редактор Тэрэнс Эдвардс болон сэтгүүлчийн хүнд хөдөлмөрт гялалзтал суралцаж яваа шинэ залуу сэтгүүлчдэдээ болон нийт хамт олондоо нэг жилийн ойн баярын мэнд хүргэе. ■

Уншигчийн булан

Та манай сэтгүүлийн талаарх сэтгэгдлээсээ хуваалцана уу?

Бидэнд судалгаа, шинжилгээтэй мэдээлэл хамгаас чухал

С. Оюун /УИХ-ын гишүүн/:

“Mongolian Economy” сэтгүүлийг нэлээн сайн уншдаг. Шийдвэр гаргагч бид нарт судалгаа шинжилгээ маш тодорхой, үнэн бодит хэрэгтэй мэдээллийг хүргэдэг юм шиг санагддаг. Бид заримдаа нэг их юм мэддэг юм шиг цээжнийхээ бангаар ярьдаг ч цаанаа мэдлэг мэдээлэл муутайгаас буруу шийдвэр гаргах тохиолдол байдаг. Энэ нь эргээд ард иргэдийн амьдралыг, эдийн засгаа, нийгмээ хөлдөө чирэхэд хүргэдэг.

Тийм болохоор цаашдаа зөв замаар явж, эх орноо өнгөтэй, өөдтэй байлгая гэх юм бол судалгаа, шинжилгээ, үнэн бодит мэдээлэл төрийн эрх барьж буй хүмүүст ихээхэн хэрэгтэй байна. Энэ зайг нөхөж, эдийн засгийн мэргэшсэн сэтгүүл болон гарч ирсан нь тун зүйтэй юм.

Юун түрүүнд манай улсын эдийн засагт ойрын хэдэн жилдээ уул уурхай ихээхэн нөлөөтэй байх тул энэ салбарын хөгжил, онцлог, үнийн хэлбэлзлийн талаар болон хувьцаа, хөрөнгийн зах зээлтэй холбоотой мэдээ, мэдээлэл хамгийн ихээр шаардлагатай байна. Манай иргэд Тавантолгойн ордоос хувьцаа эзэмших гэж байна. Тиймээс хувьцааг хэрхэн авах, хувьцаа эзэмшсэнээр ирээдүйд ямар ашигтай вэ гэдгийг цаашдаа ойлгуулж өгөх нь чухал. Энэ тал дээр түлхүү анхааран ажиллаж, ард иргэдийнхээ эдийн засгийн мэдлэгийг нэмэгдүүлж, эрх баригчдад ч шаардлагатай мэдээллийг хүргэж байна гэдэгт найдаж байна. Та бүхэнд илүү их амжилтыг хүсэн ерөөе.

Улам илүү чанартай мэдээллийг хүргээрэй

Ч. Ганхуяг /Сангийн дэд сайд/:

“Mongolian Economy” сэтгүүлийг монголчууд бид гар дээрээ авч, уншигч нь болоод нэг жил болж байна. Асуудлыг хоёр талаас нь ул суурьтай судалж, тодорхой дүгнэлт, шинжилгээ хийж, эдийн засгийн өнөөгийн шилжилтийн үед ард иргэдэд эдийн засгийн мэдээллийг түгээхээр гарч ирсэнд нь туйлын баяртай байдаг. Тус сэтгүүл хүмүүст шаардлагатай мэдээллийг цаг үед нь нийцүүлэн өгч, төр, хувийн хэвшлийн гүүр нь болж, бизнесээ өргөжүүлэх боломжийг ч өгч байгаа билээ.

“Mongolian Economy” сэтгүүл нь Эдийн засгийн форумтай хамтран ажилладаг, ахан дүүсийн харилцаатай байгууллагууд гэж хэлэхэд хилсдэхгүй байх. Ер нь Монголын цаашдын эдийн засгийн өндөр өсөлт ард иргэдийн амьдралд илүү наалдаж, хүрэхэд танай сэтгүүлээр гарч буй нийтлэл, материал ихээхэн үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэж, хүсэн хүсэж, хүлээж байгаа. Эдийн засгийн өсөлт эзэн өөрөө хичээсэн тохиолдолд тухайн ▸▸

http://www.mongolianeconomy.mn

Сангийн дэд сайд Ч. Ганхуяг

С. Оюун /УИХ-ын гишүүн/:

МҮХАҮТ-ын дарга С. Дэмбэрэл

МҮЭХ-ны тэргүүн С.Ганбаатар

УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгийн хорооны дарга Д.Зоригт

ГОУХАН-ийн Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн санаачилга хөтөлбөрийн захирал Др.Штефан Хансельманн

өрх гэр, аймаг, улсын баялаг хөгжил нь болж нөлөөлж чадна. Тиймээс иргэн бүхэн дор бүрнээ хичээж, боловсрол, хувь хүнийхээ хөгжилд анхаарч, уйгагүй хөдөлмөрлөж, төсвөө зөв удирдан, өөрт ногдож буй үүрэг даалгавраа биелүүлж байж хамтдаа хөгжиж хамгийн баян улсын тоонд орох боломж сорилт бидний өмнө байна. Хүн бүхэн үүнийг ухамсарлаж, ойлгоход "Mongolian Economy" сэтгүүл тусалж, хувь нэмрээ оруулж буйд таатай байдаг. Цаашдаа ч илүү их анхаарч, мэдээ материалаа чанаржуулж ажиллаарай. Дээр нь аль болох бодит мэдээ мэдээллийг холбогдох хүмүүсээс авч, дамжуулж өгөх хэрэгтэй. Жишээ нь ядуурлын түвшинг гаргахдаа янз бүрийн зөрөөтэй тоог хэлдэг. Энэ бол маш буруу хандлага. Тиймээс судалгаатай, үнэн бодит цаг үеийн мэдээллийг хүргээрэй. Та бүхний цаашдын ажилд амжилт хүсье.

Үргэлж гарцыг тодруулж байдагт баярлалаа

МҮХАҮТ-ын дарга С. Дэмбэрэл:

Манай улсын эдийн засгийн хөгжил эгзэгтэй гараан дээр байна. Цаашдаа эдийн засаг зөв хөгжлөөр явах уу, үгүй юу гэдэг дээр тал ард иргэд, бодлого боловсруулагчдад ихээхэн зөв санаа, мэдээлэл өгөх хэрэгцээ шаардлага, орон зайг "Mongolian Economy" сэтгүүл нэлээд сайн нөхөж өгч чадаж байгаа.

Монголын эдийн засгийн бодлогын асуудал, ногоон эдийн засаг, нөөц дээр суурилсан эдийн засаг ард иргэддээ хэр өгөөжтэй хүрч байгаа талаар тэдэнд зөв ойлголт төрүүлж өгөх ёстой. Үүнийг танай сэтгүүл аль болох олон талын, үнэн бодит байр суурийг оролцуулан олон нийтэд мэдээлж байгаа нь тун зөв зүйтэй. Эдийн засаг, ДНБ өндөр өсөлт нь тогтвортой, тэнцвэртэй, оролцоотой байж чадаж байгаа эсэхэд танай сэтгүүл гол ноён нуруугаа хандуулж, зүтгэж байдагт тун баяртай байдаг.

Нөгөө талаас эдийн засаг гэхлээр хүмүүс нэг их тоо, хэцүү юм шиг санадаг. Төрийн зах зээлд оролцох оролцоо, эдийн засгийн өнөөгийн төлөв, бидний амьдралд шууд нөлөөлж буй үнийн өсөлтийн гол шалтгаан, үр дагавар, гарах арга замыг иргэдэд үнэн бодитой, судалгаатай хүргэж байх нь танай хамт олны үүрэг юм. Дээр нь өнөөгийн манай эдийн засгийн механизм өөрөө эрүүл байна уу, үгүй бол юун дээр анхаарах нь зүйтэй вэ гэдэг гарцыг тодруулж, иргэд, олон нийт, эрх баригчдад үнэн бодит мэдээллийг хүргэж байдагт баярлалаа.

Эдийн засгийн ухаан бол амьдралын ухаан

МҮЭХ-ны тэргүүн С.Ганбаатар:

-Эдийн засгийн ухаан бол нэг ёсондоо амьдралын ухаан юм. Манай улсын эдийн засаг их эгзэгтэй байгаа энэ үед "Mongolian economy" сэтгүүл тун цагаа олж гарч ирсэн. Иргэдэд эдийн засгийн мэдээ, мэдээллийг ойлгомжтой, энгийнээр, олон эх сурвалжаас авч хүргэж чаддагт нь сэтгүүлийн гол давуу тал нь оршдог гэж боддог. Мөн улстөр, эдийн засаг, байгаль орчин гэх мэт салбар салбарын тэргүүний хүмүүс хамгийн сүүлийн үед уншиж буй номоо тус сэтгүүлээр дамжуулж хоорондоо болон хүмүүстэй хуваалцдаг нь зүйтэй юм. Эдийн засгийг хүн бүр уншиж, судлах ёстой. Тэгж байж л ядаж татварт төлсөн мөнгөө хэр үр дүнтэй зарцуулж байгааг хянахаас эхлээд ая тухтай, төрийн үйлчилгээг бүрэн авч амьдрах эрхээ өөрсдөө эдлэх юм. Тухайн нийгэмд эдийн засгийн томоохон шийдэл гарах гэж байхад урдаас тосон мэдээллээ гаргаж, иргэдийн оролцоо, санал бодлыг дамжуулах нь танай сэтгүүлийн үндсэн үүрэг гэж ойлгож байна. Ер нь энэ мэт эдийн засгийн энгийн ухагдахуунуудыг иргэдэд ойлгомжгүй болгон, төөрөгдүүлэн өм цом ашиг хийж байгаа хүмүүсийг хулгай хийх, завших боломжийг олгохгүй байх ёстой. Үүнд л танай сэтгүүлийн бодлогын нэг хэсэг чиглэгдэн иргэдийг соён гэгээрүүлэхэд "Mongolian Economy" сэтгүүл их тус болно гэж найдаж байна.

Байнгын уншигч болж нэг жилээр захиалж байгаа

Д.Зоригт /УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгийн хорооны дарга/:

-"Mongolian Economy" сэтгүүлийн хамт олон болон байнгын хүлээн авч, уншин оюуны цангаагаа тайлж байдаг

http://www.mongolianeconomy.mn

уншигчдад нь юун түрүүн нэг жилийн ойн баярын мэндийг хүргэе. Манай сэтгүүл зүйн салбарт олон сэтгүүл гарч ирж байгаагийн дотор эдийн засаг, бизнес, хөрөнгийн зах зээлийн талаар нэлээд сайн бичиж байгаа мэргэжлийн сэтгүүл “Mongolian Economy” гэж би хувьдаа дүгнэдэг. Хэд хэдэн дугаарыг уншин, танилцаж байсан. Мэдээлэл нь олон талын эх сурвалжтай, товч тодорхой гэдэг үүднээсээ их таалагдсан учраас би бүтэн жилээр нь захиалан авч байгаадаа тун баяртай байна.

Ер нь Монгол Улсын эдийн засаг эрчимтэй хөгжлийн гараан дээр ирж, бизнесийн цар хүрээ, өрсөлдөөн, эдийн засгийн их өсөлтийн өвөрмөц үед цагаа олон гарч ирсэн учраас иргэд, олон нийт, улс төрчдөд шинэлэг мэдээ, мэдээллийг хүргэх байх гэж найдаж байгаа.

Уул уурхайд суурилсан эдийн засгийг хөгжүүлэхээсээ түлхүү нэмүү өртөг шингээсэн бусад тогтвортой ажлын байр бий болгох салбарт анхаарч, хийх зүйл их байна. Жишээ нь, өргөн уудам нутаг дэвсгэр дээр амьдардаг бидний хувьд хөдөө, орон нутгийн иргэдэд жижиг, дунд бизнес эрхлэх боломж бололцоо их байдаг.

Тиймээс иргэдэд амьдрал ахуйгаа залгуулах, жижиг, дунд, бичил бизнесийг эрхлэх боломж бололцоог түлхүү харж, олон нийтэд таниулах нь зүйтэй юм. Дээр нь тэдний санал, хүсэлтийг эрх баригчдын чихэнд хүргэж байгаасай гэж хүсэж байна.

Сэтгүүлийн гол нийтлэл англи хэл дээр гардаг нь таалагддаг

Др.Штефан Хансельманн /ГОУХАН-ийн Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн санаачилга хөтөлбөрийн захирал/:

-“Mongolian Economy” сэтгүүлийн хамт олонд төрсөн өдрийн мэнд хүргэе! Энэ жил та бүхний ажил үйлс улиран өнгөрсөн нэг жил адил ер бусын амжилт дүүрэн байх болно гэж найдаж байна. Та бүхний хувьд өнгөрсөн нэг жилийн хугацаанд маш сайн нийтлэлүүдийг агуулсан гайхалтай дугааруудыг өргөн барьсан амжилт дүүрэн жил байсан гэж би хувьдаа бодож байна. “Mongolian Economy” сэтгүүл зөвхөн нэг асуудлыг хөөх бус маш олон асуудлыг олон талаас нь цаг хугацааны өргөн цар хүрээнд хөнддөг учир би танай сэтгүүлийг талархан хүлээж авдаг. Гадны хүний нүдээр харахад энэ сэтгүүл бол мэдээллийн найдвартай олон талт эх сурвалж болж чаддагаас гадна тэнцвэртэй мэдээлэл хүргэдгээрээ онцлог гэж бодож байна. Танай сэтгүүлийн гүйцэтгэх үүргийг нэг талаас зуучлагч, нөгөө талаас чухал асуудлуудыг ул суурьтай далайцтай гаргаж ирдгээрээ түлхэгч хүчин болж байдаг гэж үздэг. Мөн сэтгүүлийн гол нийтлэл англи хэл дээр гардаг нь таалагддаг. Цаашид монгол улсын хурдацтай хөгжлийн үйл явц “Mongolian Economy” сэтгүүлийн сэтгүүлчдийг улам ч завгүй болгох байх аа. Танай хамт олонд 2012 онд улам их амжилт бүтээл гаргахыг хүсэн ерөөе! ■

Дэлхийн түүх

Тэд хөрөнгө оруулалтыг хэрхэн “чулуу” болгож чадсан бэ

С.Жавхлан

Канад, АНУ, Япон, Австрали, Шинэ Зеланд болон Европын зарим орон... Эдгээр улсыг сонсоод таны бодолд юу бууж байна вэ? Дэлхийн эрүүл мэндийн байгууллага эдгээр орныг амьдрах стандартын хувьд хамгийн шилдэг хэмээн тодорхойлдог. Тус улсын хүн ам хүний амьдрах ёстой насыг бүрэн наслаж /70-80 нас/, өндөр цалин авч /дунджаар жилд 40,000 ам.доллар/, хангалттай сайн идэж /өдөрт дунджаар 2800 каллори/, өндөр боловсрол эзэмшиж /бараг 100 хувь уншиж, бичиж чадна/ байна. Дээрх улс орны хүн амын 80-90 хувь нь хотод эсвэл хотожсон бүсэд амьдарч байгаа бөгөөд хүн амын ердөө гуравхан хувь нь газар тариалангаар амьдралаа залгуулж байна. “Баян орон”-ы хүн ам бараг бүхэлдээ аюулгүй хоол хүнс хэрэглэж, цэвэр ус уун, технологи дэвшил, эрүүл мэндийн шинэ үйлчилгээг мэдэрч байна.

Харин үүний хажуугаар бөмбөрцгийн бөөрөнд “азгүй” хүн ам ч ▸▸

http://www.mongolianeconomy.mn

бий. Жилд ердөө 450 ам.доллар буюу өдрийн 1.25 ам.долларын орлогоор амьдарч, дунджаар 46 наслах боловч бохир ундны ус, хоол хүнсний дутагдал зэргээс шалтгаалан дээрхээс ч бага насалдаг байна. Ихэвчлэн Африк тивийн зарим орны хүмүүс иймэрхүү байдалтай шар бор өдрийг өнгөрөөдөг. Нийт төрсөн 1000 хүүхдээс 173 нь буюу зургааны нэг нь таван нас хүрэхгүй хорвоогийн мөнх бусыг үзэж байна.

Дээрх хоёр төрлийн орнуудаас гадна дэлхийд өөр нэгэн төрлийн орон байдаг нь бидний нэрлэж заншсанаар хөгжиж буй орнууд бөгөөд эдгээр орон хэдхэн жилийн өмнө дээр дурдсанчлан “нэн ядуу” орнууд байсан билээ. Гэвч сүүлийн 50 жилд эдгээр орны үсрэнгүй хөгжиж чадсан. Ийм орны тоонд “Азийн бар” орнууд болох Өмнөд Солонгос, Хонконг, Тайвань, Сингапур орно.

Дэлхийн хоёрдугаар дайн, аймшигт иргэний дайн /1950-1953 он/-ы дараа Өмнөд Солонгосын ирээдүй үнэхээр бүрхэг байсан. Олонх иргэн нь гэр оронгүй хоцорч, тариан талбай нь бүхэлдээ сүйрсэн байсан. Энэ үед магадгүй эдийн засагчид тус улсыг нэн ядуугийн байдлаар XX зууныг үднэ хэмээн харж байсан байх. Гэвч өнөөдөр тус орон үсрэнгүй хөгжиж, эдийн засгийн эргэлт нь их наяд долларааp яригдаж байна. Ард түмний багагүй хувь нь Англи, Германы иргэд шиг хангалуун амьдарч байна. Техник технологи, тухайлбал интернэтийн хэрэглээгээрээ дэлхийд тэргүүлж, дотоодын үйлдвэрлэгчид болох Samsung, LG, Kia зэрэг компани нь дэлхийд өрсөлдөж байна. Үүний нэгэн адил Тайвань, Хонконг, Сингапурт ч мөн адил ард түмэн нь хангалуун сайхан амьдарч буй. Газрын хэвлийн баялаг багатай, хүн ам ихтэй эдгээр орон хэрхэн энэхүү хөгжилд хүрч чадав?

Улс төрийн бодлого, тааламжит газар зүй

Хэдийгээр XX зууны хоёрдугаар хагасыг Өмнөд Солонгос, Тайвань хоёр ядуу зүдүү байдалтай угтсан ч аль алинд нь газар нутгийн хувьд барууны орнууд шиг баян тансаг болох тааламжтай нөхцөл бүрдсэн байсан. Гэвч хоёр оронд үүссэн иргэний дайны улмаас дэд бүтэц нь сүйдэж, байгалийн баялгаа баран, туйлдсан юм.

Харин Солонгосын дайны дараахан ядуу орнуудын дунд нэлээд газар авч байсан коммунизмын нөлөөнд Өмнөд Солонгосыг автуулахгүйн тулд АНУ нэлээд анхаарч эхэлжээ. Тэр үеэс эхлэн АНУ Өмнөд Солонгосыг эдийн засгийн хувьд ихээхэн дэмжих бодлого явуулсан байна. Энэхүү бодлогын хүрээнд Өмнөд Солонгосын нийт экспортын 70 хувийг америкчууд “тэтгэж” эхэлжээ. Өөрөөр хэлбэл, Өмнөд Солонгос өөрсдийн бараа бүтээгдэхүүн, тухайлбал будаагаа дэлхийн зах зээлд харьцангуй бага зардлаар борлуулах боломжтой болсон бөгөөд үүнээс гарсан зардлыг АНУ-ын Засгийн газар нуруун дээрээ авч байжээ. Ингэснээр бусад шинээр үйлдвэржиж, хөгжиж буй эдийн засагтай орнууд болох Египт, Эквадор зэрэг орноос илүү давуу талтай болжээ. Энэхүү давуу тал нь БНСУ-д газар тариалангийн бараа бүтээгдэхүүнээрээ ердөө долоохон жилийн дотор /1953-1960 онд/ дэлхийн голлох улсуудын нэг болох боломжийг олгосон байдаг. Мэдээж зөвхөн эдийн засгийн хөгжлөөр улс орон хөгжинө гэхэд хэцүү бөгөөд үүнийг ч тус улсын Засгийн газар мэдэж байсан. Иймдээ ч эдийн засгийн сайн зөв бодлогоос гадна ард түмнийхээ боловсролд ихээхэн анхаарал хандуулж, дэд бүтцээ ихээхэн сайжруулсан байна. Гэвч энэ бүгдээс гадна Өмнөд Солонгосын хамгийн том давуу тал нь ган гачиггүй, далайд гарцтай газар нутгийн байршил байсан бөгөөд эдийн засаг нь уул уурхайд суурилаагүйд оршино.

Өнөөдөр тус улс дэлхийн хамгийн боловсролтой орнуудын нэг бөгөөд технологийн ертөнцөд толгой цохисон орон болж чадсан билээ.

Баялгийг баялаг болгосон нь

Хятадын хөрөнгөтнүүд /Гоминдан/ болон Хятадын Коммунист намын дунд 1927 онд гарсан дайн нь 1950 он хүртэл үргэлжилсэн бөгөөд дайны үр дүнд Коммунист нам их газрын Хятадыг захиргаандаа авч, гоминдануудТайванийн жижиг арал руу шахагдсан. Тэд тэнд өөрсдийн гэсэн зах зээлийн эдийн засгийг нэвтрүүлсэн билээ. Нэн ядуу орны статусаас эхэлсэн Тайвань орон өнөөдөр амьдралын стандартын хувьд дэлхийн баян орнуудын хэмжээнд очиж, “Азийн барууд”-ын нэг болсон. Тайваньчууд Японы колончлогчдын барьж байгуулсан дэд бүтэц дээр хөгжлийнхөө гарааг эхэлсэн бөгөөд энэ нь маш том давуу тал болсон. Газар тариалан нэлээд хөгжсөн байсан бөгөөд Хүйтэн дайны үед АНУ хөрөнгөтний нийгмийг дэмжих зорилгоор 1951-1965 оны хооронд нийт дөрвөн тэрбум ам.долларын тусламжийг Тайванийн эдийн засагт оруулжээ. Тэрхүү мөнгийг тайваньчууд газар тариалангаа зориулж байсан бөгөөд 1960 оны байдлаар нэг га газарт дунджаар гурван тонн будаа тариалж байдаг.

1960-аад оноос эхлэн Засгийн эрхийг барьж байсан хүчнээс импорт болон экспортын татварыг бууруулах шийдвэр гаргасан. Өндөр хөгжсөн баян орнууд энэхүү хямд зах зээлийг ашиглан өртөг багатай үйлдвэр байгуулахаар хошуурч эхэлсэн гэдэг. Гадаадын хөрөнгө оруулалтын энэ урсгал нь Засгийн газарт их хэмжээний хөрөнгийг төвлөрүүлсэн бөгөөд тэрхүү хөрөнгөө Тайвань “10 том барилгын төсөл”-д зарцуулжээ. Уг төслийн хүрээнд хурдны зам, далайн боомтууд, нисэх онгоцны буудал, цахилгаан станцуудаа барьж байгуулсан. Харин 1980 оноос эхлэн тайваньчууд боловсролын салбарт ихээхэн анхаарал хандуулсан байна. Өмнөд Солонгостой адил тайваньчууд технологийн салбарт нэртэй бөгөөд өнөөдөр дэлхийн нийт компьютерийн 30 хувийг уг оронд үйлдвэрлэж байна.

Бурхнаас Сингапурт өгсөн бэлэг

Малайзын хойгийн өмнөд хэсэгт байрлах Сингапур улс нь газар нутгийн хэмжээгээр дэлхийд сүүлээсээ гуравт ордог бөгөөд улс гэхээсээ илүүгээр хот улс юм. Дэлхийн хоёрдугаар дайны үеэр Японд эзлэгдэхээсээ өмнө Британийн Эзэнт улсын мэдэлд байсан бөгөөд 1965 онд тусгаар улс болсон. Тусгаар

http://www.mongolianeconomy.mn

тогтнолоо олснооcоо хойш Сингапур гадаадын шууд хөрөнгө оруулалтын ачаар эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн үр шимийг амсаж эхэлсэн юм. Сингапурын энэхүү амжилт нь газар нутгийн байршлаас шууд хамааралтай. Өөрөөр хэлбэл, Япон руу явж байгаа бүхий л хөлөг онгоц тус улсаар дайрч явдаг. Мөн Япон, Солонгосоос Европ руу явахдаа Сингапураар дайрч гарна. Газар нутгийн ийм байрлал Сингапурыг гадаад худалдааны томоохон төв болгосон аж. Ийм давуу талаа сингапурчууд 1970-аад оноос ашиглаж эхэлж гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг дэд бүтэц, тэр дундаа далайн боомтдоо түлхүү зарцуулжээ. Харин далайн боомтоос олсон хөрөнгөө боловсролын салбарт зарцуулж, компьютер, инженерийн салбарт амжилт олох боловсон хүчнийг бэлтгэсэн билээ. Үүний дараагаас Сингапурт бас нэгэн орлогын эх үүсвэр нэмэгдсэн нь өөрсдийн үйлдвэрлэсэн компьютерийн эд анги, биотехнологийн тоног төхөөрөмж байв.

Өнөөдрийн байдлаар Сингапур нь нэг хүнд ногдох ДНБ-ийхээ хэмжээгээр дэлхийд есдүгээр байранд орж Азидаа хамгийн олон жуулчныг татдаг улс болон хөгжжээ.

Өрнө, Дорнын уулзах цэг

Азийн дөрөв дэх бөгөөд сүүлийн бар болох Хонконг нь долоон сая хүн амтай. Хэдийгээр БНХАУ-ын нэгээхэн хэсэг хэмээн тооцогддог ч 100 жил барууны үзэл сурталд хүмүүжиж, хөрөнгөтний үзэлтэй учир Азийн хөршүүдээсээ илүү барууны уламжлал тус улсад давамгайлдаг. Энэ улсын орчин үеийн түүх нь 1839 оноос үүдэлтэй. Их Британийн тэнгисийн цэргийн хүчин мансууруулах бодис худалдаалах эрхийн төлөө Хятадтай дайтсан бөгөөд энэ дайнд тухайн үед Тэнгисийг чичрээж байсан Их Британийн хүчин ялсан. Дайны үр дүнд Хятадын Засгийн газар Номхон далайд гарах гарц болох Хонконгийг түрээслэх /колончлох/-ийг Их Британид зөвшөөрчээ. Их Британи 100 жилийн турш Хонконгийг түрээслэж Европ, Хятадыг холбосон чухал газар болгосон аж. 1900 оны байдлаар тус улс дэлхийд дөрөвт орох далайн боомттой болсон бөгөөд Хятад, Европоос ихээхэн хөрөнгө оруулалтыг татсан байна. Энэ бол Хонконгд орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын эхний давалгаа байсан юм. Харин хоёр дахь нь 1940-өөд оноос эхэлжээ. Тэр үед Хятадын Коммунист нам иргэний дайнд ялж эхэлсэн бөгөөд маш олон хувийн бизнес эрхлэгч газрын Хятадаас Хонконг руу дүрвэн гарах болсон байна. Засгийн газрын дарамт шахалтгүй, хувийн өмчийг зөвшөөрдөг бизнесийн тааламжтай орчин нь Хонконгд ирж бизнес эрхлэх их мөнгөний урсгалыг авчирчээ. Энэ их мөнгөний урсгал нь 1960 он гэхэд Хонконгийг Азидаа үйлдвэржилтээр өрсөлдөгчгүй болгох боломжийг олгосон.

Улс орон баян болохын хэрээр ард түмэн нь баяждаг. Иймээс тус улсын ирээдүй хойч үе хүүхдүүд гадаадын өндөр хөгжилтэй оронд өндөр боловсрол эзэмших боломжтой болсон бөгөөд тун удалгүй ажиллах хүчний чадамжаараа дэлхийд дээгүүр орох болжээ. 1990 оны үед Хонконг нь амьдралын өндөр өртгөөрөө Азидаа хамгийн өндөрт тооцогдож эхэлсэн юм.

Судлаачид Хонконгийн амжилт нь чөлөөт худалдааг ихээхэн дэмжсэнд оршино хэмээн үздэг. Хэдийгээр өнөөдөр тус улс Их Британийн колони байхаа больсон ч Их газрын Хятадаас ихээхэн ялгаатай орон билээ. ■

www.mongolianeconomy.mn